

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

2014 ОНЫ 4 САР . №08 (066)

ЭДИЙН ЗАСАГ
ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАНЫ АЛДАА,
ОНОО

УУЛ УУРХАЙ
СОНГОЛТГҮЙ СОНГОЛТ

НОГООН ЭДИЙН ЗАСАГ
ХУВЬСГАЛЫН ТОХИРОО

WWW.MONGOLIANECONOMY.MN

ЗАСГИЙН ГАЗАР
ПРОДАКШН

ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ БАЙДАЛ

ҮЗҮҮЛЖ БАЙНА

ХАМТРАН ТОГЛОГЧИД

ЗАСГИЙН ГАЗАР | ОЮУТОЛГОЙ | ТӨГРӨГ
ТАВАНТОЛГОЙ | БОНД | ЭЛБЭГДОРЖ
АЛТАНХУЯГ | ЗОЛЖАРГАЛ



8165800016794166

VERTUL

OFFICE FURNITURE
ART GALLERY



Италийн алдарт DOIMO группийн албан тасалгааны тавилгыг албан ёсны эрхтэйгээр нийлүүлж байна.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их сургуулийн гудамж, 31/1, PC MALL
Утас: 7711-3535, 9903-7487





RECLAM6S.MN

Гарч хайснаас гараасаа хай...

Та reclam6s.mn сайтад бараа бүтээгдэхүүнээ реклам, видео зар сурталчилгаатай нь хамгийн хямд үнээр байршуулах боломжтой.


Таны худалдаа үйлчилгээг бид түгээнэ.



ВЭБ, МОБАЙЛ ВЭБ БОЛОН APPLICATION

3

ХОСОЛСОН ҮЙЛЧИЛГЭЭ



91116586, 96606586

Бид хамтран ажиллахдаа таатай байх болно.



Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын сэтгүүлдийн эвлэлийн
“2013 оны Шилдэг сэтгүүл”

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр / 9999-4248

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал / 8800-6228

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Теренс Эдвардс

ЗӨВЛӨХ МЭРГЭЖИЛТЭН:

Лиззи Хүү

ОРЧУУЛАГЧ:

Р.Гантулга

ВЭБ РЕДАКТОР:

Б.Энхцэцэг

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Э.Зоригт

Б.Үүрийнтуяа

С.Батзаяа

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

ВЭБ МАСТЕР:

Н.Гал

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Барянжав / 9409-2904

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

М.Хишигтогтох / 9409-2906

“ECONOMY” ТВ СТУДИ

СЭТГҮҮЛЧ:

Ц.Соёлмаа

ЗУРАГЛААЧ:

Ш.Гантуул

КОМПЬЮТЕР ГРАФИКЧ:

Т.Баярсайхан

ХАЯГ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг.

VI хороо, Их сургуулийн гудамж.

AV center. 503 тоот

15160 Улаанбаатар,

Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

Утас/Факс: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

www.ubprint.mn



РЕДАКЦИД
ЗАХИАЛБАЛ
ХҮРГЭЛТ
ҮНЭГҮЙ

MONGOLIAN ECONOMY
ОНЛАЙН СЭТГҮҮЛ
mongolianeconomy.imedia.mn

АГУУЛГА

ЭДИЙН ЗАСАГ

- 8 Хямралтай Монгол
- 10 Бодит байдал ийм байна
- 14 Эдийн засгийн төлөв ямар байна вэ
- 16 Чуулганы алдаа, оноо
- 21 Эрдэс баялгийн удирдлагатай байх нь буруудах зам биш
- 24 Ухаанаа ухаж идэх мөрөөдөл
- 26 С.Бэхбат: Концесст хувийн хэвшлийн туршлагаас илүү менежмент чухал
- 28 “Самурай” бондын эрсдэл & боломж
- 32 Ц.Дашцэрэн: Хөгжлийн хоёр дахь шатанд олон барилга сүндэрлэнэ
- 38 Эрчимжсэн аж ахуйг хөгжимжүүлэх төсөл
- 40 “Танай багшийн цалинг татвараас өгдөг...”
- 44 Захын тэнцвэр: илүүдэл ба хомсдол, хэрэглэгчийн болон үйлдвэрлэгчийн хожоо
- 46 Амин дэм
- 48 Сонголтгүй сонголт
- 49 Хувьсгалын тохироо

“ECONOMY” ТВ СТУДИ

“УХААЛАГ ТӨР” нэвтрүүлэг

Нэвтрүүлэх суваг: NTV телевиз

Нэвтрүүлэх цаг: 2014.04.22-ны 18.50 цаг

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Б.БЯМБАСАЙХАН Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, “Mongolian Economy” сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн

Б.БОЛД “Рио Тинто” компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажиллагаа эрхэлсэн Ерөнхийлөгч

С.БЭХБАТ ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга

Д.ЖАРГАЛСАЙХАН МIН группын ерөнхийлөгч

Ц.БАТСҮХ СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Ж.СҮНЖИДМАА “Пийбоди Энержи” компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер

Б.ТҮВШИНТӨГС Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал



facebook.com/Mongolian.Economy



twitter.com/EconomyMongolia



youtube.com/user/MongolianEconomy

Борлуулах цэгүүд:

“Интер ном”

“Цэцэг төв”

“Минж плаза”

“Алтантүлхүүр” номын дэлгүүр

“Номин” супермаркетийн бүх салбар

“Макс” супермаркетийн бүх салбар

“Фреско” супермаркет

BTSl супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн

“Grand plaza”

“Metro mall”

“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр дэх салбар

“Max mall” салбарууд

МОНГОЛД

БАНК

Валютын ханшийн чангаралтаас эхний ээлжинд ам.долларын зээлтэй иргэд өрийн дарамтад өртсөн бол арилжааны банкуудын хувьд актив, пассив хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байгаа ба энэ нь банкуудыг эрсдэлд учруулж магадгүй хэмжээнд хүрсэн аж. Эх үүсвэрийн хувьд хадгаламж харилцахын тогтворгүй хөдөлгөөн нь банкуудын хөрвөх чадварт нөлөөлж болзошгүй. Ханшийн дарамт ийм өндөр байх үед банкууд ханшийн эрсдэлээс өөрийгөө бүрэн хамгаалах боломж шавхагдаж байгаа нь ханш тэгшитгэлийн алдагдалд хүргэх ба богино хугацаанд ханшийн дарамтыг бууруулахгүй бол алдагдал нь банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээнд нөлөөлж болзошгүй анхаарах хэрэгтэйг шинжээчид анхааруулж байна.

КОНЦЕСС

Хаягдал ус цэвэршүүлэх замаар эрчим хүч үйлдвэрлэх төслийг эхлүүлэхээр болжээ. Уг ажлыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор “Туул Сонгино усны нөөцийн цогцолбор” төслийн концессийн гэрээг Эдийн засгийн хөгжлийн яам болон “Морьт импэкс” компани байгуулжээ. Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжаас хаягдаж байгаа бохир усанд дахин

гүн цэвэршүүлэлт хийх 200 мянган шоо метр бохир ус цэвэршүүлэх хүчин чадал бүхий үйлдвэр барих юм байна. Одоогийн байдлаар Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж нь нийслэлээс гарч буй бохир усны дөнгөж 30 хувийг цэвэршүүлж байгаа бол дээрх үйлдвэр ашиглалтад орсноор хаягдал усыг 90 хүртэл хувиар гүн цэвэршүүлэх боломжтой болох аж.

ТӨМӨР ЗАМ

“Шинэ төмөр зам” төслийн хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг Ухаахудагаас Ханбогд сумын нутаг дахь Гашуунсухайтын хилийн боомт хүртэл 217.9 км төмөр зам баригдах ёстой. “Шинэ төмөр зам” төслийн зам барилгын ажлын гүйцэтгэгчээр БНСУ-ын “Самсунг Си энд Ти” ХХК, туслан гүйцэтгэгчээр Монголын зам барилгын 13 компани ажиллаж байгаа. Тэгвэл төмөр зам барих хүрээнд өнөө жилийн газар шорооны ажил өнгөрсөн долоо хоногт эхэлсэн байна. Одоогийн байдлаар газар шорооны ажил 70 хувьтай, үндсэн хийж гүйцэтгэх ёстой ажил 30 хувийн гүйцэтгэлтэй яваа аж.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

Өнгөрсөн оны аравдугаар сарын 25-нд Mongolian Mining Corporation, “Эрдэнэс тавантолгой”, “Тавантолгой”, Хятадын “Шинхуа” компаниуд Монголын нүүрсийг

Хятад руу нийлүүлэх, цаашилбал дэлхийн зах зээлд гаргаж худалдахад хамтран ажиллахаар болж, санамж бичиг байгуулсан. Энэ хүрээнд “Монгол ба Хятадын хилийн боомт Гашуунсухайт - Хятадын Ганцмод”-ны боомтыг холбох төмөр замын ажлыг хийхээр талууд гэрээ байгууллаа. Гэрээг хэрэгжүүлэхийн тулд хоёр талын хамтын хөрөнгө оруулалттай компани байгуулж байгаа аж. Уг төмөр зам баригдсанаар одоогийн нүүрсний тээвэрлэлтийн зардал тонн тутамд найман ам.доллараас хоёр ам.доллар хүртэл буурах боломжтой гэж “Эрдэнэс Тавантолгой”-н гүйцэтгэх захирал Я.Батсуурь хэлжээ. Мөн тээвэрлэлтийн хүчин чадал 25-30 сая тн болж өсөх аж. “Шинэ төмөр зам” баригдсанаар жилд 25-30 сая тонн нүүрс тээвэрлэх тооцоо гаргажээ.

ҮЙЛДВЭРЖИЛ

“Техник импорт” компанийнхан Японтой хамтран “MJ Partners” компанийг байгуулж, цагаан будаа дотооддоо үйлдвэрлэж эхэлсэн байна. Тус компанийнхан “Sun rise” буюу “Нарны будаа” нэртэй цагаан будааг Монголын хэрэглэгчдэд хүргэж эхэлжээ. Одоогоор цагаан будааг тариа хэлбэрээр оруулж ирээд Монголд эцсийн бүтээгдэхүүн болгон хэрэглэгчдийн гарт хүргэж байгаа аж.

АЛТ

Алтны худалдаанд ил тод байдлыг бүрдүүлэх тухай хууль батлагдсанаар Монголбанкинд тушаах алтны хэмжээ өнгөрсөн гуравдугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 2.6 дахин буюу 1.3 тонноор өссөн байна. Монголын Алт үйлдвэрлэгчдийн холбооны тайлбарлаж буйгаар алтны шинэ хуулийн үр дүнд 2016 он гэхэд Оюутолгой, “Бороо гоулд”-ын уурхайг оруулахгүйгээр зөвхөн үндэсний алт олборлогчид Монголбанкинд тушаах алтны хэмжээ 36 тонн хүртлээ өсч, олборлолт болоод худалдаа ил болж, хар зах зээлийг бүрэн хаах боломжтой аж.

НҮҮРС

Манай улс өнгөрсөн онд 34 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөсөн ч 18 сая тонныг л экспортолсон. Энэ онд ч мөн 31.4 сая тонн нүүрс экспортлох зорилт тавьсан. Гэвч одоогийн байдлаар 3.6 сая тонныг борлуулжээ. Энэ нь 45 сая ам.доллартай тэнцэж байгаа юм байна. Үүнийг 2012 онтой харьцуулбал тав дахин унасан үзүүлэлт бөгөөд төсөвт нүүрсний үнийг чанараас хамааруулан тонн тутамд нь 81-115 ам.доллар байхаар тооцсон байгаа. Мөн “Эрдэнэс-Тавантолгой” компани 31.4 сая тонн нүүрсний 11 саяыг дангаар гаргана гэж тооцсон. Гэхдээ одоогийн байдлаар “Чалко” компанийн өрөнд нүүрс нийлүүлж байгаа бөгөөд ирэх зургадугаар сарын 1-н гэхэд бүх өрөө барагдуулж дуусахаар төлөвлөжээ.

ДЭЛХИЙ ДАХИНД

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ-ын сангийн сайд Жекоб Лью эдийн засгаа аврахад нь Украйнд туслахыг бусад оронд уриалсан байна. Тэрбээр ОУВС-д хэлсэн үгэндээ Украйны “санхүүгийн ихээхэн хэрэгцээ” гэдэг нь нэг тэрбум ам.долларын зээлийн батлан даалтад бусад орон нэмэрлэх ёстой гэсэн үг гэжээ. Дээрх уриалга Украйны түр Ерөнхий сайд зүүн бүс нутгууд руу илүү их эрх мэдэл шилжүүлэхийг санал болгосны дараа гарсан байна. Украйн дахь ОХУ-ыг дэмжигч, салан тусгаарлагчид Засгийн газраа үл ойшоож байгаа аж.

ЕВРОБҮС

Хэрвээ евробүсийн гишүүн орнуудад инфляци өсөхгүй бол эдийн засгийг нь дэмжих арга хэмжээгээ цаашид үргэлжлүүлнэ гэж Европын Төвбанк мэдэгджээ. Тус банкны ерөнхийлөгч Марио Драги еврогийн ханш чанга байгаа нь мөнгөний бодлогыг сулруулах талтай гэв. Уг бүсийн инфляци аюултай түвшинд буюу 0.5 хувьтай байгаа шалтгаануудын нэг нь еврогийн ханшийн өсөлт аж. Цаашид эдийн засгийг дэмжих сонголтуудын нэг нь уламжлалт бус мөнгөний бодлого (quantitative easing) байж болох. ОУВС-гаас үүнийг санал болгож буй. Учир нь дефляци нүүрлэх вий гэсэн санаа зовнил нэмэгдэж буй.

БНХАУ

БНХАУ-ын консорциум Glencore Xstrata-гийн

Перу улс дахь зэсийн уурхайг зургаан тэрбум ам.доллараар худалдан авахаар болжээ. Энэ нь Хятадын уул уурхайн салбар дахь хамгийн том худалдан авалт болох юм. Консорциумд Citic Metal орсон бөгөөд MMG Limited тэргүүлж байгаа аж. Худалдан авалтын журмыг удахгүй батлах бөгөөд талууд ирэх есдүгээр сард худалдан авалтын ажлыг дуусгахаар болжээ. Glencore өрөө багасгахын тулд дээрх мөнгийг ашиглах байх хэмээн шинжээчид таамаглаж буй. Эхний таван жилд уг уурхайгаас жилдээ 450,000 тонн зэс үйлдвэрлэх төлөвлөгөөтэй аж.

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Киевт санхүүгийн туслалцаа үзүүлэх олон улсын түншүүдтэй хамтран ажиллахад Москва бэлэн байгаа талаар Оросын Сангийн сайд Антон Силуанов мэдэгдэв. Энэ талаар Ройтерс агентлаг мэдээлжээ. Тэрбээр “ОУВС болон Европын холбоотой хамтран Украйнд туслах ажилд оролцоход ОХУ бэлэн” гэжээ. Мөн Украйнд нийлүүлсэн байгалийн хийн өр төлөгдөөгүй байгаад Оросын тал санаа зовниж буй талаар АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жэк Льюд хэлсэн байна.

УКРАЙН БА КРЫМ


Крымд Украйны бүх банк үйл ажиллагаагаа зогсоож магадгүй хэмээн Крымын Ерөнхий сайдын орлогч Рустам Темиргалиев мэдэгдэв.


Тэрбээр “Украйны банкууд хаалга барих болсон. Одоогоор дөрөвхөн банк ажиллаж байгаа боловч удахгүй хаалга барих байх” гэснийг Итар-Тасс агентлаг мэдээлжээ. Тус улсын эрх баригчид Оросын банкны сүлжээг Крымд ихээр оруулж буй. Одоогоор 88 салбар байгаа бөгөөд ойрын үед 250 хүргэж нэмэгдүүлэхээр төлөвлөжээ.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА

Уур амьсгалын өөрчлөлтийг хэрхэн зогсоох талаарх тайлангаа НҮБ Берлин

хотноо гаргажээ. Уг тайланд дэлхийн улс, орнууд нүүрсхүчлийн хий ихээр ялгаруулдаг түлшний хэрэглээгээ ойрын үед зогсоох шаардлагатай. Сэргээгдэх эрчим хүч рүү шилжин орох ёстой гэжээ. Эрдэмтэд болон улс орны төрийн албаны хүмүүс долоо хоногийн турш яриа, хэлэлцээр хийсний дараа ийнхүү тайлангаа эцсийн байдлаар гаргасан байна. Эрчим хүчний үйлдвэрлэлийг газрын тос, нүүрснээс ангижруулах гол гүүр бол байгалийн хий болохыг уг тайланд дурджээ. ■





ОНЦЛОХ

ХЯМРАЛТАЙ МОНГОЛ

С.БАТЗАЯА

Ард түмний амьдрал доройтож, эдийн засаг элгээрээ мөлхөж байгаа талаар амтай болгон ярьж байна. Ингэж дүгнэх шалтгааныг эрх баригчид бий болгожээ. Засгийн газар өнгөрсөн онд ДНБ-ий 80 орчим хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө зарцуулж. Тухайлбал, улсын нэгдсэн төсвийн 6.177 их наяд төгрөг, төсвийн гадуурх “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийн гурван их наяд төгрөг, “Чингис” бондын 1.5 тэрбум орчим, Хөгжлийн банкны 580 сая ам.доллар зэрэг нийт 13 гаруй их наяд төгрөгийг ашиглажээ. Тэгсэн хэр нь эдийн

засгийн өсөлт дөнгөж 11.7 хувьтай гарсан нь чамлалттай хэмээн эдийн засагчид болон сөрөг хүчний төлөөлөл шүүмжилж буй. Нөгөөтэйгүүр эдийн засгийн өсөлт хэдий хоёр оронтой тоогоо хадгалсан ч төгрөгийн ханш 25-30 хувиар суларсан нь өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ мөн хэмжээгээр өсөж, ард иргэдийн нуруун дээр хүнд ачаа боллоо. Тиймээс Монголын эдийн засгийг одоогийн хүнд нөхцөлөөс хэрхэн аврах, эсвэл хямрал улам бүр шаварт шигдсээр байх уу гэдэгт “Mongolian Economy” сэтгүүл энэ дугаарын гол агуулгаа чиглүүллээ.

Хоёр жил орчмын өмнөөс уруудаж эхэлсэн эдийн засгийн байдлыг улстөрчид “Болж, бүтэж байна” гэсэн сайхан үг, хуурамч өнгөөр далдалсаар бодит байдлыг улам хүндрүүлэв. Тиймээс бид нөхцөл байдал ямар байгааг сэтгүүлийнхээ энэ удаагийн дугаарт олон талаас нь хөндөж байна.

Нийслэлийн томоохон зах, худалдааны төвд байдал ямар буйг сурвалжиллаа. УИХ дахь сөрөг хүчнийхэн эдийн засагт улаан гэрэл сүүлийн үед ассаныг өдөр бүр сануулж байна. Тэд эдийн засагт үүсээд буй хохирлыг тоо баримттай дэлгэн тавьж, “Давхар дээл”-ийг тайлах ▶

► хуулийн төслийг хэлэлцэн баталж, цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлага байгааг удаа дараа ярьж буй нь тун догь. Мөн удтал дуугүй байсан Засгийн газрын тэргүүн, Сангийн сайд гээд холбогдох албаныхан бодит байдал амаргүй байгааг хүлээн зөвшөөрснөө шил шилээ даран мэдэгдлээ. Хэлэхээс өөр аргагүй нөхцөл байдал үүссэн учраас тэр.

Түүнчлэн ОУВС, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкны холбогдох тайлан судалгаанууд ч гараад байна. Монголын эдийн засгийн төлөв байдал ойрын ирээдүйд ямар байхыг эндээс харж болохоор. Ерөнхий сайд Н.Алтанхуяг саяхан сэтгүүлчдэд мэдээлэл хийх үеэрээ “Дэлхийн эдийн засаг манайхаас ч муу байна” гэж хэлснийг дээрх судалгаануудтай харьцуулахад нэлээд ялгаатай байна. Энэ тухай манай сэтгүүл тусгайлан шинэ мэдээлэл бэлтгэснийг сонирхоорой.

Экспортын орлого, гадаадын хөрөнгө оруулалт багассан, эдийн засагтайгаа уялдаагүй хөрөнгө оруулалт /мөнгөний нийлүүлэлт/ зэрэг нь төгрөгийн ханш сулрах гол шалтгаан болсон гэж эдийн засагч, судлаачид үзэж байна. Үүнийг энэ оны хоёрдугаар сарын байдлаар хугацаа хэтэрсэн банкны зээлийн хэмжээ харууллаа. Өөрөөр хэлбэл, хугацаа хэтэрсэн зээл 198.8, чанаргүй зээл 598 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 79.3 болон 95.5 хувиар өссөн аж. Энэ нь банкны системийн эрсдэл хэр өндөр болсныг харуулж байна.

Засгийн газрын гадаад өр жил гаруйн хугацаанд 2.8 тэрбум ам.доллараар нэмэгдсэн. Тэгсэн хэр нь гадаад валютын цэвэр албан нөөц буурсаар иржээ.

Тендер авах компани олдохгүй байна

Эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэлтэй компаниуд зардлаа бууруулахын тулд ажлын байрны цомхотгол хийхээс өөр аргагүйд хүрчээ. Жилийн өмнөөс дуулдсан энэ таагүй мэдээ өдгөө уул уурхайн салбараас хэдийнэ хальж, холбоо харилцаа, үйлдвэрлэл, барилгын компанийг ч хамрах болж. Эдийн засаг хямарсныг ганцхан жилийн дотор 4000 орчим аж ахуйн нэгж хаалгаа

барьснаас харж болох. Үндэсний статистикийн хорооны өнгөрсөн оны эцэст гаргасан тайланд хоёр жилийн өмнө 2878 аж ахуйн нэгж хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан бол өнгөрсөн онд 839, уул уурхайн салбарын 470 аж ахуйн нэгж 70, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 4492 аж ахуйн нэгж 926 болж тус тус буурчээ. Жилийн дотор дээрх салбаруудын аж ахуйн нэгжийн тоо 2000-3000 гаруйгаар хумигдсан нь бизнесийн байгууллагууд хямралд хиар цохиулсныг илтгэх.

Даарин дээр давс нэмсэн бас нэгэн үзүүлэлт бол манай улсын зээлжих зэрэглэл +В-гээс хасах В рүү ороод байгааг Олон улсын валютын сангаас мэдэгдсэн явдал. Түүнчлэн валютын ханшийн огцом өсөлтөөс үүдэж валютаар зээл авсан аж ахуйн нэгжүүд 573 тэрбум төгрөгийн ханш тэгшитгэлийн алдагдал хүлээсэн аж. Үүнээс үүдэж валютын чанаргүй зээл 87-гоос 222 тэрбум төгрөг болж 2.6 дахин нэмэгдсэн байна. Төгрөгийн ханш суларсан нь хувийн хэвшлийнхэнд ийн хүндээр туслаа. Бусад улсын банк өөрийн улсын мөнгөн тэмдэгтээс өөр орны мөнгөн тэмдэгтээр зээл авахыг хуулиар хориглосон байдаг аж. Гэтэл манайд байдал эсрэгээрээ байгаа нь өнөөдрийн эрсдэлийг авчирлаа.

Бүтээн байгуулалтын улирал хэдийнэ эхэлчихээд байхад тендер шалгаруулалтад оролцох компани далайгаас сувд шүүрэх адил ховордоод байна. Энэ нь улсын төсөвт ам.долларын төгрөгтэй харьцах ханшийг 1384 байхаар тооцож, Засгийн газар барилга байшин, замын тендерээ зарласнаас үүдэлтэй аж. Одоогийн байдлаар нэг ам.доллар 1780 төгрөгтэй тэнцэж байна. Компаниуд тендер шалгаруулалтад оролцох гэхээр ам.долларын ханшийн зөрүү их хэмжээгээр мэдрэгдэх учраас болгоомжилж буйгаа нэрээ нууцлахыг хүссэн компанийн захирал хэлсэн. Учир нь, ил тодоор байдал ийм, тийм байна гээд зарлачихвал бизнесийн үйл ажиллагаанд нь халдах, янз бүрийн шалгалт оруулж, дарамталдаг гэнэ. Энэ талаар тэрбээр “Төсвийн хөрөнгө оруулалтаар хийх ажлын жагсаалтын ихэнх нь зам, байшин барилга барих байдаг. Манай улс барилгын

материалын ихэнхийг импортоор авч байна. Нэг ам.долларын ханшийг төсөвт 1384 төгрөгөөр тооцсон нь одоо байгаа ханшаас 30 орчим хувийн зөрүүтэй байгаа. Аж ахуйн нэгжүүд ийм хэмжээний ашиг харж ажилладаг. Тэгэхээр өөрт ашиггүй ажил руу орохыг хэн ч хүсэхгүй” гэв.

Тухайлбал, өнгөрсөн жил өөрийн хөрөнгөөр барилгын ажил хийж гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн зарим нь өнөөг хүртэл улсаас мөнгөө гаргуулж авч чадаагүй аж. Нэгдүгээр сарын сүүлээр Төсвийн байнгын хороо хуралдаж, 300 аж ахуйн нэгжийн 183 тэрбум төгрөгийг төсвийн тодотголд суулгаж олгохоор болсон. Гэтэл тодотгол хийлгүй дөрөвдүгээр сартай золголоо. Энэ мэт шалтгаанаас болоод төрд итгэх хувийн хэвшлийнхний итгэл алдарч байгааг дээрх нэрээ нууцлахыг хүссэн бизнесмэн өгүүлсэн.

Төртэй өрсөлдөх хувийн компани ховордлоо

2014 оны төсвийг эрх баригчид “авлигажсан” төсөв хэмээж 243 барилга объектын санхүүжилтийг царцааж, аудитын байгууллагаар шалгуулахаар болсон. Харин энэ сарын 1-н гэхэд Засгийн газар ямар объектуудад санхүүжилт өгөх эсэхээ шийдэх байсан ч өнөөг хүртэл шийдээгүй байна. Түүнчлэн энэ оны төсөвт хөрөнгө оруулалтын зардлыг 1.1 их наяд төгрөг байхаар төсөвлөвөд буй. Өнгөрсөн сарын 31-ний байдлаар хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэл 7.2 хувьтай гарсныг Сангийн яамнаас мэдэгдсэн. Бүхэл бүтэн нэг улирал өнгөрөөд байхад хамгийн багадаа 20 хувьтай байх ёстой уг үзүүлэлт ийм хангалтгүй хэмжээнд байна. Мөн хоёрдугаар сард хийх ёстой санхүүжилтийн нийт гүйцэтгэлийн 57 хувийг л ашиглаж. Өөрөөр хэлбэл, засаг хийх ёстой санхүүжилтээ цаг тухайд нь хийхгүй байна гэсэн үг. Татварын орлого хоёрдугаар сарын гүйцэтгэлээр 23 хувиар тасалдсан байна.

“Төр хувийн хэвшил рүү хэт их орж байна. Төртэй өрсөлдөх хувийн компани ховордлоо. Өнгөрсөн жил ТОСК /Төрийн орон сууцны корпораци/ байгуулсан. Төр өөрийн компанидаа газар болон барилга барих эрхийг ►

► үнэгүй өгнө. Харин хувийн компаниуд газраа худалдаж аваад банкнаас зээл авч, барилгаа барина. Ингэхээр сэргэж байсан барилгын салбар буцаад уналтад орох нь. Үүн дээр ханшийн тогтворгүй байдал бизнес төлөвлөхөд хүндрэлтэй болгож байна. Тиймээс ам.долларын ханшийг тогтворжтол бизнесээ эхлүүлэхгүй хүлээхээр шийдсэн. Татварын дарамт, ханшийн зөрүү амсч, бизнесээ хохироож байснаас нэг жил ажилгүй өнжсөн нь хамаагүй дээр” хэмээн орон нутагт тендрээр ажил гүйцэтгэдэг компанийн төлөөлөл хэллээ.

ҮСХ-ноос гаргасан тайланд 2012 оны эцэст Монгол Улсын валютын нөөц 3.6 тэрбум ам.доллар байсан бол өнгөрсөн оны сүүлээр 1.193 тэрбум ам.доллар болсон гэж дурджээ. Өөрөөр хэлбэл, жилийн дотор 2.4 тэрбум буюу 67.1 хувиар гадаад валютын нөөц буурсан байна. Одоо байгаа нөөц бүгд улсынх уу гэдэг нь мөн л эргэлзээтэй аж. Учир нь, аж ахуйн нэгжийн дансны үлдэгдэл болон иргэдийн валютын хадгаламж арилжааны банкинд бий. Харин Монголбанк одоогоор 2.4 тэрбум ам.долларын нөөцтэй гэдгээ мэдэгдээд байгаа. Үндэсний статистикийн хороо болон Монголбанкнаас гаргаж буй валютын нөөцийн хэмжээ алд дэлэм зөрж байна. Иргэдийг төөрөгдүүлсэн энэ тоонуудын алинд нь итгэх вэ. Дээрээс нь импортлогч нарыг татвараар дарамтлах болжээ. Төсвийн орлого тасалдаж, экспорт буурснаас импортлогчдыг дарамтлах “моод” дэлгэрээд буй гэхэд хилсдэхгүй.

Эдийн засгийн өсөлтөө хадгалахад онцгой анхаарна

УИХ-ын хаврын чуулган энэ сарын 7-нд нээлтээ хийлээ. Хаврын чуулганаар хэлэлцэж, батлах хууль, бодлогын баримт бичиг олон ч нүдээ олсон зөв шийдвэр гаргаж, хямралтай Монголын эдийн засгийг сэргээх нь чухал болоод байна. Чуулганы хугацаанд Газрын тосны тухай, Ашигт малтмалын тухай зэрэг хуулийг батална. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар олон жил царцсан хайгуулын тусгай

зөвшөөрлийг зөвхөн зөвшөөрөгдсөн газарт олгох. Түүнчлэн хариуцлагатай уул уурхайн зарчмууд шинээр орсноор байгаль орчны нөхөн сэргээлт шинэ шатанд гарна хэмээн хууль тогтоох байгууллагынхан үзэж байна.

УИХ-ын дарга З.Энхболд “Бидэнд эдийн засгийн хоёр оронтой тоон өсөлтөө тогтворжуулах, эрчээ алдахгүй байх бодлого чухал байна. Их бүтээн байгуулалтыг идэвхижүүлэх, эдийн засгийн бодит секторыг дэмжих эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох хэрэгтэй байгаа. “Чингис” боңдыг анх авахад боловсруулагдсан Өрийн удирдлагын тухай хуулийг Засгийн газар нэн даруй оруулж ирэхгүй бол энэ талаар санаа зовж буй УИХ-ын гишүүдийн өргөн барих хуулийг хэлэлцэн баталж, томоохон бүтээн байгуулалт, хөгжлийн зээлүүдийг цаг алдалгүй эргэлтэд оруулж, гацааг арилгана” гэв. Мөн чуулганаар өргөн баригдсан Нэмүү өртгийн албан татварын босгын тухай

хуулийг хэлэлцэнэ. Ингэхдээ уул уурхайн салбартай холбож 25 хувиар өндөр тогтоосон аж ахуйн нэгжийн орлогын татварын одоогийн хоёр шатлалын хувь хэмжээг бизнесийн бусад салбарын ачааллыг бууруулах зорилгоор дахин авч үзэх аж.

Хямралтай холбоотойгоор Засгийн газарт хариуцлага тооцох асуудал ч улс төрийн хүрээнд хөндөгдөж эхэллээ. “Энэ Засгийн газрыг унагаахгүй зүтгүүлээд үзэх хэрэгтэй. Дараагийн гарч ирэх гүйцэтгэх засаглал одоогийнхоос дээрдэхгүй, дахиад л бүх зүйлийг шинээр эхэлнэ гэсэн үзэл бодол, байр суурь иргэд, олон нийтийн дунд ам дамжих болж. Ганцхан жилийн дотор бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 20 хувиар нэмэгдэж, 30 орчим хувьтай байсан ядуурал 40 рүү дөхөж, иргэдийн орлого нэмэгдээгүй гээд тоочих бодит шалтгаан олон. Тиймээс цаг алдалгүй гарц шийдлийг олох нь юу юунаас илүү чухал байна. ■

СУРВАЛЖЛАГА

БОДИТ БАЙДАЛ ИЙМ БАЙНА

С.АЗ

Улс орны эдийн засаг хямраагүй хэмээн эрх баригчид нэг бус удаа мэдэгдэж байсан. Харин амьдрал дээр бүх зүйл 360 градус эргэчихээд байгааг бид алхам тутамдаа мэдэрч байна. Тиймээс манай сэтгүүл энэ удаа бодит байдал ямар байгааг уншигчдадаа хүргэхээр томоохон зах, худалдааны төвүүдээр орж сурвалжлага хийлээ.

“Moody’s” агентлагийн судлаачид Монгол Улс 2014 оны сүүлээр валютын нөөцгүй болно гэсэн анхааруулгыг манайд ирүүлжээ. Цаг алдалгүй валютын нөөцөө хадгалах, ханшаа тогтворжуулах тухай бодлого гаргаж, хэрэгжүүлэхгүй бол дахиад өр зээл тавихаас өөр аргагүй гэдгийг ч сануулсан байна. Тэгэхээр дотоод эдийн засгаа дэмжихийн тулд төрд дарамт учруулахгүйгээр бизнесээ авч яваа хувийн хэшлийнхнээ “шантаажлахгүй” байх нь чухал болоод буйг бидний сурвалжлагаас та харж болно. ►



“Нарантуул” худалдааны төв

тус худалдааны төвийн Хүний нөөцийн менежер П.Отгонбаатар “Манайх улсын хэмжээнд хамгийн бага түрээстэй зах. Наймаачид бараагаа чингэлэгт хадгалдаг. Тэнд өдрийн 1000 төгрөг төлдөг юм билээ. Үүнийгээ түрээс дээрээ нэмээд сард 100-150 мянган төгрөг төлдөг гэж ярьдаг. Харин агуулах, чингэлэгтэй хүмүүс сарын 150-180 мянган төгрөгийн түрээс өгдөг” гэв. Тус худалдааны төвийн өргөтгөлийн хэсгээр орлоо. Хөдөө орон нутаг руу ачаа ачдаг машин энд зогсдог учир хүмүүсийн хөл хөдөлгөөн татардаггүй. Тиймээс орлого ч муугүй байдаг гэнэ. Тус захад хүнсний бүтээгдэхүүн зардаг Х.Хулан “Өдөрт 200 мянгаас орлого буудаггүй. “Нарантуул”-ыг бодвол манай бараа 20-30 төгрөгөөр хямд. Энэ нь ч нөлөөлдөг байж магадгүй” гэсэн.

▶ “Нарантуул”-ын худалдаачдын орлого багасчээ

Түм түжигнэж, бум бужигнаж байдаг “Нарантуул” худалдааны төвд энэ сарын 4-ний 12.00 цагийн үед очиход хүн багатай байв. Өмнө нь хөл хөдөлгөөн дунд бараагаа хулгайд алдчих вий хэмээн нүдээ ирмэх ч чөлөөгүй шахуу ажилладаг байсан худалдагч нар хэд гурваараа бөөгнөрөн хөзөр, даалуу тоглож сууна. Бэлэн хувцас зардаг иргэн Г.Анар “Үйлчлүүлэгч эрс цөөрөөд удаж байна. Цагаан сарын дараа худалдан авагчгүй болдог ч арай ч ийм байдалд орж байгаагүй. Урин дулааны улирал айлчилсан энэ үед зах хөл хөдөлгөөн ихтэй болдог. Юун хөзөр, даалуу тоглох манатай байдаг байсан. Эрээн, Бээжингээс бараагаа татахаас эхлээд бидний ажил мундахгүй байдаг ч энэ жил байдал эсрэгээрээ байна” гэв. Харин худалдагч Ц.Баяндалай “Иргэдийн худалдан авах чадвар муудаж, бараа бүтээгдэхүүний үнэ өдрөөс өдөрт нэмэгдэх боллоо. Бид түрээсээ зарим сард төлж чадахгүй зээл тавьж байна. Орлогогүй боллоо гээд зах дээр зогсохоо болих хэцүү. Цаашид амьдралаа яаж залгуулах билээ гэж бодоход хүрлээ” хэмээн өгүүлсэн. Тэд эдийн засаг сайжирч, валютын ханш тогтворжоосой гэж хүлээж буйгаа ярьсан. Тус худалдааны төвд тэргээр хүмүүсийн ачаа бараа гаргаж амьдралаа залгуулдаг 200 орчим хүн бий. Тэд өдөрт 2000-3000 төгрөгөөр тэрэг түрээсэлдэг гэх. Тэдний орлого ч багасчээ. Жижиг тэрэгтэй хүмүүс өмнө нь өдөрт 15000-20000 төгрөг олдог байсан бол одоо 5000-10000 төгрөгтэй харьж буй аж.

“Нарантуул” худалдааны төв 5000 гаруй түрээслэгчтэй. Сарын түрээс нь 50-70 мянган төгрөг аж. Энэ талаар

Том оврын автомашины жолооч нар ачаа ачих гээд тус захын дотор талд эгнэн зогсчээ. Зарим нь орон нутгаасаа ирээд сар болж буй аж. Өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад ачаа олдох нь хомс болжээ. Нэг кг ачааг замын хол ойроос шалтгаалан 150-350 төгрөгөөр ачдаг юм байна. Завхан аймгийн Их-Уул сумаас ирсэн жолооч н.Мэндбаяр “Нэг кг ачааг 150 төгрөгөөр ачдаг ч нэг тонноос дээш болвол 80-90 төгрөг болдог. Миний машин таван тоннын даацтай ч 10 тонныг ачиж байж ашиг олдог. Жилийн өмнө сардаа хоёр удаа тээвэр хийж байсан. Одоо сард нэг явж байна. Энд тэндээс сураг тавьж, ах дүү, хамаатан садныхаа ачааг ачих боллоо” хэмээлээ. Тус сум нийслэлээс 800 км-ын зайд оршдог. Нэг талдаа 200 гаруй литр шатахуун зарцуулдаг байна. Машины даац хэтэрсэн учраас дугуй хагарах нь энүүхэнд. Нэг дугуй 300 мянган төгрөг. Эндхийн бүх жолооч нар ачаагаа манаж машин дотроо хонодог байна. Нэг дор их хэмжээний ачаа олдохгүй, бага багаар цуглардаг учраас тэр. Мөн жолооч ▶



“Нарантуул” худалдааны төв

► нар нэг асуудлыг хөндөж байсан нь зам. Засгийн газар өнгөрсөн жил улсын хэмжээнд 1000 гаруй км автозам тавьсан хэмээн мэдэгдсэн. Гэтэл тэр замууд нь шар усны үерт идэгдээд энхэл донхолтой машин явахын аргагүй болсон аж. Стандартын бус шороо асгаж, түүнийгээ нэг дан асфальтаар хучиж, индүүдсэн нь нүглийн нүдийг гурилаар хуурсан явдал болжээ.

Наймаачид сайд, дарга нарт үг дайлаа

“Бөмбөгөр” худалдааны төвд дөрөвдүгээр сарын 1-ний 16.00 цагийн үед очиход эл хуль байв. Худалдагч нараас өөр хүн ховор харагдана. Уг нь “Бөмбөгөр” “Нарантуул” худалдааны төвийг бодвол хотын төвд байрладаг учраас хүний хөл татардаггүй. Юанийн ханш өнгөрсөн оны гуравдугаар сард 225 байсан бол одоо 292 төгрөгт хүрээд байна. Энэ нь урд хөршөөс бараа бүтээгдэхүүн татаж, лангуу түрээслэн амьдралаа залгуулдаг иргэдийн худалдаа наймаанд сөргөөр нөлөөлж байгааг бэлэн хувцасны

Эндхийн худалдаа эрхлэгчид хууч хөөрч хаврын урт өдрийг өнгөрөөж байна. Сурвалжлага хийх гэж явааг минь сонсоод төр засгийнханд үгээ дайлаа. Бэлэн хувцас зардаг Т.Оюундэлгэр “Зарим өдөр орлогогүй харих ч үе байдаг. Амьдрал хүнд байна. Бодит байдалтай сайд, дарга нар ирж танилцаж, гарцыг нь эрэлхийлэх ёстой байх. Ам.долларын ханшийг дагаад юань огцом өссөн. Тэд ханшийг бууруулах талаар юу хийж байна вэ. Ард иргэдийн амьдрал, эрх баригчдын хэлж буй хоёр алд дэлэм зөрж байна” гэлээ.

“Хүчит шонхор” зах дээр ч байдал ийм

Нийслэлчүүдийн мах, махан бүтээгдэхүүний бөөний төв болох “Хүчит шонхор” хүнсний захгаар энэ сарын 2-ны 15.00 цагт очлоо. Сонголт сайтай, харьцангуй хямд махтай учраас хотынхон ихэвчлэн тус захыг сонгон үйлчлүүлдэг. Махны үнэд валютын ханш нөлөөлөх учиргүй ч жижиглэнгийн үнэ нь өнгөрсөн сарынхаас кг тутамдаа 1000-2000 төгрөгөөр нэмэгдсэн байв. Үүний шалтгааныг

худалдагчаас тодруулахад “Малчид малаа үнэтэй өгч буй учир махны үнэ өсч байна. Дээрээс нь зүүн аймгуудад шүлхий гарснаас махны олдоц муу байгаа. Хятадууд их хэмжээгээр мах бэлтгэж буй нь ч үнэд нөлөөлөх болсон” хэмээв. Шатахууны үнэ, валютын ханш өссөнөөр өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн гэж тэд үзэж байна. Түүнээс наймаачид үнэ хөөрөгдөөгүй гэдгийг онцолсон.

Гурил, гурилан бүтээгдэхүүний үнийн өсөлтийг дагаад малын тэжээлийн үнэ тэнгэрт тарчээ. Энэ байдал нь мал ид төллөж буй энэ үед малчдыг бухимдуулж байна. Уг нь манайх дотоодынхоо гурилын хэрэгцээг хангах улаанбуудайг өнгөрсөн жил хурааж авсан. Харин ирэх

есдүгээр сар хүртэл гурилын үнийг өсгөхгүйн тулд 100 мянган тонн улаанбуудай импортлохоор болсон. Тэгсэн хэр нь гурил, малын тэжээлийн үнэ нэмэгдээд байгаа нь хачирхалтай. Өнөөдрийн байдлаар нэг уут тэжээл 10000 төгрөгийн үнэтэй байна. Хэдхэн сарын өмнө 5000 төгрөгийн үнэтэй байжээ.

Хятадын гааль Монголын татварыг тогтоох нь зөв үү

“Барс” зах дээр ч байдал ялгаагүй байв. Тус зах нийслэлчүүдийн жимс, жимсгэний хэрэгцээг хангадаг гол газар. Эндхийн худалдаачид ч валютын ханшийн зөрүүнээс болж бизнес эрхлэхэд хүндхэн байгаагаа хэлсэн. Өнгөрсөн жилийн мөн үеийнхээс жимс, жимсгэний үнэ хайрцаг тутамдаа 10000-25000 төгрөгөөр нэмэгджээ. Тухайлбал, өнгөрсөн жил хайрцаг чинжүүг 28 мянган төгрөгөөр зарж байсан бол өдгөө 45-48 мянга болж. Тэр үед юанийг ►



Фотог Б.Бямба-Очир

“Хүчит шонхор” худалдааны төв

тасгийн худалдагч нар ам уралдан ярьцгаав. Тус захын наймаачдын 80 хувь нь 25-45 насныхан аж. Орлого нь хумигдсанд сэтгэл гундуухан худалдагч олон.

Гэр ахуйн бараа зардаг наймаачид жилийн аль ч үед орлоготой байдаг юм байна. Цахилгаан, товч, бахь, цоож, түлхүүр, цавуу, аяга тавагны алчуур, нүүр гарын саван гээд жижиг гэлтгүй хүний хэрэгцээтэй бараа худалддаг учир өдрийн орлого нь дунджаар 150-200 мянган төгрөг байдаг байжээ. Харин одоо 100 мянган төгрөгт хүрэх тохиолдол өдрийн од шиг ховор болсон гэсэн. Аль ч худалдааны төвд гэр ахуйн цахилгаан бараа эрэлттэй байдаг аж. Тухайлбал, ус буцалгагч, индүү, будаа агшаагчны эрэлт буурдаггүй гэнэ. Гэр ахуйн бараа худалдаалдаг Р.Буян “Бид сард хамгийн багадаа хоёр удаа урагшаа явж бараагаа татдаг байсан. Харин одоо сардаа нэг, заримдаа явахгүй ч үе гарч байна. Өдөрт дунджаар 200-250 мянган төгрөгийн орлоготой байдаг байсан бол одоо 30-40 мянгатай бууж байна” гэв.

▶ 225-аар авч байсан бол өнөөдөр 291 төгрөг. Мөн гаалийн татварыг жишиг үнээр авдаг болжээ. Энэ оны хоёрдугаар сараас эхлэн Хятадын гаалийн үнэлсэн бичгээр манайх татвараа тогтоож авч буй аж. Үүнд жимсний худалдаа эрхлэгчид бухимдалтай байна. Манайх бие даасан улс байтал бусад улсыг дуурайж байна. Энэ нь бидэнд дарамт болж буй гэж байв. Урд хөршид жимсний үнэ хэвээр байгаа ч юань үнэд орсон учир хэрэглэгчийн



Фотог Б.Бямба-Очир

“Зуун айл” барилгын материалын зах

гарт ийм өндөр үнээр хүрэхээс өөр аргагүй болсон гэх. Тус захад жимсний бөөний худалдаа эрхлэгч 80 орчим түрээслэгч бий. Тэд агуулах түрээсэлдэг учраас нэг хүн сард доод тал нь 1.6 сая төгрөгийн түрээс төлдөг байна. Худалдаа эрхлэгчид жимсээ вагоноор зөөхөө больжээ. Ихэнх нь зориулалтын хөргүүртэй машинтай гэнэ. Тиймээс тус захад өдөрт дунджаар таван вагон жимс, жимсгэнэ бууж байгаа гэсэн. Нэг вагонд 30-40 тонн жимс ордог бол машин 20 тоннын багтаамжтай. Энэ талаар түрээслэгч Б.Байгалмаа “Гаалийн татвар маш их нэмэгдэж байгаа. Бид гаальд тав, НӨАТ-ын 10 хувийн татвар өгдөг. Жимс жимсгэнийн үнийн нэмэгдэлд 20 хувь нь валютын ханшийн зөрүү, үлдсэн нь гаалийн татвар нөлөөлж байна. Энэ сарын 1-нээс зарим төрлийн жимсний татвар дахиад нэмэгдсэн гэсэн. Экспорт муу байна гээд импортлогчдын татварыг

нэмэгдүүлж, орлогоо нөхөх боллоо. Тэгэхээр бидний оруулж ирж буй барааны үнэ нэмэгдэхээс аргагүй. Ард иргэдийн цалинг нэмээгүй учраас ядуурал бий болж байна” гэв.

Валютын ханш барилгын ажлыг ч чангааж байна

Урин дулаан цаг ирсэн болохоор барилгын материалын борлуулалт сайжирдаг учраас 100 айл дахь барилгын материалын зах хөл хөдөлгөөнд дарагддаг. Биднийг энэ сарын 3-ны 14.00 цагийн үед очиход байдал эсрэгээрээ байв. Валютын ханш өндөр буйгаас барилгын салбарт ажил эхлээгүй байгаа хэмээн худалдаачид хэллээ. Тус захын ихэнх нь банкны зээлтэй аж. Учир нь, барилгын материалын худалдаа эрхлэхэд мөнгө ахиу ордог учраас бизнесээ явуулахын тулд ихэнх нь зээл авчээ. Тэрбүү хэл, ам.долларын зээлтэй түрээслэгч нэлээд бий аж. Тэд 2009 оны эдийн засгийн хямралын үеэр ч ийм хүнд байдалд орж байгаагүйгээ хэлж байна.

Мөн тэд төр, засаг шийдвэр гаргахдаа амьдрал ахуй нь хөндөгдөх иргэн, бизнес эрхлэгчдийн дуу хоолойг сонсохыг хүсч байна. Барилгын гол түүхий эд болох цементийн үнэ өнгөрсөн жилийнхээс уут тутамдаа 2000-4000 төгрөгөөр нэмэгджээ. Өнгөрсөн жил нэг уут цемент 7500-8000 төгрөгийн үнэтэй байсан бол одоо хамгийн багадаа 10000-12000 төгрөг байна. Дотор засал чимэглэлийн материалын үнэ ч тэнгэрт хадчихаж. “Техникийн захад машин зардаг, 100 айлд барилгын материал худалдаалдаг иргэд төрөөс цалин, тэтгэвэр авдаггүй. Бор зүрхээрээ амьдралаа авч яваа. Бидэн шиг төрөөс нэг ч төгрөг гуйхгүйгээр бизнесээ эрхэлж татвар төлж буй иргэд олон бий. Гэтэл төр хянаж шалгах нэрээр хааж боож, татвар хураалт муу байна гээд гааль дээр бүх зүйлийг нэгждэг болсон” хэмээн тус захын наймаачин О.Саран бухимдангуй өгүүлэв.

Борви бохисхийлгүй ажиллаж, худалдаа наймаа эрхлэн амьдралаа залгуулдаг хэсгийнхэн ийм байдалтай байна. Тэд төр засгийн шийдвэр гаргах түвшний хүмүүс газар дээр нь ирж нөхцөл байдалтай танилцаж, яаралтай арга хэмжээ авахыг хүсч байна. ■

Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ /2014.04.10/

Төрөл	Захуудын нэр/үнэ	
	“Хүчит шонхор”	“Бөмбөгөр”
Ургамлын тос	3000-3500	3200-3500
Элсэн чихэр	1600-2000	1800-2000
Цагаан будаа	1800-2000	2000-2200
Гурвалжин будаа	1800-2000	2000-2200
Давс	600-1000	500-800
“Биеэ бодоорой” сүү	2500-2600	2400-2500
“Милко” сүү	2300-2500	2300-2400
“Цэвэр” сүү	2400-2500	2400-2500
“Миний монголын сүү”	2000-2100	2100-2200

Гурил /кг.төгрөг/

Төрөл		Захуудын нэр/үнэ			
		“Хүчит шонхор”		“Бөмбөгөр”	
хэмжээ		12000	20000	12500	20500
Улаанбаатар	дээд	11500	25000	12000	24500
Алтантариа	дээд	8500	18500	9000	19000
	I	5000	9500	5500	10000
	II	11500	26000	11500	25500
“Атар”	дээд	8000	18500	8000	18000
	I	8000	18500	8000	18000

ТАЙЛАН

ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ ЯМАР БАЙНА ВЭ



Б.ЭНХ

Энэ сарын эхээр Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк болон Олон улсын валютын сан дэлхийн болон бүсийн эдийн засгийн тайлангуудаа танилцуулсан. Тэгвэл тэд тайландаа Монголын эдийн засгийн эрүүл мэнд хэрхэх талаар юу гэснийг уншигч Та бүхэнд хүргэе.

Дэлхийн банк

Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн төлөв

Тус тайлан Монголд хоёр том сорилт энэ онд тулгарч буйг онцолжээ.

Өнгөрсөн оны тэлэлттэй эдийн засгийн замналаас үүдэн энэ жил Монголын зорьж буй хоёр оронтой тоон өсөлтөд улс төрийн дарамт ирж

байна. Хөгжлийн банкаар дамжиж буй төсвөөс гадуурх зарлага нь дэд бүтцийн олон төсөл хөтөлбөрүүдийн хөдөлгөгч гол хүч байхаар байгаа. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хяналтаас гарсан зарцуулалт нь бодит төсөвт ДНБ-ий 7-8 хувьтай тэнцэх хэмжээний алдагдал болж нэмэгдэж буй. Энэ жил мөнгөний бодлого сул хэвээр байх хандлагатай байгааг Үнэ тогтворжуулах хөтөлбөр болон, орон сууцжуулах зээлийн хөтөлбөрийн үйл явцаас харж болох.

Гадаадын зээл болон зах зээлд шахах буй Төвбанкны санхүүжилтүүдэд найдсан эдийн засгаа дэмжих арга хэмжээ нь эдийн засгийн тэнцвэргүй байдлыг нэмэгдүүлнэ. Төвбанкны үнийн хяналтаас үүдэн импортын барааны зардал нэмэгдэж буй нөлөөлөл нь жижиглэнгийн худалдаанд шууд бус, хэсэгчлэн тусаж байна. Одоогийн урсгал тэнцэл

болон санхүү/ хөрөнгийн дансанд гараад буй том зай нь гадаад валютын нөөцийн хэмжээ цаашид ч дарамтад байхаар байгааг илтгэж байгаа юм. Одоогийн нөхцөлд эдийн засгийн удирдлага нь төлбөрийн тэнцлийн асуудлыг анхааралдаа авч, хямралд унах эрсдэлийг бууруулах замаар тогтвортой өсөлтийг чиглэсэн байх ёстой. Төлбөрийн тэнцэл, инфляцийн өсөлт мөн гаднын хөрөнгийн урсгалын асуудлыг нэн тэргүүнд анхаарах.

Олон улсын Валютын сан

Дэлхийн эдийн засгийн төлөв

Харин манай улсын ДНБ-ийг ОУВС энэ жил 12.9 хувиар өсөхөөр таамагласан бол ирэх жил 7.7 хувьтай байна гэж үзэж байна. Монгол Улсын хувьд өрийн хурдацтай өсөлтөөс үүдэн томорч буй макро эдийн засгийн тэнцвэргүй байдал мөн төсвийн өндөр алдагдал нь энэ жилийн хувьд ч өндөр эрсдэл хэвээр хадгалагдах шинжтэйг ОУВС тайландаа дурьджээ.

Монгол, Бангладеш, Бутан, Бруней, Камбодж, Лаос, Фижи Кирибати, Малдив, Маршалын арлууд, Микронез, Мьянмар, Непал, Палау, Шинэ Гвиней, Самоа, Соломоны арлууд, Шри Ланк, Тимор Лесте, Тонго, Тувалу болон ▶

Дэлхийн банкны Зүүн Ази Номхон далайн орнуудын эдийн засгийн ээлжит тайлан 2014 оны дөрөвдүгээр сар -Монгол

Он	2013	2014 / таамаг	2015 / таамаг	2016 / таамаг
Бодит ДНБ-ий өсөлт	12.4%	11.7%	9.2%	7.6 %
Ашигт малтмалын ДНБ-ий өсөлт	8.0%	20.7%	13.8%	1.1 %
Хэрэглэгчийн үнийн индекс	14.2%	12.3%	9.9%	8.0 %

Олон улсын валютын сангийн Эдийн засгийн тайлан 2014 оны дөрөвдүгээр сар -Монгол

Он	2014	2015	2016
ДНБ-ий өсөлт	12.9%	7.7%	5.7

Ванауту зэрэг ижил төстэй хөгжиж буй эдийн засагтай орнуудыг хамтатгаж авч үзсэн эдийн засгийн өсөлтийн таамаг энэ жил 6.7 хувь байгаа бол ирэх жил 7.1 хувь байхаар байна.

Дэлхийн худалдааны салбарт ажиглагдаж буй сэргэлт нь Азийн хөгжиж буй орнууд тодорхой хэмжээнд өгөөжөө өгч эдийн засгийн өндөр өсөлтөө хадгалах боломж бүрдэнэ гэж ОУВС үзжээ.

Азийн хөгжлийн банк

Азийн хөгжлийн төлөв- 2014: Хүртээмжтэй өсөлтийн төлөөх төсвийн бодлого

Энэ жил эдийн засгийн өсөлт нэг оронтой тоо руу орохоор байгаа ч Монголын ашигт малтмалын салбараа хөгжүүлэх чадамжаас үүдэн дунд хугацааны төлөв өөдрөг харагдаж байгаа. Тиймээс ирэх оноос өсөлт хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэхээр байна. Өнгөрсөн жилийн зургадугаар сараас Оюутолгой ил уурхайн зэсийн үйлдвэрлэлээ эхлүүлснээс үүдэн энэ жил эдийн засаг 9.5 хувиар өсөхөөр байгаа. Харин уул уурхайн бус салбарын өсөлт эдийн засгийн бодлого чангарахаас үүдэн саарах хүлээлт буй. Дотоодын өндөр эрэлт болон төлбөрийн тэнцлийн дарамтыг багасгахад эдийн засгийн бодлогыг чангатгах нь зайлшгүй хэрэгтэй байна. Энэ оноос Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтын зарцуулалтууд болон Монголбанкны санхүүжилтүүд буурах хүлээлт байгаа учир төсвөөс гадуурх зарцуулалтыг оролцуулж тооцсон төсвийн алдагдал 2014 онд өнгөрсөн жилийнхээс бага байхаар байна.

Бодлогын сорилт

Монголын хувьд хамгийн гол сорилт нь тогтворгүй макро эдийн засгийн бодлогоо цэгцэлж, төлбөрийн тэнцлийн дарамтыг хөнгөлөн, нам

Азийн хөгжлийн банкны Эдийн засгийн ээлжит тайлан 2014 оны дөрөвдүгээр сар -Монгол

Он	2014	2015
ДНБ-ий өсөлт	9.5 %	10 %
Инфляци	11 %	8 %
Урсгал дансны тэнцэл	-20 %	-15 %

АХБ, ДБ, ОУВС-гаас гаргасан Хятадын эдийн засгийн таамаг

Он	2014	2015
Дэлхийн банк	7.6%	7.5%
Азийн хөгжлийн банк	7.5%	7.4%
Олон улсын валютын сан	7.5%	7.3%

ОУВС- голлох эдийн засгуудын өсөлт

Он	2014	2015
ОХУ	1.3%	2.3%
Энэтхэг	5.4%	6.4%
Их Британи	2.9%	2.5%
АНУ	2.8%	3.0%
Евробүс	1.2%	1.5%
Хөгжиж буй эдийн засагтай орнууд	4.6%	5.3%

дор инфляцийг онилж, санхүүгийн салбарыг гэтэж буй өндөр эрсдэлийг бууруулах юм. Гадаадын шууд хөрөнгө оруулалт болон нүүрсний экспортод нүүрлэсэн сөрөг “шокууд” нь төлбөрийн тэнцлийн дарамтыг 2012 оноос хойш хүндрүүлж ирлээ. Эдгээр дарамтад өрөө нэмэгдүүлж, импортын эрэлт, зээл олголтыг дэмжсэн төсөв, мөнгөний тэлэх бодлого ихээхэн нэрмээс болсоор байна.

Түүнчлэн гадаад валютын нөөц ерөнхийдөө хангалттай байгаа боловч буурч буй хандлага нь тогтвортой биш байна. Хөрөнгө оруулалтын хууль шинээр батлагдсан ч гаднын

хөрөнгийн урсгал дахин сэргэхэд нэлээд хугацаа зарцуулагдахаар байгаа. Мөн одоогийн эдийн засгийн бодлого нь үүсч болох гадаад “шокуудыг” давах санхүүгийн хамгаалалтуудаа чангатгахад төдийлэн дэмжлэг үзүүлэхээргүй байна. Дээрх сорилтууд нь эдийн засгийн бодлогын шинэчлэл хийх хэмжээний иж бүрэн багц арга хэмжээ авах нь зайлшгүй болсныг илтгэж байгаа билээ. Гэсэн ч төсөв, мөнгөний бодлогыг сайжруулах нь нэн тэргүүнд тавигдах асуудал юм. Мөнгөний бодлого нь макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэх ёстой. ■

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН-2014

ЧУУЛГАНЫ АЛДАА, ОНОО

И.ОТГОНЖАРГАЛ

Монголын эдийн засгийн чуулган-2014-өөр яригдсан асуудлууд, шинэлэг санал санаачилгыг цаг тухайд нь манай www.mongolianeconomy.mn сайт, "Economy" TV студи болон бусад сонин хэвлэл, телевизээр мэдээлсэн. Интернэт ертөнц бүтэн 2-3 хоног эдийн засгийн чуулганаар амьсгалсан. Тэгвэл манай сэтгүүлийн хувьд энэ удаагийн дугаартаа тус чуулганы үеэр хөндөгдсөн чухал асуудлуудаар сурвалжлага, сонирхолтой ярилцлага зэргийг бэлтгэн хүргэж байна.

Монголын эдийн засгийн чуулган энэ удаа 35 салбар хуралдаантай болсон учраас бидний хувьд нэг хоёр удаа бичээд орхих биш, жилийн турш хөндөх сэдэв, баримт, олон сонирхолтой өнцөг олж авсан гэдгээ тус чуулганыг тав дахь жилээ амжилттай зохион байгуулсан "Монголын эдийн засгийн форум" ТББ-ын хамт олонд уламжлахад таатай байна. Харин энэ нийтлэлээр хөндөх асуудлын тухайд Монголын нийгэмд брэнд болж чадсан тус чуулганы тав дахь удаагийн арга хэмжээний алдаа, оноо юу байсан бэ гэдэг талаас нь гаргахыг зорилоо.

Эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулагчид, төр засгийнхан, Олон улсын байгууллага, иргэний нийгэм, эрдэмтэн судлаачдын төлөөлөл гээд нийгмийн тал бүрийн оролцоог бий болгож, асуудлыг хэлэлцүүлдгээрээ тус чуулган өндөр ач холбогдолтой. Тиймээс ч иргэдийн хувьд Монголын эдийн засгийн чуулганыг хүсдэг, хүлээдэг. Жилд 800-1000 орчим төлөөлөгчтэй чуулдаг. Энэ жил ч гэсэн зохион байгуулагчдын зүгээс тийм хэмжээний төлөөлөгч оролцсон гэсэн мэдээллийг өгсөн. Тус чуулган хоёр өдөр нийт 35 салбар хуралдаан зохион байгуулсан. Зочид төлөөлөгчдийн зарим нь өөрийн сонирхсон салбар хуралдаанууд



дээрээ цаг заваараа ирсэн учраас оролцогчид өмнөхөөс шингэн санагдсан байх талтай. Гэхдээ УИХ-ын гишүүд "Чуулганд заавал оролцоно" гэж урьдчилж захиалга өгсөн боловч цаг дээрээ бараг ирээгүй тухай зохион байгуулагчдын зүгээс урамгүйхэн учирлаж байсан. Уг нь бол жил жилийн эдийн засгийн чуулганы үеэр яригдаж байгаа асуудлуудыг жинхэнэ шийдвэр гаргаж, бодлого тодорхойлогчид сонсмоор санагддаг. Даанч тэгдэггүй нь харамсалтай. С.Дэмбэрэл, Я.Содбаатар, С.Бямбацогт С.Одонтуяа зэрэг гарын таван хуруунд багтаахад гишүүн хоёр өдөрт хурлын танхимд орж, гарч харагдсан. Сошиал медиагаар хурлын төлөөлөгчид "Төрийн түшээд ээ, эдийн засгийн чуулгандаа суугаач ээ" гэж хүртэл жиргээд авсан байна лээ.

Алдаа

Хоёр өдрийн дотор 35 салбар хуралдаан хийж болдог гэдгийг тус чуулган харуулж чадлаа. Энэ нь

ололт, алдаа хоёуланг нь дагуулсан гэх үү дээ. Нэг талаасаа өмнө нь яригддаг улиг болсон сэдвүүдийг давтаагүй нь сайн хэрэг. "Монголдоо бүтээцгээе" уриалгын дор төдийлэн яриад байдаггүй олон сонирхолтой сэдвийг багтаасан байв. Эрүүл мэндийн салбарын сайн засаглал, Санхүүгийн зах зээл-Шинэ тоглогчид, Хүн өөрөө баялаг, Татварын бодлого-Ялгаатай юу, үгүй юү, Даатгал- эрсдэлгүй орчин, XXI зууны монголчуудын үнэт зүйлс, Яагаад урлаг, Төсөл-түүний шалгаруулалт, Ухаалаг хот- бидний ирээдүй, Иргэн ба нийслэл, Стандартуудыг жигдлэх, Зээлийн түүх, Ажилгүй юу, чадваргүй юү гээд олон шинэлэг сэдэв байлаа. Гэхдээ "Хэт олон зүйл рүү үсчсэн, зарим сэдвээ дэндүү жижиглэсэн байна" гэсэн шүүмжлэлийг ч хэлэх оролцогчид таарч байсан. Тухайлбал, С.Дэмбэрэл гишүүн "Хүлээж байсан асуудлууд ерөөсөө яригдахгүй байна. Энэ удаагийн чуулган валютын ханш, татварын шинэчлэл, Оюутолгойн асуудлыг тойрч явагдах ёстой байсан. Гэтэл аль нь ч байхгүй байна. Би Татварын бодлого-Ялгаатай юу, үгүй юү хуралдааныг сонирхсон. Маш хөнгөн хөндлөө" гэв. МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш Б.Эрдэнэбат "Зохион байгуулагчдын зүгээс юу хийж болох байсан бэ гэвэл үнэтэй цаг, мөнгөө зарцуулаад ирсэн хувийн секторынхон, төр, иргэний нийгэм, мэдлэгийн салбарынхан цугласан энэ сайхан боломжийг зүгээр нэг үсчсэн ерөнхий зүйлүүд биш, барьцтай тодорхой зүйл ярьж өнгөрөөсөн бол ихээхэн үр өгөөжтэй байх байлаа. Хэрвээ ямар нэгэн сэдэв сонгож байгаа бол энэ сэдэвтэй хамаатай хамгийн чухал оролцогч талууд юу байж болох вэ? Тийм хүмүүстэйгээ урьдчилж тохироод, тухайн сэдвээрээ өмнө нь хэлэлцүүлэг зохиож, илүү тодорхой болгож оруулж ирээд, энд хэлэлцэх ёстой байсан байх. Жишээ ►►

► нь, би өчигдөр Зээлийн түүхийн хурал дээр суусан. Хурал удирдагч нараас ганц нь ч ирээгүй. Тэгэхээр тэнд оролцож саналаа хэлж байгаа хүмүүс хувийн хэвшлийг бүрэн төлөөлж чадах уу гэдэг эргэлзээтэй. Хэсэг бүлэг хүний лообий явагдах вий гэсэн айдас өөрийн эрхгүй төрсөн” хэмээн ярьсан.

Олон салбар хуралдаан зэрэг явагдсан гэхэд ихэнх нь бас ч гэж боломжийн оролцогчидтой байсан. Гэхдээ ганц нэг нь үнэхээр хүнгүй шахуу байсантай санал нэг байна. Стандартуудыг жигдлэх гэсэн салбар хуралдаан огт болоогүй. Уг нь их л чухал сэдэв. Сонирхох хүн байсан л байх. Гэвч зэрэгцээд Иргэн ба нийслэл, Ирээдүйн өв-баялгийн сан, Кластер: Хамтдаа нэмүү үнэ цэнийг бүтээх нь, Шийдэл нь инноваци гээд олон шинэлэг хурал байсан учраас хүмүүсийн хүч тарамдсан байх талтай. Гэхдээ олон оролцогчидтой, халуун маргаан өрнөсөн, гарц шийдэл хайсан бүтээлч хурал цөөнгүй болсон. Тухайлбал, эхний өдөр XXI зууны монголчуудын эрхэмлэх зүйлс хуралдаанд олон сонирхолтой хүн оролцож, ярилцсан. Хоёр дахь өдөр Шийдэл нь инноваци хуралдааны үеэр Төрийн ордны В танхим дүүрэн хүнтэй, асуудлыг нэлээд хурц хэлэлцэж байлаа. Олон салбар хуралдаантай зохион байгуулсан нь нэг талаасаа олон асуудлыг нэг дор ярьж болдог гэдгийг харуулснаараа давуу талтай ч нөгөө талаасаа юм юм руу үсчсэн гэдэг шүүмжлэлийг зүй ёсоор дагууллаа.

Хоёрдугаарт, салбар хуралдаанууд дуусаад чуулган шууд өндөрлөсөн нь оролцогчдод нэг л дутуу санагдах шиг болсон. Нэг үгээр хэлбэл, хоёр өдрийн турш үргэлжилсэн салбар хуралдаануудын дараа Их танхимд эргэн цуглаж, нэгтгэн дүгнэдэг уламжлал энэ удаа байсангүй. Ялангуяа энэ жилийн хувьд салбар хуралдаанаар маш олон асуудлыг хэлэлцэж чадсан учраас харин ч өмнөхөөс сайн нэгтгэн дүгнэх шаардлагатай байсан байж ч болох. “Хаалтын нэгдсэн хуралдаан байхгүй юм уу” хэмээн нэгнээсээ асуун өлгүүрийн зүг гэлдрэх хүн олон байв.

Гуравдугаарт, салбар хуралдааны

сэдвүүд хэдий сонирхолтой, Төрийн ордонд гүйсээр хоёр өдрийг өнгөрөөсөн ч эдийн засаг ийм хүнд байгаа үед нээрээ л валютын ханшийг хэрхэх, эрсдэл хэр удаан үргэлжлэх, түүнийг хэрхэн давах боломж бололцоо байна вэ гэдэг дээр төр засгийн бодлого ямар байгаа хувийн хэвшлийнхэн юу хийх ёстой талаар маш тодорхой дүгнэлттэй гарах хүсэл илүү тээсэн биз ээ. Гэхдээ хурлыг үр дүнгүй болсон гэж байгаа юм биш. Зохион байгуулагчдын зүгээс маш их ажилласан нь мэдрэгдэж байсан. Эдийн засгийн чуулган тав дахь жилээ болж байгаа учраас оролцогчид өмнөхөөс илүү ихийг хүссэн байж ч болох. Таван настай цэцэрлэгт явдаг хүүхдээсээ эцэг эх нь илүү бие даасан байдлыг, сурч мэдэх хүсэл сонирхол, авъяас билгийг нь нээхийг хүсдэгтэй адил юм даа.

Оноо

Энэ жилийн эдийн засгийн чуулганы хамгийн халуухан хурал хоёр дахь өдрийн нэгдсэн хуралдаан буюу Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт байв. Тус хуралдааны үеэр эрх баригч болон сөрөг хүчин болсон хоёр том намын УИХ дахь бүлгийн дарга нарыг индэрт зэрэгцүүлэн суулгаж чадсан нь “Монголын эдийн засгийн чуулган-2014”-ийн хамгийн том ололт амжилт байв. Эдийн засаг ээдрээтэй, улс төрийн байдал шалдир булдир байгаа энэ цаг мөчид хоёр намын Бүлгийн дарга нарыг нэг дор суулгаж, хөгжлийн бодлого, төлөвлөлт яриулж чадсанд олон хүн олзуурхаж, баяртай байлаа. Түүнчлэн тус хуралдааны модератороор эдийн засагч, нийтлэлч Д.Жаргалсайханыг ажиллуулсан нь ч тун догь байв. Түүнээс биш, тааруухан хөтлөгч байсан бол хоёр дарга хурлын зочид төлөөлөгчдөд мэдээлэл хийх биш, “танай нам, манай нам” гэж хоорондоо ширүүхэн маргахад бэлэн байсан. Чуулган зохион байгуулагчид хамгийн өндөр оноог эндээс аваа болов уу.

Дараагийн ололт амжилттай зүйл нь модераторууд. Өнгөрсөн дөрвөн жилийн хурлыг голлон телевизийн олны танил хөтлөгч,

сэтгүүлч хөтөлсөн бол энэ удаа тэд нараас татгалзжээ. Энэ нь гэхдээ буруудаагүй санагдсан. Нэгдсэн болон салбар хуралдаануудыг тухайн чиглэлийн мэргэжлийн хүмүүсээр хөтлүүлсэн нь асуудлын гүн рүү орох, зочдыг удирдан залах зэргээрээ илүү байсан тухай хурлын төлөөлөгчдийн зарим нь сонирхуулж байсан.

Мөн энэ удаагийн чуулганд гадаад, дотоодод мэргэжил боловсрол эзэмшиж, өндөр технологи, инноваци, судалгаа шинжилгээ зэргээр мэргэшсэн туршлагатай “мундаг” залуу оролцогч олон байсан. Тэд салбар хуралдаан бүрийг сонирхож, санал бодлоо илэрхийлж, идэвхтэй оролцож байсан нь бахрахмаар байлаа. Үүнд зохион байгуулагчдын зүгээс ч нэлээд анхаарчээ. Энэ бол өмнө нь байгаагүй шинэ үзэгдэл. Тийм ч учраас томоохон ололт, өөрчлөлт гэж үзэж болно.

Гуравдугаарт, Монголын эдийн засгийн чуулган анхнаасаа л дэлхийн нэр нөлөө бүхий зочноор “гоёдог” уламжлал тогтсон. Тэр уламжлалыг энэ удаа Давосын дэлхийн эдийн засгийн чуулганы Монгол Улсын хөгжлийн 2040 он хүртэлх стратеги, хувилбаруудыг боловсруулсан төлөөлөгчдийн төлөөллөөр үргэлжлүүлэв.

Мөн тус чуулганы эхний өдрийн оройн зоог буюу Ерөнхий сайдын хүлээн авалт “Монгол бахархал” нэрийн дор болсон нь нэлээд өвөрмөц байв. Энэ үеэр загварын үзүүлбэр, Монголын байгалийн сонирхолтой гэрэл зургуудыг дэлгэн тавьж бүтэн орой Монгол бахархлаар омогшсон нь чуулганд оролцсон гадаадын зочид төлөөлөгчдөд тун ч их таалагдсан.

Монголын эдийн засгийн чуулганыг алдаанаасаа суралцаж улам сайн зохион байгуулаасай гэдэг үүднээс тав дахь жилийн арга хэмжээний алдаа, оноог ийн өгүүлээ. Зохион байгуулагчдын зүгээс ч гэсэн саяхан чуулганы зохион байгуулалт ямар байсан талаар оролцогчдоос санал авахаар мэйл илгээсэн байсан. Энэ нь тэд илүү сайн ажиллахыг хүсэж байгаа гэсэн үг. Дараа дараагийн эдийн засгийн чуулганд өндөр амжилт хүсье. ■

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН-2014

ЧУУЛГАНД ОРОЛЦОГЧИД ЮУ ХЭЛЭВ

О.Орхон /ХХБ-ны дэд захирал/:

-Баялагтай улсаас баян улс болох боломж Монголд байна. Монголоос ашигт малтмал авдаг улс авахаа байчихвал баларна гэж хүмүүс ярьж байна. Би хувьдаа үүнийг сайн зүйл гэж харж буй. Яагаад гэвэл ирээдүйн баян болох Монголын баялаг байгалийн баялаг биш, нөхөн сэргээгддэг баялаг юм. Монгол дэлхий дээрх хамгийн их нартай, салхитай улс. Жил бүр гамшгийн хэмжээнд хүртэл үер болдог. Үүнийг хуримтлуулах боломжтой. Дээрээс нь маш их хэмжээний хөдөө аж ахуйн түүхий эдтэй. Энэ бүгдийг ирээдүйд хөгжүүлэхийн тулд одоо газар дор байгаа баялгаа маш хурдан ашиглаж, боловсруулж хөрвөх чадвартай болгоод, алсдаа хөгжүүлэх зүйл рүүгээ төвлөрье гэсэн санаа юм.

Ч.Ганхуяг /Эдийн засагч/:

-Монгол Улс 20 жил уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрээр тэжээлгэсэн. Одоо Оюутолгойгоос дараагийн 20 жилд ДНБ-ийхээ 30 хувийг гаргаж авна гэж байгаа. Тийм байж уул уурхайн бүтээгдэхүүнийг брэнд болгож ярихгүй байна. Уул уурхайгаар тэжээлгэж байж ундаалж буй булгийнхаа ус руу нулимаад байгаа юм шиг байж таарахгүй. Уул уурхайгаас орж ирэх орлогоо зөв зарцуулах хэрэгтэй. Хуримтлалын санг одооноос суурийг нь тавиад тэтгэврийн шинэчлэлээ хийгээд8 орж ирж байгаа мөнгөнийхөө зарим хэсгийг тэр сандаа хадгалах хэрэгтэй.

Энэ гурван алхмыг хийснээр бүтэн тойргийг хаана. Ингэснээр ямар үр дүнд хүрэх вэ гэхээр цугласан баялгийн сангийн мөнгөөрөө гадаадын том корпорациудын хувьцааг авч, дэлхийн түвшний өндөр технологитой үйлдэрүүдийг худалдан авч болно. Мөнөөх яриад байгаа төрөлжилт эндээс гарч ирнэ.

Б.Лхагвасүрэн /Монголбанкны Хяналт, шалгалтын газрын захирал/:

-Ноолуурыг валют болгоход зөвхөн тэрнийг бүтээж үйлдвэрлэж байгаа үйлдвэрлэгчдээс гадна төрийн оролцоо байх ёстой. Яагаад гэвэл ноолууран бүтээгдэхүүн зөвхөн “Говь” гэдэг компанийнх биш, Монгол Улсын бүтээгдэхүүн. Үүнийг дэлхийн өнцөг булан бүрт хүргэхэд төрийн оролцоо хэрэгтэй.

Г.Батхүрэл /ЭЗХЯ-ны газрын дарга/:

-Үндэсний хөгжлийн цогц бодлого өмнө нь боловсруулж байх явцад Үндэсний хөгжлийн үзэл баримтлал, Тогтвортой хөгжлийн цогц бодлого гээд урт хугацааны бодлого байсан. Гэтэл энэ урт хугацааны цогц бодлоготой давхцуулаад дахин цогц бодлого гаргаж байна гэдэг бол бидний өнөөдрийн яриад байгаа төлөвлөлтийн тогтолцоо, урт хугацааны бодлого боловсруулах механизм боловсруулалтын шатнаасаа эхлээд алдаатай явж байна гэж ЭЗХЯ үзэж байгаа.

С.Одонтуяа /УИХ-ын гишүүн/:

-Эрүүл мэндийн салбарыг эдийн засгийн том салбар гэж авч үзэхгүй олон жилийг өнгөрөөж ирсэн. Энэ нь зүгээр л төсвөөс мөнгө авдаг. Үр ашиг тал дээр огт анхаарч ирээгүй. Урьдчилсан тооцоогоор гадаадад эрүүл мэндийн чиглэлээр жилд 600 сая ам.доллар гарч байна. 60.000 хүн гадаад явж эмнэлгийн үйлчилгээ авч байна гэсэн тооцоо гараад байна. Эрүүл мэндийн салбарыг заавал эмч хүн удирдах ёстой гэсэн ойлголтоос ч салах хэрэгтэй болж. Эрүүл мэндийн салбарыг эдийн засагч хүн удирдах цаг нь болсон байна. Өнөөдөр эрүүл мэндийн салбарын засаглалын талаар ярилцлаа.

Д.Батмөнх /Ерөнхий сайдын зөвлөх/:

-Монголд мянган сайн санаа гаргаад, үйлдвэрлээд тэрийг нь гадагшаа гаргахаар зарагдахгүй бол үнэгүүддэг. Бидэнд дэлхийн хэмжээний өрсөлдөх чадвар хэрэгтэй. Хоёрдугаарт, импортыг бид боломж гэж харж байгаа. Нэгэнт манайх гаднаас 100 сая ам.

долларын юм худалдаж аваад байгаа юм чинь тэр хэмжээний зүйл үйлдвэрлэхэд зарагдах нь тодорхой. Нөгөө талд борлуулалт найдвартай байна гэдэг бол төсөл хэрэгжээд, зээл төлөгдөөд явах боломжтой. Бидний хоёр сар гаруйн хугацаанд ажилласан бодлоготой давхцацан санаа ч өнөөдөр олон байна. Шинэ санаа гэвэл үнэхээр манайд худалдааны бодлого чухал. Борлуулалт гэж юм алга. Өөрсдийнхөө чадлаар юм хийгээд байдаг. ■






ВЭБ САЙТ,



МОБАЙЛ ВЭБ,

APPLICATION



ЧАНАРЫН ӨНДӨР ТҮВШИНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭНЭ.

91116586, 96606586

Манай хамт олон видео, график реклам, захиалгат нэвтрүүлэг болон видео төрлийн бүх монтажыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэж байна.

ХӨРӨГ БАРИМТАТ НЭВТРҮҮЛЭГ

РЕКЛАМ

ТВ ШТОРЖ

20 сек хүртэлх дүрст реклам 1 сек

50 000₮

21 сек дээш дүрст реклам 1 сек

35 000₮



ЗОЧИН

ЭРДЭС БАЯЛГИЙН УДИРДЛАГАТАЙ БАЙХ НЬ БУРУУДАХ ЗАМ БИШ

Б.ЭНХЦЭЦЭГ

Манай сэтгүүл монголын эдийн засгийн чуулганд оролцсон Дэлхийн эдийн засгийн форумын Стратеги хариуцсан ахлах дарга Кристел Вандер Елсттэй уулзаж, хөгжлийн хувилбаруудын талаар илүү дэлгэрэнгүй ярилцах боломж олдсон юм. Кристел нь Фулбрайтын тэтгэлгээр Иелийн их сургуулийг Менежментийн чиглэлээр бакалавр зэрэгтэй төгссөн. Тэрбээр Уул уурхай болон металс, 2025 он хүртэлх хөгжлийн хувилбарууд, Юань, ам.доллар, еврогийн тодорхойгүй байдал, Олон улсын валютын системийн ирээдүй, Иргэний нийгмийн ирээдүйн байр суурь, ОХУ-ын хөгжлийн хувилбарууд зэргийг боловсруулахад гар бие оролцож байжээ.

-Та манай улсад дөрөв дэх удаагаа ирж байна. Энэ хугацаанд Монголын боломж нөөцийг хэрхэн харж байна вэ?

-Уул уурхайн баялаг мөн түүнийг бусад салбарт баялаг бүтээхэд ашиглан эдийн засгаа төрөлжүүлэх талаас нь харвал эдийн засгийн хувьд аугаа боломж, чадавхи байна. Гэхдээ энэ их боломжоо ухаарч, урагш хөдлөх хүч болгохын тулд тун ч ихийг хийх хэрэгтэй байна даа.

Монголын хувьд ажиглагдаж буй давуу тал нь ардчилалын үнэт зүйлсээ ихэд дээдэлж, хадгалж авч үлдэхийн тулд хүсэл, зүтгэлээ харамгүй гаргадаг улс юм. Ардчилсан зарчмаар асуудлыг гаргаж ирж, хэлэлцэж, мэтгэлцэх нь их чухал. Энэ талаар бусад шинээр гарч ирж буй эдийн засгуудаас ялимгүй өөр юм.

-Та манай бусад хөгжиж буй эдийн засагтай улсаас ялгарах онцлогийн талаар ямар бодолтой байна? Азийн хөгжиж буй улсуудтай харьцуулахад ямар байна вэ.

Байгалийн асар их нөөц бололцоо бүхий эрдэс баялаг байна. Энэ нь Индонезитэй нэлээд төстэй. Гэвч танай улсад хөгжлийн сайн суурь бий. Тухайлбал, ардчилал, цөөн хүн ам. Бусад улстай харьцуулахад хүн амын нягтаршил бага. Энэ нь Монгол баялгийн хишгээ иргэддээ хүртээхийн тулд эдийн засгаа тийм ч их тэлэх шаардлагагүй гэсэн үг.

Хоёр хөрш болох Орос, Хятадаас шууд хамааралтай. Танай улстай харьцуулж болох ихэнх ижил төстэй эдийн засагтай улс далайд гарцтай. Монгол бүх талаар хоёр хөршдөө

хашуулдаг. Үүнийг сайн анхаарч үзэх нь чухал.

Гэвч өнөөдөр өөрсдийгөө далайд гарцгүй улс гэж харах эсвэл голлох өсөлтүүдийн төв цэг гэж үзэх эсэх нь та бүхний хандлагын асуудал. Та бүхэнд онцгой байршил бий. Үүнийг ойлгож, хөшүүрэг болгож ашиглах талаас харах нь зүйтэй.

-Дэлхийн эдийн засгийн чуулганы Монголд зориулж гаргасан хөгжлийн хувилбаруудаас Монгол Улс хөгжлийн хувьд дөрвөн замын уулзвар дээр байна гэж ойлгогдлоо. Та санал нэгдэх үү?

-Тиймээ. Та бүхэн яг тэр замын голд зогсож байна.

-Хөгжлийн хувилбаруудын чиглүүлж буй ирээдүй бидний хувьд ямар байхаар байна вэ?

-Монгол яг одоо сайн анхаарч авч үзэж, хариу үйлдэл үзүүлэх ёстой гурван хөгжлийн хувилбар байна. Өөрөөр хэлбэл, уул уурхайн баялаг, дагалдах боломжуудаа хэрхэн удирдах, уул уурхайг эдийн засгийн төрөлжилтийн суурь болгох. Мөн худалдаа болон хөрөнгө оруулалтын ямар харилцааг бид ирээдүйд хүсч байна вэ гэдгээ тодорхойлж, замаа сонгох чухал мөчид Монгол ирээд байна.

Энэхүү хөгжлийн хувилбаруудад бид зөвхөн одоогийн нөхцөл байдал гэхээс илүүтэй ирээдүйд бий болж болох орчин нөхцөлийг харуулахыг зорьж, одоогийн та бүхний тавьж буй асуултад хариулахыг хичээсэн. Бүхий л шийдвэр хэрэгжилт, үр дагаврын хувьд цаг хугацаа шаарддаг. Тиймээс ирээдүйгээ сайн бодож, шийдэх хэрэгтэй.

Уул уурхайн салбарын хөгжлийн хувьд Монгол Улс эдийн засгийн тогтвортой орчинтой байх нь л нэн чухал. Өнгөрсөн жилүүдэд, хүчээ авч байсан таваарын үнэ өдөр ирэх тусам салхи шиг чигээ өөрчилж байна. Мөн макро эдийн засгийн орчинд өнгөрсөн зургаан сарын хугацаанд өөрчлөлт ажиглагдаж байна. Энэ нь Монголд эрдэс баялгаа гадагш зарахад илүү хүндрэлтэй болохын дохио.

-Монголын одоогийн нөхцөл байдлыг харвал аль хөгжлийн хувилбартай нь илүү дөхөм байгаа вэ?

-Уул уурхайн баялаг дээр суурилж хөгжих нь ойр санагдаж байна. Энэ бол танай улсын эдийн засгийн тулгын чулуу. Гэвч үүнийг төрөлжихөд ашиглах нь хамгийн чухал. Монголд хөдөө аж ахуйн өндөр боломж байна. Мөн биотехнологи тэргүүтэй инноваци бүтээмж рүү түлхүү анхаар. Мөн банкны салбар дахь боломжуудыг ч сайн ▶

► харах хэрэгтэй. Эрдэс баялаг ба төрөлжилт гэсэн хоёр хөдөлгүүртэй эдийн засаг нь хөгжлийн сайн хувилбар байна гэж бодож байна.

-Дэлхийн эдийн засгийн чуулган дахь манай улсын оролцоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Тэгвэл Монголын байр суурийг та хэрхэн харж байна вэ?

ДЭЗЧ болон Монгол улс хамтарч ажиллаж буй нь сайн хэрэг. Дэлхийн эдийн засгийн чуулган бол асуудлыг шийдэлтэй нь уулзуулах тухай л байдаг. Монгол олон улсын асуудлуудад шийдэл олоход нэлээд чармайлт гаргадаг улс. Чуулганы усны нөөц, авилгалын эсрэг хэсгүүдэд оролцоо өндөртэй байдаг. Харин одоо хөгжлийн загваруудаа биднээс гардаг аваад байна. Энэ бол Монгол Дэлхийтэй хэчнээн ойр холбоо, харилцаатайг харуулж байна. Газар зүйн хувьд алслагдмал байж болох ч хол, ойрын асуудал нь нэг талаар хандлагын л асуудал.

Дэлхийн эдийн засгийн чуулганд ойрын жилүүдэд хамгийн их ярьж буй ямар сэдвүүд байна вэ?

Цар хүрээ өргөнтэй чуулган учир олон асуудлыг хэлэлцдэг. Гэвч зарим асуудлыг дурьдвал, худалдааны тогтолцоо, зохицуулалт байна. Мөн бид шинжлэх ухаан, технологийн шийдлүүд рүү түлхүү анхаарч авч үзэж байгаа. Учир нь, шинжлэх ухаан ирэх 10 жилд бидний нийгмийг ихээхэн өөрчлөхөөр байгаа. Инноваци руу олон эдийн засаг шилжилт хийж байна. Дэлхийн эдийн засгийн форум ч гэсэн. Эдийн засаг сэргэж буй эсэх асуудал тодорхойгүй хэвээр байна. Энэ бидний голлох сэдэв байсаар байгаа. Мөн сүүлийн үед геополитикийн асуудлууд нэлээд хүч түрэн орж ирж байна. Үүнтэй холбогдуулан геополитикийн хурцадмал байдлууд нь Дэлхийн эрсдэлийн тайланд давамгайлах байр суурь эзлэх хандлага ажиглагдаж буй. Тиймээс бид энэ чиглэлд илүүтэй анхаарч байгаа.

Дэлхий даяар ногоон эдийн засаг, тогтвортой хөгжлийг нэлээд ярьж байна. Дэлхийн эдийн засгийн чуулганы хувьд энэ хэр түгээмэл сэдэв бэ?

Бид ногоон хөгжил гэж нэрлэдэг. Мөн эрдэс баялгийн удирдлага ч

гэж нэрлэж болно. Эрчим хүч, усны зохистой цаашлаад хэмнэлттэй хэрэглээг төлөвшүүлсэн сайн тогтолцоо, дэд бүтцийг эхнээс нь хэрэгжүүлж авч явбал энэ нь ногоон хөгжил. Та бүхэнд боломж нь байна.

Урт хугацааны амьдралын мөчлөгтэй байя гэвэл одооноос эхлэх нь зүйтэй. Бидний очиж үзсэн олон улс одоо нэгэнт яваад ирчихсэн хөгжлийн замаа

өөрчлөх гэж ихээхэн зардалтай тулгарч байна. Тиймээс ирээдүйнхээ төлөө одооноос эхлэх хэрэгтэй.

Бидний хөгжлийн хувилбарууд дээр бий л дээ. Хэрэв дэлхийн улсууд “ногоон” чиг хандлага баримтлахгүй “хүрэн” хэвээр үлдсэн ч Монголын хувьд “ногоорох нь” эерэг нөлөөтэй байх болно. Ингэснээр эрчим хүчний импортын хувьд бага хамааралтай ►



Дэлхийн эдийн засгийн форумаас эдийн засгийн голлох тоглогчид болон мэргэжилтнүүд багтсан 250 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг 2013 онд хамтран ажиллаж Монголын хөгжлийн гурван хувилбаруудыг боловсруулсан. Дээрх хувилбаруудыг энэ жилийн нэгдүгээр сард Швейцарийн Давост жил бүр болдог Дэлхийн эдийн засгийн форум дээр албан ёсоор танилцуулсан. Мөн өнгөрсөн сард Монголын эдийн засгийн чуулганд хөгжлийн хувилбаруудыг боловсруулсан Дэлхийн эдийн засгийн чуулганы мэргэжилтнүүд танилцуулга хийсэн юм. Манай сэтгүүл энэ тухай өмнө нь нэг бус удаа дэлгэрэнгүй хөндөж байсан учраас энэ удаад хөгжлийн хувилбаруудын гол асуудлыг товчхон хүргэе.

▶ болно. Нефть импортлохын оронд нар салхины эрчим хүчээр хэрэгцээгээ хангана гэдэг эрчим хүчний салбарын аюулгүй байдал хангагдана гэсэн үг. Улмаар Монголын хараат бус байх үнэт зүйл ч хадгалагдана. Цаашид ногоон технологиудыг дэд бүтэц, үйлдвэрлэлийн салбарт ашиглах замаар хөгжих боломжууд ч дагаж гарч ирэх юм. Тиймээс аль ч хувилбараар дэлхий ертөнц зүгээ тодорхойлсон,

эрдэс баялгийн удирдлагатай байна гэдэг буруудах зам бус хамгийн зөв нь байх болно.

-Монголын ирээдүйн хөгжлийн замд хамгийн том сорилт нь юу байх бол?

-Байгалийн баялгаа хэрхэн олборлож авах вэ гэдэг л хамгийн том сорилт байх болов уу. Энэ бол Монголын эдийн засгийн суурь нь. Гэвч үүний тулд эдийн засгийн тогтвортой орчныг бий болгож,

хөрөнгө оруулалт орж ирэх, ашигт малтмал борлуулах замыг чөлөөлөх хэрэгтэй.

Эхлээд эдийн засгаа тогтворжуул. Улсдаа хэрэгтэй гаднын шууд хөрөнгө оруулалт, сангуудыг оруулж ирэхийн тулд олон улсын хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлэх нь чухал. Тэгээд орж ирсэн хөрөнгийг иргэд тэгш хүртэх боломжоор ханга. Богино хугацаанд ийм л хоёр том сорилт байна. ■

Монголын хөгжлийн хувилбарууд товчооноор



1. Бүс нутгийн сэргэн мандалт

- 2040 он гэхэд Монгол уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүнээ боловсруулах, борлуулахад ХЯЛБАР байна
- Зүүн хойд Азид улс төрийн интеграцилал идэвхжиж, эдийн засаг бэхжин өснө. Энэ нь Монголд уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүнүүдээ ашигтайгаар борлуулж, эдийн засгаа төрөлжүүлэх боломжийг олгохоос гадна, экспортын бодлогоо оновчтойгоор зохион байгуулж, эдийн засгийн хэт халалт, нийгмийн тогтворгүй байдлаас урьдчилан сэргийлэх шаардлагыг бий болгоно




2. Хятад “ногоорох” нь

- 2040 он гэхэд Монгол уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүнээ боловсруулах, борлуулах ЧАДВАРТАЙ байна.
- Хүрээлэн буй орчныг хамгаалах үзэлд хувьсгал гарснаар Хятад “тойрог эдийн засгийн” загвараар манлайлагч болж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлнэ. Ингэснээр Монголын уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний эрэлт буурах хэдий ч ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх боломж бий болгоно.



3. Баялгийн хямрал

- 2040 он гэхэд Монгол уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүнээ боловсруулах, борлуулахад ХЭЦҮҮ байна
- Бүс нутагт геополитикийн хямрал газар авч, байгалийн баялгийг улс төрийн явцуу сонирхлоор ашигласнаас үүдэн худалдааны нөхцөл байдал хүндэрнэ. Монгол Улс эрдэс баялгаа боловсруулан нийлүүлэх зах зээл, санхүүгийн эх үүсвэр олох боломж хумигдах хэдий ч бүс нутгийн бусад орны хүндэтгэлийг хүлээсэн төвийг сахисан байр суурь бүхий хөрш улсын байр сууриа бататгах боломжийг бүрдүүлнэ.



ИННОВАЦИ

УХААНАА УХАЖ ИДЭХ МӨРӨӨДӨЛ

Э.ЗОРИГТ

Инноваци гэх харь үг Монголын үгсийн санд нутагшаад удаж байгаа ч эдийн засагт өөриймсөлгүй хэдэн оныг үдсэн. Нэг хэсэгтээ л амтай бүхний амны уншлага болсон энэ үг өдгөө мартагдах шахжээ. Харин энэ жилийн Монголын эдийн засгийн чуулганаар инноваци гэж байдгийг дахин нэг сануулсан юм. Түүхэндээ хамгийн олон буюу нийт 30 гаруй салбар хуралдаантай болсон тус чуулганаар хүмүүсийн сонирхлыг гижигдсэн олон сэдвээр талууд ярилцсан. Түүний нэг нь “Шийдэл

нь инноваци” салбар хуралдаан байсан бөгөөд энэ үеэр олон хүний “загатанасан газар нь маажгаад” авсан юм.

Дутуу хуулийн сүүдэр

Мэдлэгийг эдийн засагжуулж, монгол эрдэмтдийг од болгох зорилготой Инновацийн тухай хууль батлагдаад дөрвөн хаврыг ардаа орхижээ. Эрүүгээ чилтэл инноваци гэж орилсон монгол эрдэмтдийн судалгааны ажил, шинэ мэдлэгийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, улмаар эдийн засгийн өсөлтөд хөтлөх мөрөөдөл Инновацийн

тухай хууль батлагдсанаар ажил хэрэг болох учиртай байлаа. Гэхдээ хууль батлагдлаа гээд инноваци амьдралд бууж, эдийн засгийн өсөлтийг тэтгэсэн нь үгүй. Тиймээс энэ талаар эдийн засгийн чуулганд оролцогчид хариу нэхсэн юм. “Монгол алтан тос” компанийн захирал Г.Ганболд “Монголчууд дотооддоо ургамлын тос үйлдвэрлэдэггүй байсан. Харин манай компани үйлдвэрлэж байна. Энэ бол Монголдоо л шинэ зүйл. Бид хүнсний салбарт инноваци хийсэн гэж үзэж байгаа. Гэтэл Эдийн засгийн хөгжлийн яамныхан хуулиа барьчихаад манайхыг инноваци ▶

► хийсэн, хийгээгүй гэж маргалдаад одоо хүртэл тодорхой хариу өгөөгүй байгаа” гэв. Ер нь энэ үеэр хуулийн талаар шүүмжлэл багагүй өрнөсөн. Тухайлбал, шинээр батласан хуульд инновацийн үйл ажиллагааг дэмжих олон чухал зүйл заалт орсон байдаг аж. Тухайлбал, Засгийн газрын дэргэд Инновацийн зөвлөл ажиллахын сацуу энэ чиглэлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх Инновацийн санг шинээр байгуулах учиртай байжээ. Гэтэл өнөөдрийг хүртэл хуулийн хэрэгжилт байхгүй байгаад олон хүн бухимдаж байна. Мөн хууль баталчихаад түүнийгээ хэрэгжүүлэх дүрэм журмыг нь гаргахгүй гацаадгийн тод жишээг эндээс харж болохоор байв. Боловсрол, шинжлэх ухааны яамны мэргэжилтэн Б.Лхагвадорж “Хууль хэрэгжихийн тулд дагалдах 10 гаруй журам гаргах шаардлагатай байгаа. Гэвч тэдгээр журмыг батлахад улс төрийн савлагаа, сонгууль, нэг засаг нь нь гараад нөгөө засгийнхаа бодлогыг үгүйсгэдэг төрийн залгамж халаагүй бодлого саад болж байна” гэв. Гэхдээ одоогоор гурван журам батлагдах гээд хүлээгдэж байгааг тэрбээр онцолсон. Тус гурван журмаар Засгийн газрын дэргэд Инновацийн зөвлөл байгуулах, гарааны компаниудыг татвараас чөлөөлөх гээд хэд хэдэн асуудлыг шийдэх юм билээ.

Мөнгө бас дахин мөнгө

Мөрөөдөхөд мөнгө төлдөггүй боловч зарим мөрөөдөлд мөнгө төлбөл тэндээс ашиг олж болдог. Түүний нэг нь инноваци. Шинэ мэдлэгийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулахад мөнгөний асуудал зайлшгүй тулгарна. Гэтэл өнөөдөр монголчуудад мөнгө алга байгааг салбар хуралдаанд оролцсон хувийн хэвшлийнхэн хэлж байлаа. Тухайлбал, “Монхимо” компанид “Адуу” брэндийн кальци, тоос дарагч гээд нэг бус ашигтай төсөл санхүүжилтгүйн улмаас тоосонд даруулаад байгаа аж. Тус компанийн ерөнхий захирал М.Ариунаа “Ер нь хэчнээн сайхан инноваци байлаа гээд санхүүгийн асуудлаа шийдэхгүй бол зах зээлд удаан амьдарч чадахгүй. Тиймээс улс орны нэрийг гаргах инновацийн төслийг төрөөс санхүүжүүлэх тал дээр анхаарах хэрэгтэй” гэв. Гэтэл зарим оролцогчид

үйлдвэрлэгчдийг төрөөс мөнгө горьдоод сууж байгааг эрс буруутгаж, харин хөрөнгийн зах зээлд гараад өөрсдөө хөрөнгө оруулагчдыг татах хэрэгтэй гэж байлаа. Аль аль нь хөрөнгө оруулалтын хувьд боломжийн санаа хэдий ч бүтэхгүйн зовлон их. Адаглаад дотоодын зах зээлдээ ч танигдаагүй бүтээгдэхүүнд итгэж хөрөнгө оруулах хувь хүн ховорхон. Дотоодын хөрөнгийн зах зээлд IPO хийлээ ч монголчууд хувьцааны тухай мэдлэг тааруу болохоор үйлдвэрлэгчид хөрөнгийн зах зээлд сүжиггүй ханддаг аж. Тиймээс инновацийнхны ганц найдвар төр гэнэ. Гэтэл төр бондын мөнгөөр инновацийн үнэргүй хэдэн зуун төсөл санхүүжүүлээд байгаа нь харамсалтай. М.Ариунаа “Төрөөс импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих нэрээр оймс бээлийний үйлдвэрт хөрөнгө өгөөд байгаа мөртлөө мэдлэг шингэсэн үйлдвэрлэл эрхэлдэг биднийг дэмжихгүй юм. Уг нь тэр төсөл шалгаруулдаг багт нь энэ талын мэдлэгтэй хүн байвал монголчуудын мөрөөдөл биелэнэ” хэмээн учирласан. Инновацийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд асар их мөнгө хэрэгтэй байдаг. Тиймээс мөнгө хайсан эрдэмтэд сайхан санаатайгаа тааз ширтээд сууж байгааг учирлах хүн олон. Харин олон улсын туршлагаас харахад нэг ч төгрөг зарцуулахгүйгээр мэдлэг шингэсэн үйлдвэрлэл, эдийн засагтай болох боломж байдаг юм байна. Тэр нь оффсет буюу харилцан худалдан авалт. Энэ талаар багахан тайлбар хийхэд Монголын үндэсний хэмжээний томоохон компани гаднын компаниас их хэмжээний бараа худалдан авч байгаа бол худалдан авалт хийсэн орондоо тодорхой хэмжээний бараа материалыг буцаан худалдах тохиролцоог ерөнхийд нь оффсет гэж нэрлэдэг юм билээ. Монголын үндэсний их сургуулийн Эдийн засаг, бизнесийн удирдлагын сургуулийн захирал Д.Нэргүй “Монгол Улсын эдийн засаг хөгжихийн хэрээр уул уурхай тэргүүтэй дотоодын олон салбар гаднаас их хэмжээний бараа бүтээгдэхүүн худалдан авч байгаа. Тиймээс нийт худалдан авалтын үнийн дүнгийн 30 хувиар оффсет хийнэ гээд хуульчлах боломжтой. Хуулийнхаа хүрээнд бид үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний үйлдвэр

үйлчилгээг эх орондоо оруулж ирэх нөхцөл бүрдэх юм” гэв. Мөн түүний тайлбарласанаар ийм хуультай болчихвол монголчууд ямар ч татвар төлөхгүйгээр гаднын технологи эзэмшигч болчихно. Тухайлбал, МИАТ “Бойнг” онгоц худалдан авахдаа оффсет хийсэн бол үнийн дүнгийн тодорхой хувьтай тэнцэх хэмжээний онгоцны технологийн баазыг эх орондоо бариулах боломжтой байжээ. Ганцхан жишээ дурдахад Кувейт улс оффсет хэлцэлийн үр дүнд “Бойнг” онгоцны засварын төвийг өөрийнхөө улсад нэг ч төгрөг төлөхгүйгээр бий болгосон байдаг аж. Өнгөрсөн жилийн “Financial times” сонины нэгэн дугаарт дэлхий дахинд хийж байгаа нийт оффсетийн хэмжээ 75 тэрбум ам.доллар байгаа гэжээ. Тиймээс энэ их мөнгөний багахан хэсгээс монголчууд авч яагаад болохгүй гэж.

Боломж бий, гэхдээ Ерөнхий сайд татгалзсан

Мөнгө нэхээд байгаа ч Монголд хөрөнгө оруулах инноваци алга гэж шүүмжлэх хэсэг байж магадгүй. Гэхдээ Монголд инновацийг бүтээгчид бий гэдэг нь дээрх салбар хуралдааны үеэр харагдаж байлаа. Заримаас нь дурдвал Төрийн соёрхолт инженер Н.Нацагням, “Hitachi” компанид ажиллаж байсан техникийн шинжлэх ухааны доктор Д.Баяр гээд олон эрдэмтдийг энд дурдаж болно. Тэдэнд инновацийн шилдэг туршлага, шинэ санаа байна. Төрийн соёрхолт инженер Н.Нацагням “Монголчууд дэлхийн зах зээлд гарах боломж байгаа. Өнөөдөр бид чип дизайнаар дэлхийг эзэлж яагаад болохгүй гэж. Хоёр ширээ дүүрэн схемийг нэгтгээд ганцхан ширхэг жижигхэн товчлуур буюу чип болгох чадвар монгол эрдэмтдэд байна шүү дээ. Гэтэл бид түүнийгээ ашиглаж чадахгүй байна” гэв. Ер нь энэ талын эрдэмтдийн хэлж байгаагаар чип дизайны тал дээр Монголд маш өндөр боломж байгаа гэдгийг дуу нэгтэй хүлээн зөвшөөрдөг юм билээ. Учир нь манайд чип хийж байсан туршлагатай эрдэмтдээс гадна чипний түүхий эд нь хүртэл байдаг аж. Чип гэлтгүй Монголчууд “ноу хау”-гаа дэлхийн зах зээлд зарах цаг хэдийнэ иржээ. Техникийн шинжлэх ухааны доктор Д.Баяр “Хоцрогдол нэг бодлын давуу тал. Гаднынханд ►

► том үйлдвэр байна. Харин бидэнд байхгүй гээд санаагаар унах хэрэггүй. Харин гоё санааг нь гаргаад л тэр санаагаа тэдэнд худалдаж болно шүү дээ. Тухайлбал, бид дотооддоо компьютер үйлдвэрлээд хол явахгүй. Харин хаана ч байхгүй компьютерын санаа, хэлбэр загвар гаргаж чадвал дэлхийн үйлдвэрлэгчид өрсөлдөөд л авна” гэв. Харин тэр сайхан санааг нь ажил хэрэг болгоход инноваци хөгждөг тогтолцоо чухал байдаг аж. Гэтэл Монголын өнөөгийн зах зээлийн тогтолцоо нь энэ салбарыг автоматаар нураагаад байгаа гэнэ. Н.Нацагням “Аль ч зах зээлд гарахын тулд бид эхлээд дотоодын зах зээлдээ амжилттай ажиллах хэрэгтэй. Үүний тулд тухайн зах зээлийг төр засгаас хамгаалчихмаар байгаа юм. Тухайлбал, би эх орондоо гар утас үйлдвэрлэж чадна. Магадгүй хөгжүүлээд чихэнд ордог хэмжээтэй болгох боломжтой. Гэтэл үүний тулд дотоодын зах зээлдээ ашиг олох хэрэгтэй байдаг. Гэвч манайд импортоор маш их гар утас орж ирээд зах зээлийг эзэлчихээд байхаар би гар утас үйлдвэрлээд ашиг олохгүй шүү дээ. Тиймээс дотооддоо үйлдвэрлэж чадаж байгаа бараа бүтээгдэхүүнийг импортоор оруулж ирэхийг хуулиар хориглох хэрэгтэй байна. Тэгэхгүй бол дотоодын үйлдвэрлэл автоматаар унаад байгаа юм” гэлээ. Тэрбээр энэ саналаа Ерөнхий сайдад уламжилжээ. Гэтэл Ерөнхий сайд “Чөлөөт зах зээлд монополь эрхийг шууд өгч болохгүй. Өрсөлдөөний зарчмаар гарч ирэх хэрэгтэй” гэсэн байна. Ерөнхий сайдын үг зөв юм шиг боловч түүх сөхөхөд өнөөдөр хөгжлөөр тэргүүлэгч бүх л улс өдий зэрэгт хүрэхийн тулд дотоодын үйлдвэрлэгч нарт зах зээлийн монополь эрхийг өгч байсан түүхтэй юм билээ. Ганцхан жишээ дурдахад Английн “English electric” компани улсынхаа усан онгоц, танк, нисэх онгоц гээд бүх тоног төхөөрөмжийг дангаараа хийдэг. Улсаас нь тэр компанид л бүх захиалгаа өгдөг байжээ. Тэрний хүчинд өдгөө “English electric” компани дэлхийн зах зээлд тэргүүлэгч болсон. Ер нь монголчууд нэгэнт хөгжихсөн баян капитализмыг дуурайх биш харин тэд хөгжихийн тулд 100 жилийн өмнө ямар хууль эрх зүйн орчинтой байсныг нь судлах

хэрэгтэйг ч оролцогчдын зарим нь хэлж байлаа. Гадаад, дотоодод төгссөн инженерийн толгойтой залуус хөгжлийг арай өөрөөр хараад байх шиг ажиглагдсан. Тухайлбал, Н.Нацагням шинэхэн Төрийн соёрхолт залуу хүн болоод ч тэр үү эдийн засгийн чуулганд идэвхтэй оролцож, салбар хуралдаан бүрт санал бодлоо хэлж байсан. “Шийдэл нь инноваци” салбар хуралдааныг удирдсан тэрбээр “Монголын өнөөгийн нийгэм хуулиар биш лоббигоор хөгждөг юм байна. Лобби байх хэрэгтэй. Тэгж гэмээнэ сая зах зээлээ хамгаалуулж дотоодын үйлдвэрлэгчид хөгжих суурь бүрдэнэ”. Мөн “Лордын тогтолцоог Монголд бий болгох хэрэгтэй. Юу яасан чөлөөт зах зээл” гэж байсан юм.

Ерөнхий сайд нь дотоодын үйлдвэрлэлээ дэмжих хэрэгтэйг сануулж, Монголбанк нь үйлдвэрлэгчдээ дэмжихийн тулд хэдэн тэрбумаар нь зах зээлд төгрөг нийлүүлээд, Засгийн газар нь зээл тавьж санхүүжилт өгөөд өгөөд зах зээлээс хамгаалж чадахгүй бол монголчууд импортод дулдуйтсан байдлаасаа ангижирч чадахгүйг салбар хуралдаанд оролцогчид учирлаж байлаа.

Монголд мэдлэгийн их уурхай байна. Гэхдээ түүнийг нь санхүүжүүлэх мөнгө нь, төр засгаас ухаалгаар дэмжих бодлого нь алга. Тиймээс нүүрсээ биш, ухаанаа ухах идэх мөрөөдлөө биелүүлэхэд төрийн дэмжлэг, зохицуулалт дутаад байгааг эдийн засгийн чуулганы “Шийдэл нь инноваци” хуралдаан харууллаа. ■

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

С.БЭХБАТ: КОНЦЕССТ ХУВИЙН ХЭВШЛИЙН ТУРШЛАГААС ИЛҮҮ МЕНЕЖМЕНТ ЧУХАЛ



С.ЗАЯА

Эдийн засгийн хөгжлийн яамны Инноваци, төр-хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга С.Бэхбаттай ярилцлаа.

-Танай газар бизнес эрхлэгчидтэй нэлээд хамтарч ажилладаг. Тэдэнд ээлтэй ямар бодлого шийдвэр гаргаж байна вэ?

-Эдийн засгийн хөгжлийн яамны таван газрын нэг нь манайх. Инноваци, төр хувийн хэвшлийн түншлэлийн газар бизнесийн орчинг боловсронгуй болгох, зах зээлийн эдийн засгийг түлхүү хөгжүүлэхээр ажиллаж байгаа. Манайх инноваци өндөр технологи, чөлөөт бүс, концесс гэсэн гурван хэлтэстэй. Мөн компанийн засаглал, нийгмийн хариуцлага, хувийн хэвшлийн хөгжлийн стратеги, “Зөгийн үүр” хөтөлбөр зэрэг олон чиг үүргийг хариуцан ажиллаж байна. Эдгээрээс одоогоор олны анхаарлын төвд ►

► байгаа концессын асуудлыг ярьж. Аливаа улс орны мөрөөдөл нь төр хувийн хэвшлийн түншлэл байдаг. Тухайн улсын төсөв томоохон төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхэд хүрэлцээ муутай байдаг. Тиймээс хувийн хэвшлийн татан оролцуулах, үр ашигтай менежментийг нь ашиглах боломжийг төр хувийн хэвшлийн хүрээнд бий болгодог. Монголд энэ талаарх эрх зүйн орчин бий болоод удаагүй ч өмнө нь ийм оролдлогууд байсан. Тухайлбал, менежментийн гэрээгээр зарим байгууллагуудыг ажиллуулж байв. Концесс нь төр хувийн хэвшлийн түншлэлийн нэгээхэн хэсэг юм. Өөрөөр хэлбэл, мөсөн уулын орой нь олны анхааралд байгаа томоохон төсөл арга хэмжээнүүд. Үүний цаана маш олон асуудал буй.

-Тухайлбал?

-Төр хувийн хэвшлийн түншлэл хөгжсөнөөрөө төрийн аппаратыг цомхон, менежментийг нь илүү боловсронгуй болгох ач холбогдолтой. Томоохон дэд бүтцийн хөрөнгө оруулалтаас гадна энэ мэт олон асуудал бий. Тухайн өмч 100 хувь төрийн мэдэлд эсвэл хувийн хэвшлийнх байвал дунд нь байгаа бусад бүх асуудал төр хувийн хэвшлийн түншлэлээр зохицуулагдана. Монголд энэ чиглэлийн эрхзүйн орчин бий болгохын тулд 2008 онд УИХ-аас Төр-хувийн хэвшлийн түр хороо байгуулж байсан. Улмаар 2009 оны аравдугаар сард энэ талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг, 2010 оны нэгдүгээр сарын 28-нд Концессын тухай хуулийг баталсан. Бодлогын баримт бичгийг малгай гэж хэлж болно. Үүнд бүх чиглэлийг зааж өгсөн юм. Харин хууль нь дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэгдсэн. Төрийн үүрэг бол тодорхой үйлчилгээг ард түмэнд үзүүлэх юм. Ингэхийн тулд дэд бүтэц, зам харилцаа, цахилгаан эрчим хүч, усан хангамж зэрэг байх ёстой. Өөрөөр хэлбэл, ийм үйлчилгээг үзүүлэх хариуцлага нь төрд хэвээр байна. Тэгэхдээ хувийн хэвшлийн татан оролцуулна гэсэн үг. Гагцхүү эрсдэл нь хаана байна гэдгийг тооцох шаардлагатай. Эрсдэл нь 100 хувь төрд байвал хувийн хэвшлийн сонирхлыг татаж болно. Харин бид ийм эрсдэлийг үүрвэл төсөвт хэт их ачаалал ирэх аюултай учир хууль баталж, бодлогын баримт бичигтэй боллоо. Өөрөөр хэлбэл, эрсдэлээ хуваалцахын зэрэгцээ хувийн хэвшилд тодорхой боломжуудыг нээж өгье гэж үзсэн.

-Концессын гэрээгээр ямар ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна вэ?

-Хууль хэрэгжиж эхэлж байхад чиг үүргийг нь Төрийн өмчийн хороо хариуцаж байсан.

Эдийн засгийн хөгжлийн яам байгуулагдсан учраас манай яаманд хэрэгжүүлэх чиг үүрэг нь шилжээд байна. 2010 онд концессын гэрээгээр хийх 121 төслийн жагсаалт батлагдсан байсан. Энэ жагсаалтыг бид өнгөрсөн онд шинэчлэн баталлаа. Одоо 51 төсөл болсон. Нөгөөтэйгүүр жагсаалтыг нэг баталчихаад гар хүрэхгүй 4-5 жил болдог гэж ойлгож болохгүй. Нэг ёсондоо энэ бидний ажлын хөтөлбөр, удирдамж гэсэн үг. Тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдал, тэргүүлэх ач холбогдлоос шалтгаалан зарим төслийг нэмж, хасч болно. Ер нь цаашид хөрөнгө оруулалтын ихэнх төслийг концессоор буюу төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хэрэгжүүлэх болно.

-Ойрын хугацаанд хэрэгжүүлэх томоохон төслүүдээс нэрлэхгүй юү?

-Авто зам, дэд бүтцийн, нисэх буудал, хоолойн тээврийн, эрчим хүчний, байгаль орчин, эрүүл мэнд, боловсролын, спорт, соёлын салбарын төслүүд бий. Үүнээс хэрэгжиж буй нь Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн авто замын төсөл юм. Тэлмэний дулааны цахилгаан станц, Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны автозамын төслийн гэрээг байгуулаад байна. Уг хурдны замын ажил нэлээд томоохон бүтээн байгуулалт болно. Уул уурхайн металлургийн цогцолбор байгуулах төслийг Засгийн газрын хуралдаанаас дэмжээд одоо гэрээ байгуулах шатанд яваа. Туул Сонгино усны нөөцийн цогцолбор төсөл гэрээ байгуулахад бэлэн болсон. Харин дулааны V цахилгаан станц, Тавантолгой-Ханбогд-Ханги чиглэл, Нисэх онгоцны буудлыг нийслэлтэй холбосон автозамын төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ хэлэлцээрийн шатанд явж байна.

-Концессын гэрээгээр ажил хийлгэхдээ хэр нээлттэй сонгон шалгаруулж байна вэ. Ер нь аливаа нэг тендер болон бусад асуудалд танил тал хардаг гэсэн ойлголт нийгэмд бий болоод удаж байна.

-Өнөөдрийг хүртэл явагдсан уралдаант шалгаруулалтууд нээлттэй явагдсан. Олон орны байгууллагууд ч оролцлоо. Цаашид илүү нээлттэй болгохын тулд шалгаруулалтад оролцож буй компаниудын мэдээллийг ил тод зарлана. Ямар компани, хэдий хэмжээний хөрөнгө, туршлагатай, ямар ажлыг хэр үр дүнтэй хийсэн эсэх нь олон нийтэд ил байх юм. Харин бид концессын төслийг хэрэгжүүлэхэд тухайн компанийн туршлагаас илүүтэй мөнгө босгох болон менежмент хийх чадварыг нь үнэлж сонгоно. ■

БОНД

“САМУРАЙ” БОНДЫН ЭРСДЭЛ & БОЛОМЖ

С.ЗАЯА

Бондын хөрөнгийг 2017, 2022 Бонд төлөх ч ямар эх үүсвэрээс гаргах нь одоогоор тодорхойгүй байгаа. Тавантолгойн цахилгаан станц, шинэ төмөр зам барих, хөдөө аж ахуйн салбарын зэрэг томоохон төслүүдэд тус бондыг зарцуулахаар төлөвлөсөн ч гарт баригдахаар шууд санхүүжилт өгөхөөр бэлэн төсөл алга. Ийн үр ашиггүй хадгалж, бондын хүүний төлбөрийг хагас жил тутамд Монголбанк төлж байна. Мөн Засгийн газар Японы талд удаа дараа санал тавьж, “Самурай” бондыг арилжих эрх авав. Үүнд Монголын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны банк эрсдэлийн баталгаа гаргасан. Тиймээс өнгөрсөн нэгдүгээр сарын эхээр Хөгжлийн банкны дансанд 24.3 тэрбум иен байршжээ. Уг нь манай улс 30 тэрбум иенийг Японы зах зээлд гаргасан. Үүний 5.7 тэрбумыг нь баталгаа гаргасан Японы банк бөөнд нь авсан аж.

“Чингис”, “Самурай” бондыг гаргасан нь манай улсын өмнө нь хийж байгаагүй ажил гэдгээрээ давуу ч улсын өр хяналтгүй нэмэгдэж буй нь айдас төрүүлж байна. Өрөө төлөхийн тулд төсөл хөтөлбөрт хийгдэж байгаа санхүүжилт үр өгөөжтэй байх ёстой. Монголбанкны тооцоогоор Монгол Улсын нийт өр олон улсын аргачлалаар 17 тэрбум ам.долларт хүрчээ. Энэ нь манай улсын ДНБ-ий 170 хувьтай тэнцэж буй. Үүнээс гадаадын хөрөнгө оруулалтыг өргөж тооцохгүйгээр хасвал 10 тэрбум ам.доллар нь манай улсын хувийн компаниудын өр. Харин улсын өр 4.5 тэрбум орчим ам.доллар аж. Үүн дээр “Самурай” бондыг оруулбал

багагүй өссөн тоо гарна. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн улсын өр ДНБ-ий 40 хувиас хэтрэхгүй байна гэсэн заалтыг аль хэдийнэ давсан гэсэн үг. Олон улсын байгууллагууд манай улсын өрийг 60-70 хувьтай

гэж тооцдог байна. Өрөнд улсын байгууллага, компани болон орон нутгийн өр ордог. Харин Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар зөвхөн гадаад өрийг тооцоод байгаа. Гэтэл манайд дотоодын өр гэж том зүйл бийг санах хэрэгтэй. “Чингис”, “Самурай” бондын төлбөрийг улсын төсвөөс төлнө. Эргэн төлөлтийн асуудал одоохондоо яригдаагүй ч 2017, 2018 оны төсөвт энэ хэмжээний мөнгө зайлшгүй тусгагдах болно. Тэгэхээр 2-3-хан жилийн дараа ийм их орлогыг төвлөрүүлэх аж үйлдвэрийн төслүүд хаана байна вэ. “Самурай” бондыг үйлдвэржилтийг дэмжих зорилгоор арилжаалсан. Энэ хүрээнд экспортыг дэмжих, импортыг орлох төсөл сонгон шалгаруулж, бүх зүйлийг тэгээс эхлэх гэж байна. Гэтэл хувийн хэвшлийн болон улсын томоохон бэлэн төслүүд байсаар. Тухайлбал, Монгол Улс аж үйлдвэржих гурван том төсөлтэй. Тэр нь гангийн, зэс хайлуулах, нефть боловсруулах химийн үйлдвэр юм. Эдгээрийн судалгаа аль хэдийнэ хийгдсэн. Гэтэл бондын хөрөнгийг олон төсөл хөтөлбөрт бага багаар зарцуулах



гэнэ. Энэ эрээвэр хураавар олон төслийнхөө үр өгөөжийг хэзээ хүртэж, зээлээ хэрхэн төлөх вэ. Хөгжихийн тулд бидэнд мөнгө хэрэгтэй ч ийм байдлаар ашиглаж, зарцуулбал дорвитой үр дүнд хүрэхгүй гэдгийг зарим эдийн засагч хэлж байна.

Өрийн бичиг арилжаалахгүйгээр шийдэж болох байсан уу

Манай улс өнгөрсөн 2011, 2012 онд нүүрс, зэсийн үнийн өсөлтөөс ахиу орлого олсон учраас төсвийн орлого нэмэгдсэн. Энэ үеэр гадаад, дотоодын томоохон хөрөнгө оруулагчдыг татаж төсөл хэрэгжүүлсэн нь эдийн засгийн эерэг нөлөөллийг бий болгосон. Харин 2012, 2013 онд томоохон шинэ эх үүсвэр гарсангүй. Өөрөөр хэлбэл, нүүрсний салбар хямарсан учраас өр тавих хэлбэрээр мөнгө оллоо. Манайх дээрх хоёр аргаар мөнгө олж буй ч хоорондоо асар их ялгаатай. Тухайлбал, төсвийн санхүүжилт хамгийн хямдхан гэж тооцогддог. Татвараас бүрддэг учир өрөнд ордоггүй. Харин гадаадын ➤

хөрөнгө оруулагчдын хувьд эрсдэлийг өөрсдөө хүлээдэг. Ямар нэгэн үйлдвэр дампуурлаа гэхэд бид эрсдэл үүрэхгүй. Дотоодын хөрөнгө оруулагчдын хувьд ч ялгаагүй. Хувийн хэвшлийнхэн л эрсдэл хүлээнэ. Өөрөөр хэлбэл, төр ачаа үүрэхгүй гэсэн үг. Харин бонд буюу улсын өрөөр санхүүжилт хийсэн үед төсөл нь үр өгөөжтэй байна уу, үгүй юу гэдэг нь маш чухал байх ёстой. Хувийн хэвшлийнхэн болон гадаадын хөрөнгө оруулагчид үр өгөөжөө өөрсдөө тооцон маш нарийн судалгаа хийдэг. Харин аливаа улсын хувьд эрсдэлийг тооцож, тодорхой бодлогын дагуу санхүүжилтээ хийх нь чухал байдаг аж. Энэ асуудал өнөөгийн тогтолцоонд дутагдаж буйг эдийн засагч Ч.Хашчулуун хэлж байна.

Энэ талаар тэрбээр “Бондын хөрөнгийг олон төсөл хөтөлбөрт зарцуулна гэсэн. Сонгож авсан төслүүдээ ямар үндэслэлээр сонгосон, тооцоо судалгаагаа хэрхэн хийсэн нь ойлгомжгүй байгаа. “Самурай” бондоор жишээ татъя л даа. Японы зах зээл маш том. Их хэмжээний хөрөнгөтэй ч үнэ нь харьцангуй бага байдаг. Манай улс Японоос зээл тусламж байнга авдаг ч бонд арилжиж байгаагүй. Тэд манайд нэг талаараа тусалсан. Хэвийн нөхцөлд “Самурай” бондыг гаргахыг зөвшөөрөхгүй байсан байх. Гэхдээ япончууд манай эдийн засгийг эрсдэлтэй гэж үзсэн байх ёстой. Учир нь, татварын орлогын тодорхой хувийг бүрдүүлдэг зэс, нүүрсний экспорт сайн биш. Төсвийн орлого бүрдүүлэх байдал нь хязгаарлагдмал. Ийм үед бонд арилжиж байгаа учраас эрсдэлийн баталгааны шимтгэлээ бөөнд нь авсан байх. Үүнийг төлөөгүй бол манай үнэт цаасыг Японы зах зээл дээр хэн ч авахгүй байсан. “Самурай” бондын зээлийн хүү бага. Японы санхүүгийн зах зээлийн онцлог нь ийм байдаг. Гэхдээ эрсдэл өндөртэй. Шимтгэлийг хүүндээ шингээвэл бас тийм ч хямдхан зээл биш. Төгрөгийн ханш сүүлийн үед эрчимтэй унаж байна. Энэ маш аюултай. Үүнээс зөв гарахын тулд Засгийн газар 2015 он гэхэд үр өгөөжтэй ажил хийх хэрэгтэй. Өнгөрсөн гурван жилд хэрэгжсэн томоохон төсөл алга. Зээлийн эргэн төлөлтийг эргээд хэн хариуцах юм бэ” гэв.

Импортыг орлож, экспортыг дэмжинэ

Засгийн газраас экспортыг дэмжиж импортыг орлох төсөл хөтөлбөрийг “Чингис” болон “Самурай” бондын хөрөнгөнөөс санхүүжүүлэхээр болсон. Энэ хүрээнд 888 төслийг санхүүжүүлэх боломжтой гэж үзжээ. Энэ талаар Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр “Эдгээр төслийн нийт санхүүжилт 7.3 их наяд, үүнээс төсөл санаачлагчдын хүссэн зээлийн хэмжээ 4.2 их наяд төгрөг буюу нийт төслийн дүнгийн 57 орчим хувьтай тэнцэж байгаа. Хамгийн өндөр өртөгтэй нь 285 тэрбумын төсөл байсан бол бага нь таван сая төгрөг байна. Зээлийг тав хүртэл жилийн хугацаатай төгрөгөөр олгоно. Хүү нь жилийн есөн хувиас хэтрэхгүй байх юм. Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 12 сараас доошгүй байна. Төсөл санаачлагч өөрийн сонгосон арилжааны банкинд хандаж зээлээ авч болно” гэв. Экспортыг дэмжих төсөлд ашигт малтмал, хүнд үйлдвэрлэл, малын гаралтай түүхий эд боловсруулах, хүнсний бүтээгдэхүүн, барилгын материалын үйлдвэрлэл зэрэг долоон салбарын төсөл иржээ. Импортыг орлох төслийн олонх нь барилгын материал, хүнд болон хөнгөн үйлдвэрлэл зэрэг найман салбарынх байна. Эдгээр төслийг хэрэгжүүлбэл 40 мянган ажлын байр шинээр бий болох тооцоог тус яамныхан гаргажээ. Дээрх төслүүд бүгдээрээ хэрэгжвэл жилд есөн их наяд төгрөгийн эерэг нөлөө үзүүлэх судалгааг Хөгжлийн банкнаас хийсэн байна. Гэхдээ бүгдээрээ хэрэгжих боломжгүй. Учир нь, төсөл санаачлагчдын хүссэн зээлийн эх үүсвэр манайд байхгүй. Нийт төслийн гуравны нэгийг “Чингис”, “Самурай” бондоос санхүүжүүлэх боломжтой гэсэн. Энэ хүрээнд нэг ам.долларыг гурав болгох зорилт тавьжээ.

Тэгэхээр нэг их наяд төгрөгт багтаан санхүүжилт хийнэ гэсэн үг. Үүнийг Ерөнхий сайд Н.Алтанхуяг хэлсэн. “Самурай” бондын 24.3 тэрбум иен 400 орчим тэрбум төгрөг аж. Үлдсэн 600 орчим тэрбумыг “Чингис” бондын эх үүсвэрээс гаргана

гэдгийг Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал А.Мөнхбат онцолсон. Мөн тэрбээр “Одоо байгаа бондын бүх эх үүсвэрийг үйлдвэржилтийг дэмжих төсөлд зарцуулна. Учир нь, “Самурай” бондыг гаргахдаа ийм зорилго тавьсан. Тэр утгаараа бондын хугацаа урт. Хүү нь маш бага буюу жилийн 1.52 хувь. 10 жилийн хугацаатай авсан уг бондын жилийн хүүнд бид 6-7 орчим тэрбум төгрөг төлнө. Энэ маш бага тоо. Японы олон улсын хамтын ажиллагааны банк манай санхүүгийн эрсдэлийг үүрч буй учраас үүндээ тохирсон хэмжээний хүүг бөөнд нь авсан. Энэ утгаараа бид зардал хэмнэж байна. Төсөл хөтөлбөр бэлэн болсны дараа санхүүжилт татах ёстой гэдэгтэй би санал нийлдэггүй. Учир нь, бонд арилжаалах эсэх нь тодорхойгүй байхад олон төсөл яриад яах вэ дээ. Манайхан байнга л төсөл ярьдаг. Хэрэгжүүлэх гэхээр санхүүжилт байхгүй гэдэг. Эх үүсвэрийг нь шийдчихээр төсөл хөтөлбөр байхгүй гэнэ. Одоо бид богино хугацаанд валютын урсгалд үр өгөөжөө өгөх салбарт анхаарах ёстой. Мөн төсөл хөтөлбөрүүд хувийн хэвшилд тодорхой хэмжээгээр үр нөлөөгөө өгөх эсэхийг чухалчилна. Тиймээс экспортыг дэмжих хөтөлбөр рүү эх үүсвэрээ чиглүүлэхээр ажиллаж байна” гэв.

“Самурай” бондыг банк хоорондын зах дээр байршуулжээ. ХААН, Худалдаа хөгжлийн банкны дансанд 24.3 тэрбум иенээ хуваан байршуулсан аж. Санхүүжүүлэх төсөл тодорхой болонгуут мөнгөө татаж, хөрөнгө оруулалт хийх гэнэ. “Чингис” бондын эх үүсвэрийг ч ийм байдлаар банкуудад байршуулж буй аж. Мөнгийг үр ашиггүй “хэвтүүлэх” нь бидэнд ашиггүй. Цаашид заавал бонд гаргаж хөгжих нь гол биш. Томоохон аж үйлдвэр, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлж эдийн засгаа тэлэхгүй бол өр тавьж, түүнийгээ үр дүнгүй ашиглаад байвал сүүлдээ зээл өгөх газар олдохгүй болох аюултай. Тиймээс урд хормойгоороо хойд хормойгоо нөхөн байж арилжсан бондоо “чулуу” болгох нь чухал байна. Яаж хөдөлгөхийг Засгийн газрын бодлого л мэднэ. ■

ТООН МЭДЭЭ

“Самурай” бондын хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийг байршлаар нь ангилсан байдал

	Төслийн тоо	Хүссэн зээлийн хэмжээ /сая төг/	Шинээр үүсгэх ажлын байрны тоо	4. Төсөл өртгөө нөхөх хугацаа /сараар/:	5. Бизнес төлөвлөгөө, Зах зээлийн судалгаатай
Улаанбаатар	524	1,185,957	18779	55	458
Дорноговь	15	747,185	1949	49	11
Дархан-Уул	32	417,736	4477	63	29
Орхон	33	376,541	2430	51	29
Төв	63	221,632	2136	52	56
Булган	15	159,312	732	56	15
Дорнод	11	154,020	2364	44	9
Өмнөговь	13	101,240	342	57	12
Хөвсгөл	9	94,410	411	53	8
Говь-Алтай	2	79,904	61	60	2
Говьсүмбэр	2	77,544	132	96	2
Дундговь	4	61,103	348	81	4
Сэлэнгэ	33	59,341	557	55	28
Баян-Өлгий	6	50,625	297	72	4
Ховд	19	45,754	501	66	17
Архангай	14	36,487	352	50	14
Увс	15	23,960	288	61	14
Баянхонгор	2	20,215	139	41	2
Өвөрхангай	8	8,787	712	53	8
Хэнтий	9	7,120	362	42	5
Тодорхойгүй	53	252,432	1454	52	46
Нийт / Дундаж	888	4,186,498	38912	55	778

Хүлээн авсан төслийн салбарын ангилал

	Төслийн тоо	Хүссэн зээлийн хэмжээ /сая төг/	Шинээр үүсгэх ажлын байрны тоо	Төсөл өртгөө нөхөх хугацаа /сараар/:	Бизнес төлөвлөгөө, Зах зээлийн судалгаатай
А. Экспортыг дэмжих	131	1,036,105	9743	53	113
1. Ашигт малтмал боловсруулах үйлдвэрлэл	16	626,135	2175	51	14
2. Хүнд үйлдвэрлэл	4	169,014	2753	59	2
3. Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр	47	127,459	2610	49	42
4. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	34	59,482	1368	57	30
5. Эм, эмнэлгийн үйлдвэрлэл	9	27,223	355	50	8
6. Хөнгөн үйлдвэрлэл	20	22,955	482	54	16
7. Барилгын материалын үйлдвэр	1	3,836	0	25	1
Б. Импортыг орлох	757	3,150,393	29169	55	665
1. Барилгын материалын үйлдвэр	210	1,655,104	11154	56	185
2. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	217	435,502	5749	58	196
3. Хүнд үйлдвэрлэл	67	307,106	3274	50	56
4. Химийн үйлдвэр	69	256,462	2336	50	57
5. Хөнгөн үйлдвэрлэл	141	230,631	5209	53	124
6. Эрчим хүч	4	131,880	138	120	3
7. Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр	25	90,219	598	48	23
8. Эм, эмнэлгийн үйлдвэрлэл	24	43,489	711	62	21
Нийт / Дундаж	888	4,186,498	38912	55	778

Эх сурвалж: ЭЗХЯ



“Улаанбаатарын хотын хүн ам өсөхийн хэрээр усны хэрэглээ мөн нэмэгдэж буй. Үүний дүнд Туул голын сав газраас нөхөн сэргээгддэг газрын доорх усны түвшин жил тутам 15 метрээр доошилж байна”

“Ногоон эдийн засгийн өсөлт” ТТБ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн З. Батбаяр



УСНЫ УХААЛАГ ХЭРЭГЛЭЭГ ТӨЛӨВШҮҮЛБЭ

1

Гэр бүл, хамаатан садан, найз нөхдөө усны талаар мэдлэгтэй болгож, усыг хэмнэх тухай сануулж байх

6

Угаалгын машинаа хэрэглэхдээ аль болох угаах юмаар дүүргэж, бага цаг зарцуулдаг хувилбарыг сонгох

2

Крантны ус шүүрч буй эсэхийг шалгах. Крантнаас шүүрсэн усны хэмжээ нэг сард хоёр тонноор хэмжигддэг

7

Крант болон шүршүүрний хошуунд ус хэмнэх төхөөрөмж суулгах

3

Усанд орохдоо аль болох ваннтай ус хэрэглэлгүй, шүршүүрт түргэхэн орох

8

Аяга, тавгаа автомат угаагчаар угаалгүй, аль болох гараараа угаах

4

Крантны ус тосох. Халуун ус иртэл гоожуулж буй усаа саванд тосч, дараа хэрэглэх

9

Ус хэмнэх зориулалттай шүршүүрний толгой, суултуур суулгах

5

Шаардлагагүй үед тухайлбал, шүд угаах, үсээ шампуньдах үедээ крантаа хааж хэвших.

10

Угаалгын машин зэрэг ус хэрэглэдэг цахилгаан хэрэгсэл худалдан авахдаа аль болох усны хэрэглээ багатайг нь сонгох



Ногоон Эдийн засгийн Өсөлт

төрийн бус байгууллага

www.greengrowth.mn

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

Ц.ДАШЦЭРЭН: ХӨГЖЛИЙН ХОЁР ДАХЬ ШАТАНД ОЛОН БАРИЛГА СҮНДЭРЛЭНЭ



"Мастер" группийн ерөнхий захирал Ц.Дашцэрэн

Д.БЭХЭЭ

"Бид таны орон сууцыг зарж, борлуулж өгнө" гэсэн зар сонинд гаргаж, ажлаа эхэлсэн бизнесмэн бол "Мастер" группийг үүсгэн байгуулагч, ерөнхий захирал Ц.Дашцэрэн. "Мастер проперти" энэ нэр Монголын үл хөдлөх хөрөнгийн худалдаа борлуулалтын зах зээлд зургаан жилийн өмнөөс орж ирж, өдгөө байр сууриа баттай эзэлжээ. Өндөр үнэтэй орон сууц, оффисын томоохон худалдаа борлуулалтыг тус компани л гүйцэтгэдэг. Үл хөдлөх хөрөнгийн худалдаа, үйлчилгээ, үнэ, хөгжлийн чиг хандлагын талаар Ц.Дашцэрэн захиралтай ярилцлаа.

-Танай группийн охин компани "Мастер проперти" бизнес, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн борлуулалт, худалдааны 41 хувийг эзэлж байгаа статистик мэдээлэл байна. Амжилтад хөтөлсөн нууцаасаа хуваалцана уу?

-Манай хамт олны хувьд том амжилт. Товчхон хэлбэл, бид маш их хөдөлмөрлөдөг. Амралтын хоёр өдөр ч ажилладаг. Бидний хүсэл мөрөөдөл, зорилго олон улсын стандартыг сурч эзэмшээд эх орондоо нэвтрүүлж, эргээд олон улсын зах зээлд гарч ажиллах. Ийм зорилго тавьсан хүмүүс сайн ажиллахаас өөр аргагүй. Мөн бид оюутнууд, суралцагч. Том компаниудаараа бахархдаг. Үндэсний томоохон компаниудын удирдлага, шилдэг менежерүүдээс зөвөлгөө авч, санал бодлоо хуваалцаж, тэднээс үлгэр дууриал авч ажилладаг. Монголын үл хөдлөх хөрөнгийн худалдааны зах зээлд өнөөдөр 20 гаруй компани тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Тэдний ихэнхийг нь манай компаниас ажлын гараагаа эхэлсэн хүмүүс удирдаж байна.

-Компани анх байгуулагдах үеийн эдийн засгийн байдал өнөөдөр хэр өөрчлөгдсөн бол?

-2007 онд компани маань хоёр ажилтантайгаар байгуулагдсан. Жилийн дараа хэвлэлд анхны рекламаа үнэгүй өгч байлаа. Тэгвэл өнөөдөр манай компани зар сурталчилгааны зардалд жилдээ багагүй мөнгө зарцуулдаг болжээ. Улс орны нийгэм, эдийн засгийн байдал ч мэдээж өөрчлөгдсөн. Үл хөдлөх хөрөнгийн худалдааны тухай ойлголт өөр болж, эрчтэй хөгжсөн. Улс нь ч, компани нь ч, хэрэглэгч нь ч хөгжиж байна. Бусад манайхтай ижил төстэй орныхтой харьцуулахад энэ салбарын хөгжил өндөр түвшинд хурдтай явж байна гэж үзэж болно. Манай хөрөнгө оруулагч Швейцариас ирээд "Та нар Туркменестан, Дундад Азид ийм төрлийн бизнес хийх боломж байна. Үл хөдлөх хөрөнгийн худалдааны бизнесийг зааж, сургах түвшинд ажиллахаар байна" гэсэн. Бид урамшаад улам илүү сайн ажиллахыг хичээж байгаа.

-Үл хөдлөх хөрөнгийн борлуулалт, худалдааны хууль, эрх зүйн орчин манайд ▶

► хэр бүрдсэн бэ?

-Нэг сайн, нэг муу зүйл байна. Үл хөдлөх хөрөнгө өөрөө өндөр үнэтэй. Манай улсын хувьд өмчлөх талаасаа зохицуулагдсан, харин худалдааны харилцаа нь бараг л зохицуулагдаагүй гэж хэлж болно. Тиймээс энэ бизнес эрх чөлөөтэй ч юм шиг, хоорондоо тохиролцоод л, өөрөөр хэлбэл, яаж ч тайлбарлаж болох талтай. Шүүхэд очлоо гэхэд баримтлах хуулийн яг таг нарийн заалтгүй гэсэн үг. Гадаадад Үл хөдлөх хөрөнгийн худалдааны тухай хуулиар зохицуулдаг. Энэ нь худалдаачдад нэмэгдэл төлбөр төлүүлэх гээд байгаа хэрэг биш л дээ. Үл хөдлөх хөрөнгө нь иргэдийн амьдралдаа 4-5 удаа хийдэг том асуудал учир эрсдэлгүй хариуцлагатай байх тогтолцоог бүрдүүлсэн өгсөн эрх зүйн бодлого юм. Улсдаа ч сайн үр дүнтэй. Тэгэхээр бид эрх чөлөөтэй бизнес эрхэлж байна гээд дураараа явахыг хүсээгүй. Дээрх 20 компанийн төлөөлөл хамтран Үл хөдлөх хөрөнгийн худалдаа борлуулалтын холбоо байгуулж зохих ёсны хуулийн зохицуулалтыг бүрдүүлэхэд анхаарахаар ажиллаж байна. Англи, Америкийн бэлэн туршлагыг эх орны хөрсөнд нутагшуулах л тухай юм. Түүнээс өөр шинэ зүйл сурах гээд явах хэрэггүй. Эрх зүйн орчныг бүрдүүлснээр тоглоомын дүрэм илүү тодорхой болно. Гаднын өндөр хөгжилтэй орнуудад үл хөдлөх хөрөнгийн худалдаа, санхүүжилт, бүтээн босголт, барилгын уялдаа холбоог маш нарийн судалж зохицуулсан байдаг. Энд бид хувь нэмрээ оруулна гэж бодож байгаа.

-Үл хөдлөх хөрөнгийн бизнесийн хөгжил манай улсад ямар шатанд явна вэ?

-Улс орнуудын хөгжлийн хэд хэдэн шатлал байна. **Нэгдүгээрт**, ямар нэг зүйлээс мөнгө олох. Монгол Улсын мөнгө олох гол салбар нь уул уурхай. **Хоёрдугаарт**, дээрх ямар нэг зүйлээс олсон мөнгө нь тухайн улсын үл хөдлөх хөрөнгийн салбарыг хөгжүүлдэг. Мөнгө хоёр л зүйлд зарцуулагддаг. Нэг нь үл хөдлөх хөрөнгө, нөгөө нь үйлчилгээний салбар. Үл хөдлөх хөрөнгө ба хэрэглээ гэж томъёолж болох. Олсон мөнгөө хэрэглээнд зарцуулсан улс хөгждөггүй юм байна. Үл хөдлөх хөрөнгийн хувьд үнэтэй ч мөнгө хий

хоосон үрэгдээд алга болохгүй гэсэн үг. Ингээд хөгжлийн хоёр дахь шатанд улс орнуудад олон байшин баригдаж сүндэрлэнэ. Хөгжлийн гурав дахь шатанд тухайн үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан баталгаажсан үнэт цаас гаргаж эхэлдэг. Англи, Америк, Японы хөгжил энэ жишгээр явж үнэт цаасны арилжааны бизнес хүчтэй хөгжсөн байдаг. Үнэт цаас нь өөрөө санхүүгийн том хөшүүрэг. Тэгэхээр манай улс бусдын замналаар зөв жишгээр гэхдээ нэлээд хурдтай явж байна. Байшин барилга олноор баригдаж байна. Хөгжлийн хоёр дахь шатны эхлэлийг эрчимтэй тавьж байна гэж ойлгож болно.

-Энд тэндгүй олон барилга баригдаж хөгжиж буй мэт харагдавч чанар талаас харахаар их хэцүү шүү дээ.

-Хамгийн хүнд сэдэв энэ л дээ. Манай судалгааны ахлах мэргэжилтэн Японоос Улаанбаатар руу нисч ирэхдээ нэг хонгконг хүнтэй танилцсан байна. Тэр манайд баригдсан шинэ орон сууцны насжилтын судалгаа хийж байгаагаа ярьж. Бид их гайхсан. Салбарт нь ажилладаг мөртлөө энэ тухай бодоо ч үгүй байсан. Санаа зовж эхэлсэн. 2001-2008 онуудад баригдсан барилга хяналт сул байсан тул чанар талд хэлэхэд бэрх. Бахархмаар жишээ ч бий. Чанарын хувьд ямар ч ойлголцол тохиролцоо байх ёсгүй. Засгийн газрын бодлого үүнд чиглэх ёстой.

Өнгөрсөн хоёрдугаар сарын мэдээгээр 204 төслийн 37000 айлын байр зах зээл дээр борлуулагдаж. Одоо энэ тоо нэлээд нэмэгдсэн. Энэ нь өрсөлдөөнийг харуулна. Өрсөлдөөн чанарыг сайжруулж, үнийг тодорхой хэмжээгээр барина. Социализмын үед барьсан хуучин барилгуудын дулаалгыг цогцоор шийдэх хэрэгтэй байна. Эдгээр хуучин барилга, тэр Дорж, Готов нарын 100 сая төгрөгийн байр чинь нийлээд Монгол Улсын өмч. Дараагийн хөгжлийн суурь бонд үнэт цаасны баталгаа болно. Хэн нэгний байр гэхээсээ илүүтэй үндэсний баялаг хэмээн харж хандаж, анхаарч ажиллаж, амьдрах нь зөв.

-Монголд орон сууц, оффис өндөр үнэтэй. Зарим хүн 100 сая төгрөгөөр Америкт хоёр давхар хаус барина гэх. Орон сууцны үнэ цаашид өсөх

үү, буурах уу?

-Аль ч улс үндэстэнд баячуудын хороолол байдаг. Америк, Лондон, Японд өндөр зэрэглэлийн тансаг үнэтэй хороолол бий. Америкт үл хөдлөх хөрөнгийн зуучийн бизнес эрхэлдэг монгол надад хэлж байсан. "Америкийн баячуудын хорооллыг очиж үзээгүй монгол энд ирээд худлаа яриад байгаад гайхаж байна" гэсэн. Налайхын наана байх хорооллын орон сууцны үнийг хотын төв дэх үнэтэй харьцуулж үзэж болохгүй. Тухайн улсын тансаг зэрэглэлийн байрыг тэр орных нь тансаг зэрэглэлийн байрны үнэтэй л харьцуулах ёстой. Оффисын байрыг ч мөн адил.

Манай компани үл хөдлөх хөрөнгийн худалдаа, үнийн талаар таван жилийн турш судалгаа хийж ирсэн. Судалгааны сайн мэргэжилтнүүдтэй, хамгийн сайн судалгаа хийдэг гэж би боддог. Бид 2010-2016 он хүртэлх Улаанбаатар хотын үл хөдлөх хөрөнгийн судалгааг хийсэн. Одоо 2020 он хүртэлх эдийн засгийн хөгжлийн ерөнхий хандлага, үл хөдлөх хөрөнгийн салбарт нөлөөлөх судалгааг хийж байна. 30-40 улсын судалгааг харьцуулан харвал манайтай ойролцоо хөгжил, ДНБ-тэй улсын орон сууцны ам.метр талбайн дундаж үнэ 2000 ам.доллар байна. Манайд бол 1200-1300 ам.доллар. Энэ тоо цаашид өснө. Судалгаагаар 2016 он гэхэд орон сууцны ерөнхий дундаж өсөлт 16 хувьтай нэмэгдэхээр гарсан. Үл хөдлөх хөрөнгийн үнэ өсдөг нэг л шалтгаан бий. Улс орны эдийн засаг хөгжиж, мөнгөний хэмжээ нэмэгдвэл үл хөдлөх хөрөнгийн үнэ дагаад өснө.

Судалгаагаар орлого багатай ерхийнхөө амьжиргааг дэмжих бодлогыг аль ч улс орны засаг төр шийддэг. Тухайлбал, манай Засгийн газраас тодорхой бүлэгт чиглэсэн орон сууцны ам.метр талбайн үнийг 1280 төгрөг гэж тогтоолоо. Энэ бол сайн үнэ. Гэхдээ Монголын бүх байр ийм үнэтэй байна гэж ойлгож болохгүй. Засгийн газар байр худалдан авч дийлэхгүй зорилтот бүлэгт чиглэсэн үнийг тогтоож бага орлоготой иргэдээ дэмжиж байна. Түүнээс бусад зэрэглэлийн үнийг хэн ч, ямар ч төр тогтоож чадахгүй. Зах зээлийнхээ жамаар явдаг асуудал юм. ►

► **-2016 он хүртэл орон сууцны үнэ дунджаар 16 хувиар өснө гэж ойлгож болох уу?**

-Бүх орон сууцны үнэ ийм хувиар өснө гэж байхгүй. Жигнэсэн дундаж өсөлт. Зарим байрны үнэ өсөж, зарим нь буурна. Бүр үнэгүйдэх ч байр бий. Байр үнэ цэнэтэй байхын тулд зөвхөн тухайн орон сууц бус, үйлчилгээ, байршил, засвар тордлого гэх мэт зүйлс нөлөөлдөг. Гаднын орнуудад тухайн байшинг 100 жилийн турш үнэ цэнэтэй байлгахын тулд хууль эрх зүйгээр бүгдийг зохицуулсан байдаг. Нэг төгрөгөөр ч авахгүй байр байна. Манай компани герман зөвлөхүүдтэй. Бүтэн хорооллыг маш хямдхан үнээр зарж байсан гэсэн. Тэгвэл нөгөө талдаа хэсэг байрны үнэ 20-30 хувиар өснө. Үл хөдлөх хөрөнгийн хамгийн эхний тоглоомын дүрэм бол хэн ч хэнийг ч хуурч мэхэлж чадахгүй. Тэгэхээр үл хөдлөх хөрөнгөтэй хүн хөрөнгөө сайн үнэлж цэгнэх хэрэгтэй.

-Үл хөдлөх хөрөнгийн худалдаагаар мэргэшсэн компанийн удирдлагын хувиар орон сууц худалдаж авах талд манай иргэдэд зөвлөгөө өгнө үү?

-Нэгдүгээрт, мэргэшсэн компанийн ажилтнуудаас зөвөлгөө заавал авах хэрэгтэй. Эхлээд байшингаа бус байршлын зөвлөгөө аваарай гэж

анхааруулж хэлмээр байна. Ирээдүйд үнэ хүрэх, эсвэл үнэгүйдэх байршил гэж бий. Нэг төгрөгийн ч үнэгүй болох байршлыг анхааран судлах хэрэгтэй. Хүүхэд хаана тоглох, эмээ өвөө нар хаана амарч суух, орой шөнө явахад хир тохиромжтой, агаарын байдал ямар байх, автобусны буудал хэр хол байгаа зэрэг судалгааг маш сайн хийх шаардлагатай. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний 50-иас илүү хувь нь байршил, тухайн байшин бол 50-иас доош хувьд л орно. Манайхан байшингаа л голлоод гял цялд нь хууртагддаг тал бий. **Хоёрдугаарт**, Байшин. Тухайн орон сууц барьсан барилгын компанийн удирдлагыг сайн судлах. Ямар ч захирлын бодлого, хэв шинж, сэтгэл, үзэл барьсан барилгад нь туссан байдаг. Сэтгэлээсээ барьсан, мөнгө олох гэж, таньдаг найз нөхдөөрөө дамжуулан зөвшөөрөл аваад босгосон барилгууд хоорондоо газар тэнгэр шиг ялгаатай. Байшингийн үндсэн тулгуур хийц муу бол хичнээн сайхан гял цял байгаад ч нэмэргүй. Үнэхээрийн сайн чанартай байшин худалдаад авбал та тэр гял цялыг бий болгож болно. Барилгын үндсэн хийцийн чанар маш чухал. **Гуравдугаарт**, орон сууц худалдаж авах өөрийн санхүүгийн бололцоо боломжийн талаар санхүүгийн байгууллагаас зөвлөгөө авах хэрэгтэй. Боломжоо тооцоолоогүйгээс

гэрээнүүд олноор цуцлагддаг. Урьдчилгаагаа өгчихье. Тэгээд болно доо гэсэн монголчуудын тооцоолох бус сэтгэлгээг халах хэрэгтэй. Байршил, чанар, санхүүжилтийн эх үүсвэрээ л сайн судлах хэрэгтэй.

-Япончуудын барьсан барилга сайн, хятадуудынх тийм гэх хандлага иргэдийн дунд бий. Үүнийг хэрхэн таньж мэдэх вэ?

-Компаниудын маркетингийн бодлоготой холбоотой л доо. Чанарын хяналт сайн тавьж, санхүүжилтийг гэрээгээр сайн хийгээд явсан компанийн барилга чанартай сайн гүйцэтгэлтэй байдаг. Япончуудын барьсан барилга сайн гэдэг ойлголт дэлхий даяар бий. Тэд санхүүжилтийг ном ёсоор нь хийж, хяналтыг дээд зэргээр тавьдаг улс. Өнөөдөр монгол компаниуд барилгыг сайн барьж сурч байна. Монголдоо байшин барьж сурч, туршлагажаад гадагш барихаар төлөвлөж байна. Энэ бол сайн зүйл.

-Танай салбарын онцлог, мөн хүндрэлтэй зүйл юу байна вэ?

-Энэ нь миний дуртай ажил мөрөөдөл юм. Үнэнээ хэлэхэд бэрхшээл тулгардаггүй гэж хэлж болно. Учир нь би энэ ажилдаа дуртай учраас зарим нэг тулгарах асуудлыг бэрхшээл гэж хардаггүй байх. Бизнес мэдээж асуудал байнга гарна. Асуудал



Улс орны эдийн засаг хөгжиж мөнгөний хэмжээ нэмэгдвэл үл хөдлөх хөрөнгийн үнэ дагаад өсдөг

► байгаа нь өөрөө бизнес гэж ойлгодог. Хамгийн гол нь түүнийг даван туулах, амжилттай шийдвэрлээд явах хэрэгтэй гэж ойлгодог. Миний хувьд заримдаа төрдөө баярлалаа гэж хэлмээр санагддаг юм. Учир нь эрх зүйн тодорхой зохицуулалт байхгүй тул төрийн зүгээс хорьсон хаасан хүндрэл учруулах асуудалгүйгээр өнгөрсөн хугацаанд ажиллаж ирлээ. Харин бид өөрсдөө ийм чөлөөтэйгээр цааш явж болохгүй гэж үзээд эрх зүйн орчныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах хүсэлтэй явж байна. Харин иргэдийн зүгээс үл хөдлөх хөрөнгийн худалдааны бизнесийг анхлан ойлгодоггүй, дундаас нь их мөнгө завших нь хэмээн бодож биднийг үздэггүй байлаа. Зургаан жилийн өмнөхийг өнөөдөртэй харьцуулахад өдөр шөнө шиг ялгаатай байна. Үл хөдлөх хөрөнгийн салбар хөгжих тусам манай бизнесийг иргэд сайн ойлгож, ухаарч, хамтарч ажилладаг болно.

Өнгөрсөн хугацаанд нэлээд туршлага хуримтлуулж, хэрэглэгчид ямархуу төрлийн үйлчилгээ хүсдэг, ямар орон сууцтай болохыг боддог, ямар аргаар мөнгөө төлөх хүсэлтэйг нь сайтар ойлгодог болжээ. Бид өр нь хамгийн хэцүү цэг дээр ажилладаг. Хүнээс мөнгө салгах хэцүү шүү дээ. Барилгын компаниудын захирлуудын нэг сул тал нь өөрсдийн мөрөөдлөөр барилга барьдаг. Гадаад үзэмж, орон сууцны өнгөц харагдах байдалд түлхүү анхаардаг. Тэгвэл миний бодлоор барилгын компаниуд иргэдэд орон сууц худалдахаа бодож, өндөр үнэд хүргэх ашгаа тооцоолж, тухайн өрхийн, хүсэл мөрөөдлийг судлаад баривал үр дүнтэй. Ямархуу байр сонирхоод байгаа юм, ямар загвартай, мөнгөний хэмжээ хэр юм, мөнгөө хэрхэн төлөх бодолтой байгааг нь сайн судлах шаардлагатай. Барилгын 51 хувиас багагүй нь судалгаа, хэнд хэдээр, ямар аргаар борлуулах, худалдахыг судлахад чиглэдэг.

-Үл хөдлөх хөрөнгийн мэргэшсэн боловсон хүчин гэж байдаг уу?

-Мэргэшсэн боловсон хүчин байхгүй л дээ. АНУ-д реалторийн лиценз олгодог. Энэхүү лицензийг авахын тулд шаталсан сургалтад хамрагддаг. Тэгээд Үл хөдлөх хөрөнгийн холбоо

нь лиценз өгдөг. Бид холбоогоороо дамжуулан лицензжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ гэж бодож байгаа. Одоо бол гаднын туршлагаас, бие биенээсээ суралцаад явж байна. Би л гэхэд эрх зүйч мэргэжил эзэмшсэн хүн.

-Дэлхийн үл хөдлөх хөрөнгийн хөгжлийн чиг хандлага ямар байна вэ?

-Дэлхийн зах зээл өөр өөр л дөө. Би нэгдүгээр сард Давосын эдийн засгийн чуулганд оролцоод ирсэн. Тэгэхэд өндөр хөгжсөн улсуудад проперти зах зээл дууссан гэж байсан. Манай компани итали, германчуудтай ажиллаж байсан. Тэдгээр улсад 15-20 жил энэ бизнесийн худалдаа идэвхтэй үргэлжилсэн байна. Хөгжлийн гуравдугаар түвшинд гараад ирэхээр санхүүгийн зах зээлд түшиглэсэн бизнес хийдэг тухай дээр ярьсан. Хөгжилтэй орнуудад барилга баригдаж байгаа, гэхдээ бага. Харин ЗМ буюу Монгол, Мьянмар, Мозамбик улсад үл хөдлөх хөрөнгийн бизнес хамгийн хүчтэй хөгжиж байна. Анголд үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхэлдэг Израйлийн бизнесмэнтэй уулзахад Анголд манайхны хэлдгээр амбаар мэтийн орн сууцны ам.метр тайлбайн үнэ 5000 ам.доллар.Түрээсэлбэл бүр үнэтэй тухай ярьсан. Тэгвэл бид "Blue Sky" тауэрийн 150 ам.метр талбайг нэг тэрбум 800 орчим сая төгрөгөөр борлуулж байсан. Монголын хотын төвийн хамгийн үнэтэй байршил дахь байрыг мөнгөөр Анголд нэг муу байшин авах нь гэсэн үг. Үл хөдлөх хөрөнгийн худалдааны бизнес ойрын 100 жилд эрчимтэй хөгжинэ.

-Давосын эдийн засгийн чуулганд оролцсон бизнесмэн тэндээс юуг олж хардаг вэ?

-Хөгжлийн, бизнесийн ирээдүйн чиг хандлага нь зөв явж буй улс орныг нэлээд дэмжиж өгдөг нь харагдсан. Монголчууд сайн зүйлээ сайнаар ярьдаг, эх орноороо бахархдаг болмоор байна. Давосын чуулганы үеэр олон бизнесмэнтэй уулзаж, танилцаж, ажил хэргийн холбоо тогтоож, тэдгээр бизнесмэнийг Монголд урьсан. Бүгд ирнэ гэсэн. Монголыг сонирхож байна. Монгол дэлхийн нэг хэсэг болжээ. Давосын

эдийн засгийн чуулганы 2013 онд дэлхий улс орнуудад болсон нийт хүлээн авалтын хамгийн гоё нь Монголынх байсан гэж олон хүн хэлсэн. Бахархаж байлаа. Энэхүү чуулганд боломж нь байвал Монголын бизнесмэнүүд олноор оролцоосой. Дэлхийн баялаг бүтээж яваа шилдэг бизнесмэнүүд оролцдог, харилцаа холбоо тогтоодог, хамтын бизнесийн гэрээ хэлэлцээрийг биечлэн гэхдээ удирдлагуудтай хийх боломжтой.Тэнд танилцах нь маш чухал, нэр хүнд, өөрийгөө илэрхийлэх баталгаа, бизнесийн том гарц юм билээ. Давосын чуулганд сайн бэлтгэлтэй очвол ганзага хоосон ирэхгүй шүү. Миний хувьд анх удаа оролцсон бөгөөд үл хөдлөх хөрөнгийн худалдааны бизнесээрээ Швейцарийн том банктай хамтын ажиллагаа эхлүүлэхээр ярьж, бодит ажил болгоод байгаа нь Давост очсоны үр дүн юм.

-Танай компани анх "Мастер травел" буюу англи хэлний сургалтаар гарч ирсэн. Өнөөдөр бизнесийн өөр ямар үйл ажиллагаа явуулж байна вэ?

-Тиймээ, анх хэлний сургалт, гадаадад англи хэл сурах зуучийн бизнес эрхэлж байлаа. Өнөөдөр "Мастер травел"-ийг аялал жуулчлал, энтертаймент чиглэлээр хөгжүүлэхээр төлөвлөж байна. Бид үл хөдлөх хөрөнгийн судалгаа, худалдаа, зөвөлгөөний үйлчилгээнээс гадна манай охин компани "Мастер девелопер" нь бүтээн байгуулалтын, "Монголиан мортгэйж фанд" нь санхүүжилтийн бизнесийн үйл ажиллагаа явуулж байна.

"Мастер пропертис" нь түлхүү өндөр үнэтэй орон сууцны зах зээл дээр ажилладаг, хөрөнгө худалдаж борлуулдаг. Мөн анхныхаа оффис төслийг хэрэгжүүлж эхлээд байгаа нь бидний амжилт. Хэд хэдэн судалгаа, хэлэлцүүлэг, 150 орчим компанийн судалгаагаар гуравдугаар сургуулийн орчимд оффисоо барихаар барилгын ажлыг эхлүүлээ.

Эцэст нь бидэнд тусалж, дэмжиж, сайн зөвөлгөөг харамгүй өгдөг бүх хүнд баярлаж талархсанаа танай сэтгүүлээр дамжуулан хэлье. ■


СУДАЛГАА

Үл хөдлөх хөрөнгийн худалдаа эрхэлдэг “Мастер Пропертис” компаниас гаргасан энэ оны гуравдугаар сарын үл хөдлөх хөрөнгийн сарын тоймыг товчлон хүргэж байна.


Нийт орон сууц ашиглалтад орох хугацаагаар

	Төслийн тоо	Айлын тоо	Дундаж үнэ
Ашиглалтад орсон	78	9.991	2.321.4
2014-Q1	29	6.959	2.434.4
2014-Q2	38	6.395	2.201.9
2014-Q3	15	1.979	1.832.6
2014-Q4	18	5.335	2.218.2
2015-Q1	7	2.360	3.381.0
2015-Q2	2	300	2.963.9
2015-Q3	2	284	1.850.3
Нийт	189	33.603	2.353.0


Орон сууцны 1м²-ын дундаж үнэ, дүүргээр




Дундаж үнийн өсөлт, дүүргээр (%)



Зэрэглэл тус бүр, айлын тоогоор



Зэрэглэл тус бүр, мөнгөн дүнгээр /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Мастер Пропертис

Хуучин орон сууцны үнэ

Хүснэгт 2.1. Хуучин орон сууцны нийт үнэ(сая.төг), дүүргээр							
	1 өрөө	2 өрөө	3 өрөө		1 өрөө	2 өрөө	3 өрөө
Баянгол дүүрэг				Сүхбаатар дүүрэг			
3-р хороолол	78.1	118.7	140	11-хороолол	82.5	131.7	159.3
4-р хороолол	72.5	123	145.7	7-р хороолол	72	88.3	128.6
10-р хороолол	69.9	101	115.1	5-р хороолол	89.3	140	211
Төмөр зам	79.6	112.5	151	220-н мянгат	69.8	181.9	221.5
6-р бичил хороолол	78	110	150	50-н мянгат	78.5	140	220
Дундаж	75.6	113.1	140.3	Дундаж	80.6	125	179.7
Чингэлтэй дүүрэг				Хан-уул дүүрэг			
Бага тойруу	91	147.5	158.7	19-р хороолол	62	132.3	168.4
40 мянгат	74.5	121.3	160	120 мянгат	86.3	116	237.8
6-р хороолол	79.5	135	155	Нисэх	58.5	88	100
Дундаж	81.7	134.6	157.9	Дундаж	68.9	112.1	168.7
Сонгинохайрхан дүүрэг				Баянзүрх дүүрэг			
1-р хороолол	96.5	104.5	147.7	15-р хороолол	73.5	100	139
21-р хороолол	62	84.7	106.6	13-р хороолол	71.8	125.5	153.8
5 шар	51.8	77.7	93	16-р хороолол	71	109.3	116
ХМК	71	109.3	116	12-р хороолол	70	140	205.1
Дундаж	70.3	94.1	115.8	Дундаж	71.6	118.7	153.5
Хүснэгт 2.2. Хуучин орон сууцны 1м/ын дундаж үнэ(сая.төг), дүүргээр							
	1 өрөө	2 өрөө	3 өрөө		1 өрөө	2 өрөө	3 өрөө
Баянгол дүүрэг				Сүхбаатар дүүрэг			
3-р хороолол	2.26	2.38	1.89	11-хороолол	2.7	2.49	2.08
4-р хороолол	2.19	2.37	2.01	7-р хороолол	1.9	1.99	1.8
10-р хороолол	2.5	2.1	1.94	5-р хороолол	2.8	2.8	2.7
Төмөр зам	2.17	2.19	2.09	220-н мянгат	2.0	2.9	2.8
6-р бичил хороолол	2.5	2.1	1.94	50-н мянгат	2.53	2.3	2.4
Дундаж	2.33	2.19	1.96	Дундаж	2.41	2.473	2.24
Чингэлтэй дүүрэг				Хан-уул дүүрэг			
Бага тойруу	2.6	2.5	2.21	19-р хороолол	3.0	2.6	1.84
40 мянгат	2.4	2.6	2.12	120 мянгат	2.5	2.3	2.5
6-р хороолол	2.5	2.4	2.13	Нисэх	1.7	2.1	1.73
Дундаж	2.5	2.5	2.15	Дундаж	2.4	2.3	2.02
Сонгинохайрхан дүүрэг				Баянзүрх дүүрэг			
1-р хороолол	2.44	2.20	1.87	15-р хороолол	2.37	1.92	1.83
21-р хороолол	1.91	1.61	1.65	13-р хороолол	2.27	2.37	2.14
5 шар	1.65	1.81	1.57	16-р хороолол	2.09	2.03	1.61
ХМК	1.25	1.5	1.8	12-р хороолол	2.92	2.19	2.3
Дундаж	1.81	1.78	1.72	Дундаж	2.41	2.13	1.97

Эх сурвалж: Мастер Пропертис

ХӨДӨӨ АЖ АХУЙ

ЭРЧИМЖСЭН АЖ АХУЙГ ХӨГЖИМЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

С.АЗ

Сумын төвөөс зайдуухан тал газарт байшин барилга сүндэрлэжээ. Хэдэн метр үргэлжилж буй нь үл мэдэгдэх төмөр сараалжин хашааны захад байшин байх. Хашааны гадна талд амины тохилог орон сууцтай юм. Холоос харсан хүнд тосгон, багийн төв мэт харагдахаар энэ газарт “Хишигтэн Нүүдэлчин” компанийн үхрийн фермерийн аж ахуй байрлах аж. Тус компани Төв аймгийн Архуст суманд 4186 га газар авч, газар тариалан, үхэр, адууны аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлжээ. Тэд өнгөрсөн онд 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж Франц улсын мах-сүүний хосолмол ашиг шимт “монтбейльярд” үүлдрийн 150 үнээ, таван бух авчран ферм байгуулсан нь энэ аж. Зах зээлийн нийгэмд шилжсэнээс хойш манай улс эрчимжсэн мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх талаар ярьж байгаа ч гарт баригдахаар ажил хийсэн нь цөөхөн. Үнээний фермтэй аж ахуйн нэгж болон хувь хүн бий ч хөрөнгө мөнгө, төрийн дэмжлэг туслалцаа

муугаас төдийлэн хөгжиж чадахгүй байгаа. Харин “Хишигтэн Нүүдэлчин” компани үнээний аж ахуйг цогцоор нь байгуулахаар зорьсон байна. Сүүлийн үед зохиомол хээлтүүлэг үр дүнтэй байгаа ч тус компанийнхан судалгаа шинжилгээ хийсний дүнд биологийн нөхцөлөөр хээлтүүлэх нь зөв гэж үзэн таван бух оруулж иржээ. Тэд 30 үнээнд нэг бух байхаар тооцож. Үнээнүүд Монголд ирээд жил болох гэж буй аж. Энэ хугацаанд ихэнх нь тугалласан бөгөөд Монголын эрс тэс уур амьсгалд дасан зохицох чадвартай гэдгээ харуулжээ.

Мах, сүүний чиглэлийн “Монтбейльярд” үүлдрийн үнээнүүд тарга тэвээрэг сайн авдаг, сүүний өндөр гарцтай, туурай, хөл аарцгийн хөгжил сайтай аж. Тэд цаашид сүүний үхрийн фермерийн аж ахуйгаа өргөжүүлж, өөр үүлдрийн үнээ оруулж ирэхээр судалж буй гэсэн. Учир нь, тус компани Монголын фермерүүдийг

дэмжиж, хамтарч ажиллах зорилго тавиад байгаа аж. Энэ талаар “Хишигтэн Нүүдэлчин” компанийн гүйцэтгэх захирал Ж.Баттөгс “Бид энэ зах зээлд ганцаараа байх гэж оролдохгүй. Үлгэр жишээ үнээний аж ахуй олныг байгуулах, ийм фермтэй болохыг хүсч байгаа хүмүүст зуучлах болно. Өөрөөр хэлбэл, технологийн шаардлага хангасан байрыг нь барьж, үнээнүүдийг оруулж ирэх, тэжээлийн ургамлыг нь тарьж, холбогдох тоног төхөөрөмжийг нийлүүлж чадна. Энэ хүрээнд бид олон ажил хийж эхэлсэн. Тухайлбал, сургалтын төв байгуулахаас эхлээд Германы тоног төхөөрөмж нийлүүлдэг компанитай дунд хугацааны гэрээ байгууллаа. Мөн Голланд, Францын үхэр ▶



► нийлүүлэгчидтэй хамтран ажиллахаар болсон. Энэ нь үхрийн өртгийг хямдруулах, үргүй зардлыг багасгах зорилготой” гэв.

Тус компани энэ жил дахин 150 үнээ оруулж ирэн, Архуст суманд байрлах үнээнийхээ байрыг өргөтгөхөөр төлөвлөжээ. Барууны орнуудын фермүүдэд байдаг бүх төрлийн техник, хэрэгслийг ашиглаж буй аж. Тэд хүний хөдөлмөрийг хөнгөвчлөхийн тулд олон үйлдэлт ачигч, тэжээл тараагч болон өвс цацагч машин ашиглаж байна. Мөн хамгийн сүүлийн үеийн саалтуурын системийг авчирч суурилуулж буй гэсэн. Энэ ажил дуусвал бүх ажиллагаа автомат болох юм байна. “монтбейльярд” үүлдрийн үнээг найман жил саамаа өгсний дараа махны чиглэлээр ашиглаж болох аж. Нэг үнээнээс хоногт 25 литр саам авах боломжтой. Гэхдээ эхний тугаллалтаар буюу гунжин үхэр нийт гаргах сүүнийхээ 70 хувийг гаргадаг байна. Тиймээс үнээнүүд одоо хоногт 14-15 литр сүү өгч буй аж. Харин хоёр жилийн дараа 25 литр болох юм. Нийт 150 үнээний нэг өдрийн саам нь хоёр тонн орчим болдог байна. Үүнийгээ ТЭСО компанид нийлүүлж буй аж.

Нийслэлд жилд 150-160 орчим сая тонн литр сүү шаардлагатай гэх судалгаа бий. Энэ хэрэгцээний ихэнхийг хуурай сүүгээр орлуулж байгаа. Харин “Хишигтэн Нүүдэлчин” компани нийт зах зээлийн 2-3 хувийг хангах аж. Тиймээс үнээний энэ мэт ферм олон байгуулах хэрэгтэйг хэлж байсан. Тэгвэл дотоодын сүү, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлт сайжирч, импортын хуурай сүүг хязгаарлах алхам болох юм. Менежментээ зөв хийж чадвал Монголд сонгодог утгаараа эрчимжсэн мал аж ахуй хөгжих учиртай. Үхрийг зуны саруудад бэлчээрт гаргаж, өвөлд тэжээнэ. Гэтэл Европт өглөө оройгүй тэжээдэг. Тиймээс манайд боломж илүү байгаа аж.

Герман, Франц, Голланд, АНУ, БНХАУ, Монголын эрдэмтэд дээрх төсөл дээр ажиллаж байна. АНУ усалгааны систем, германчууд хадлан тариалангийн тоног төхөөрөмж, Хятад саалтуурын систем, Франц, голландууд үхэр нийлүүлжээ. Мөн дотоодын хөдөө аж ахуйн чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэд зөвлөгөө өгч байгаа аж. Стандартын бус

үхрийн байр, тав тухгүй орчин, өвс тэжээл нь таарахгүйн дээр тоног төхөөрөмжийн сонголтоо хийж чадахгүйгээс манайхан алддаг байна. Энэ бэрхшээл “Хишигтэн Нүүдэлчин” компанид тулгараагүй ч ярвигтай асуудал мэр сэр бий аж. Энэ талаар Ж.Баттөгс “Бидний ажилд алдаатай зүйл олон байна. Монголд зарим тэжээл байхгүй, урд хөршөөс эрдэнэшиш зэргийг оруулах гэхээр хориотой. ОХУ-аас тээвэрлэвэл өртөг өндөртэй. Гэхдээ бид Франц, Голландын түншүүдтэйгээ ярилцсаны дүнд Монголд аль төрлийн ургамал тариалбал илүү ургах боломжтойг судаллаа. Үүний үр дүнд бид энэ хавраас Америкийн усалгааны системтэй газар тариалан эрхлэх гэж байна. Фермерийн аж ахуй эрхлэхэд өөрийн гэсэн газар тариалантай байх ёстой. Хурааж авсан тэжээлээрээ үхрээ тэжээвэл сайн үр дүн авчрах боломжтой. Энэ утгаараа Монголын эрчимжсэн аж ахуйг шинэ шатанд

гаргах бүрэн механикжсан фермийг бий болгох эхлэл тавигдсан” хэмээсэн.

Үнээний болон ажилтнуудын байр барих, техник хэрэгсэл, үнээ гээд нийт 6.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Үүний 1.8 тэрбумыг “Чингис” бондын хөрөнгөнөөс гаргасан бол үлдсэн таван тэрбумыг “Нүүдэлчин” группээс санхүүжүүлжээ. Энэ хөрөнгөө 2018, 2019 он гэхэд нөхөж, ашигтай ажиллаж эхэлнэ гэж тэд үзэж байна. Үүнээс гадна малын төл, гарч буй сүү сааль эдийн засагт тодорхой хэмжээгээр нөлөөлнө гэдгийг ч хэлж байв. Нэг үхрийн амьдын жин 480 кг. Тугал байх үедээ 40-51 кг байдаг аж. Цаашид монгол үхэртэй эрлийжүүлэхийг ч үгүйсгээгүй. Учир нь, өндөр ашиг шим өгөх “монтбейльярд” үүлдэртэй монгол үхрийг үржилд оруулж өөрсдийн брэнд гаргаж болох эсэх талаар судалж буй аж. ■

“Монголын худалдаа, таваарын чуулган”-д оролцох хос эрхийг хожоорой

Global Trade Review (GTR) нь ирэх тавдугаар сард Монголын худалдаа, таваарын санхүүгийн чуулганыг гурав дахь удаагаа Улаанбаатар хотноо зохион байгуулах гэж байна. Энэ нь манай улсын худалдаа, таваарын салбарт болдог цорын ганц арга хэмжээ юм.

Тус чуулганы гурав дахь удаагийн арга хэмжээнд 13 орны 175 орчим төлөөлөгчийг оролцуулахаар уриад байгаа аж. Чуулганаар бүс нутгийн тэргүүлэгч бизнесменүүд, худалдаа, санхүүгийн талбарт дадлага, туршлага хуримтлуулсан хүмүүсийн хамт хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлэх сайхан боломж бүрдэж буй.

Чуулганы гол сэдэв уул уурхай, эрдэс баялаг болон таваараас голлон хамаардаг эдийн засгийн өсөлт зэрэг болно. Түүнчлэн дотоодын банк болон хувийн салбарынханд тулгараад буй сорилтын талаар цаг үеэ олсон гүн гүнзгий ойлголт өгч, улмаар худалдаа, таваарын салбарыг дэмжигч гол оролцогч талуудын баримталж буй хэтийн төлөв, алсын харааг дэвшүүлэх гэж байна.

“Mongolian Economy” сэтгүүл ирэх сарын 13-нд “Blue Sky”-д болох Монголын худалдаа, таваарын зах зээлийн чуулганы мэдээллийн түншээр хамтран ажиллаж буй. Хамтын ажиллагааны хүрээнд уг арга хэмжээнд оролцох хос эрхийг уншигчиддаа санал болгож байна.

Энэхүү эрхийг авахын тулд win@mongolianeconomy.mn хаяг руу имэйл бичиж, та өөрийн нэр, ажлын газар, имэйл хаяг болон утасны дугаараа илгээнэ үү.

МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ ҮГ

“ТАНАЙ БАГШИЙН ЦАЛИНГ ТАТВАРААС ӨГДӨГ...”

И.ОТГОН

“Mongolian Economy” сэтгүүл Сангийн яам болон бусад холбогдох газартай хамтран олон нийтийн татварын боловсролыг дээшлүүлэх, системтэй мэдлэг, мэдээлэл өгөхөд анхаарч байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор СЭЗДС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхмийн багш Ч.Өнөржаргалтай иргэдийн татварын мэдлэгт зучил нэмэх ярилцлага хийснээ сонирхуулж байна.

-Та багш хүний хувьд татварын ач холбогдлыг иргэдэд ойлгомжтой энгийнээр тайлбарлаж өгөхгүй юү. Манайхан татварыг албадлагын шинжтэй дарамттай зүйл гэж хардаг. Энэ ойлголтыг засах ёстой байх.

-Ерээд онд татвар төлөгч маш цөөхөн. Татварын хувь хэмжээ дээд шатлал нь аж ахуйн нэгжийн хувьд 40 хувь байлаа. Татвараа яаж ч төлөөд дороос нь босдоггүй байсан. Тэгээд зугатаадаг. Татвар төлөх аймаар гэсэн ухамсар одоо болтол арилаагүй. Ганзагачин сэтгэлгээгээр ханддаг хэвээр. Балансаа уншиж чаддаггүй захирал олон байна. Бараг зууны 90 хувь нь уншиж чадахгүй дээ. Тийм боловсролтой байгаа юм чинь татвар хэрхэн төлөх тухай ойлголт байхгүй. Нягтлангууд нь буруу ойлгуулдаг. Орлого нь гурван тэрбум төгрөгт хүрэхээр 25 хувийн татвар төлдөг гээд ойлгочихсон явах жишээтэй. Гэтэл орлогоос нь зардлыг хасаад гурван тэрбумаас дээш гарсан ашгаас 25 хувийн татвар авдаг гэхээр “Өө тийм үү, тэгвэл бага юм байна” гэж дуугардаг. Ийм мэдлэг, мэдээлэлтэй хүмүүс татварын харилцаанд оролцож



байна. Татвар их хэмжээгээр нуугаад байгаа компаниудын нябо нарын карьерийг дуусгах хэрэгтэй. Тэгвэл чадалтай нягтлангууд тийм үйлдэл хийхээс татгалзаад эхэлнэ.

-Татварын орлогыг хүмүүсийн хүсэж байгаагаар хэт бага эсвэл өндөр тогтоож болдоггүйн учир юунд байна вэ?

-Татварын орлого хэт бага байгаад хүрэлцэхгүй бол төсвийн урсгал алдагдал үүснэ. Тэгэх юм бол улс орны эдийн засаг хүндэрнэ. Төсвийн байгууллагынхан цагтаа цалингаа тавьж чадахгүй. Цалингүй багш өлсөнө, өвдөнө. Хүүхэд багачууд сургууль цэцэрлэгтээ муу хамрагдана. Цагдаагийнхан муу ажиллана, тэтгэвэр тэтгэмжээ цагтаа тавьж чадахаа болино. Нийтийн тээвэр болон бусад салбарт олгогддог татаасууд хумигдаж эхэлнэ. Тийм учраас татварын орлогыг бүрэн дүүрэн хураах тухай асуудал маш чухлаар тавигддаг. Татварын орлого хүрэлцэхгүй бол улс зээл авдаг. Манайх “Чингис” бонд гаргасан. Зээл олдохоо байвал хандив тусламж гуйдаг. Хандив тусламж гуйхаар тухайн улс орныг ядуу байхыг

шаарддаг. Нэг хүнд ногдох ДНБ маш бага. Үндсэндээ гуйлгачин байна гэсэн үг. Гуйлга гуйхгүйн тулд өрөнд орохгүйн тулд татварын орлогоо бүрэн дүүрэн бүрдүүлэх ёстой.

-Татварын орлого бүрэн бүрэлдэхэд ямар хүчин зүйл нөлөөлөх вэ?

Нэгдүгээрт, нийгэм эдийн засгийн бүтэц. Хувийн бизнес ихтэй, орлого ашиг арвинтай субектүүд олон байвал татварын орлого их байна. Хоёрдугаарт, Татвар төлөх ухамсар. Ер нь бол татваргүйгээр улс орон оршин тогтнох үндэсгүй. Их ч бай, бага ч бай ямар нэг хэмжээгээр иргэн татвар төлж хувь нэмрээ оруулах ёстой гэдгийг ухамсарласны үндсэн дээр татварын орлого бүрэлдэнэ.

-Иргэдийн татвар төлөх ухамсрыг хэрхэн дээшлүүлэх вэ?

-Засаглал сайн байгаад олсон мөнгөө зөв зүйтэй, ил тод зарцуулдаг байх. Төсвийн мөнгийг үргүй зарцуулдаг, авлига хээл хахуулийн тухай мэдээлэл бага байх юм бол татвар төлөх ухамсар дээшилдэг. Дээрээс нь тэгш шударга байдал чухал. Ижил түвшинд орлого олж байгаа, амьжиргааны түвшин болоод адилхан ажил төрөлтэй хүмүүс татварыг ижил тэнцүү хэмжээгээр төлөх байдал татвар төлөлтөд нөлөөлдөг. Манай татварын орлогын бүрдүүлэлтэд энэ сөргөөр нөлөөлж байна. Үүнээс гадна татварын байгууллагын үйл ажиллагаа татвар төлөлт, бүрдүүлэлтэд нөлөөтэй. Энэ бол манайд сайжирч байна. 2000 оны эхээр заавал хариуцсан байцаагчтайгаа уулзаж байж татварын тайлангаа өгдөг байсан. Одоо бол монголчууд татварын тайлангаа өгөх гэж татварын ►►

▶ алба руу биеэр очих шаардлагагүй. Дурын мэдээллийг утсаар асуух боломжтой. Нэг цэгийн үйлчилгээн дээр очоод хэн дуртай байцаагчаас үйлчилгээ авч байна. Татварын албаны үйл ажиллагааг гааль, нийгмийн даатгалтай харьцуулахад мэргэжлийн түвшинд ч хүнд сурталгүй шуурхай үйлчилгээний хувьд ч гэсэн харьцангуй сайн болсон гэж үзэж болно. Энэ бол татвар төлөхөд их бага ямар нэгэн хэмжээгээр нөлөөлнө.

-Бусад оронд татварын тухай ойлголт, хүмүүжлийг хүүхэд байхаас нь өгдөг гэсэн. Монгол хүүхэд багачууд яагаад татварын тухай ойлголтгүй өсөх ёстой гэж. Тэгээд том болохоороо яаж татвараас зугатаж бултаж болдог вэ гэдэг муу аргад шууд суралцах болдог. Энэ тухай Та ямар бодолтой байдаг вэ?

-Ер нь бол татвар гэж юу вэ гэдгийг хүүхэд байхаас нь ойлгуулах ёстой. Танай багшийн цалинг татвараас өгдөг, сургуулийн ширээ сандлыг аав ээжийн чинь ажил хийж төлсөн татварын мөнгөөр худалдаж авдаг. Сургуулийн цахилгаан, усны зардал, цэвэрлэгчийн цалинг ч мөн татвараас тавьдаг. Та нарыг боловсрол мэдлэгтэй сайн хүн болгохын тулд ээж аавын чинь болоод өмнөх үеийн төлсөн татварын мөнгийг зарцуулж байгаа. Тийм болохоор та нар ч гэсэн том болохоороо өөр өөрийнхөө орлогоосоо татвар төлдөг болох ёстой гэдгийг ухамсарлуулах хэрэгтэй. Манай дунд сургуульд орох ёстой хичээлийн жагсаалтад татварын тухай ойлголт өгөх хичээл байдаг. Сонирхож үзсэн чинь эдийн засгийн дээд боловсролтой хүн ойлгох хэмжээний маш хүнд юм байна лээ.

-Татварын нийгэмд гүйцэтгэх үүрэг хэр их вэ?

-Нийгмийн янз бүрийн орлогыг бий болгосноор олон арга хэмжээг санхүүжүүлэх, төрөл бүрийн сангуудыг бий болгох, хуримтлал бий болгоод, хуваарилалт хийх, хуваарилалтаасаа дахин хуваарилалт хийх, татвараар дамжуулаад эдийн засгийн эргэлтийг түргэсгэх, эргэлтэд ордоггүй үхмэл хөрөнгүүдийг эргэлтэд оруулах гэх мэт олон үүрэгтэй.

Мөн нийгэмд хяналт тавих үүрэг ч бий. Хэрвээ татварын тайлан гэж өгдөггүй, гааль дээр татвар хураадаггүй байсан бол хэн хаана ямар үйл ажиллагаа эрхлээд, хэр хэмжээний орлого олж байгааг бүртгэх боломж хомсдоно. Жишээлбэл, Монгол Улс жилдээ хэчнээн тонн элсэн чихэр хэрэглэж байна гэдгийг гаалийн статистик мэдээллээс л мэднэ. Хэрвээ татвараас зугатаж зайлсхийж байгаа бол эх орноосоо урваж байна гэсэн үг. Яагаад гэвэл Монгол Улс оршин тогтнож байж бид амьдарна.

-Хараад байхад манайд нийгмийн эмзэг хэсэг мэдээж татварын орлогод нэмэргүй. Баян чинээлэг хэсэг татвараа тэр бүр төлж байгаа гэдгийг нотолж батлах зүйл нь хомс. Тэгэхээр энд ямар арга зам байх ёстой вэ?

-Хөгжилтэй оронд хувь хүмүүс нь нийт улсын төсвийнхөө дийлэнх хэсгийг бүрдүүлдэг. Гэтэл манайд НӨАТ, Гааль, Онцгой албан татвараар ихэнх орлого бүрддэг. Нэг том үйлдвэр дампуурвал улс хоосрох хэмжээнд байна. Иргэд нь татвар төлж мэддэггүй, ухамсарладаггүй. Тэгээд бандгар жийп унаж давхилдсан хүмүүс. Тэр машиныг юугаар авсан бэ гэдгийг тайлагнах ёстой. УИХ-ын гишүүд хүртэл хөрөнгө орлогын мэдүүлэгтээ маш хариуцлагагүй хандаж байна. Хэдэн суурь хоньтой, хэдэн азарга адуутай, 100 саяын орлоготой гээд л жагсаадаг. Тэрнээсээ татвар төлсөн л байдаг байгаа даа.

Хэт ядуу хэсэг хэчнээн хүсэл сонирхол байгаад ч мөнгөгүй юм чинь худалдан авалт хийх чадваргүй. Баян хоосны ялгааг нэмэгдүүлэхгүй байх нь чухал. Энэ хоёр хэсгийн хоорондын ялгаа хэт их болоод ирвэл аль аль нь нийгэмд бодит зүйлийг бий болгохоо больчихдог. Тийм болохоор татвар хэт орлоготой хэсгийг тайрах, нийгэм жигд орлоготой байхыг зохицуулах үүрэгтэй.

-Сүүлийн үед НӨАТ-ыг бараг амтай болгон нь ярьдаг болж. УИХ-ын гишүүд НӨАТ-ын хууль санаачилж байгаа нь хэр зохимжтой вэ?

-УИХ-ын гишүүд улсын төсөв, санхүү эдийн засгийн аюулгүй байдалтай

холбоотой хууль санаачилдгаа болих хэрэгтэй. Хариуцлагыг Засгийн газар үүрнэ. Засгийн газрын оролцоогүйгээр Татварын хуульд гар дүрэх нь буруу. Засгийн газарт өөрийн төлөвлөсөн төсөвлөсөн бодсон зүйл байгаа. Тэр төлөвлөсөн зорилгодоо хүрэх гээд ажиллаж байхад дурын нэг гишүүн хууль санаачилж болохгүй.

НӨАТ-ын босго хэт бага байгаа. 10 саяд бариулах гээд олон аж ахуйн нэгж тайлангаа худлаа гаргаж байгаа нь ч үнэн. Нөгөө талаар НӨАТ хэт өндөр байвал аюултай. Хэт өндөр байвал жижиг, дунд үйлдвэрийг томрох боломжийг хязгаарлаад, хэдэн том компани хоорондоо тоглох боломжтой болдог. Сангийн яамнаас УИХ-д өргөн барьсан НӨАТ-ын босгыг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл маш зөв зүйл. 50 сая гэдэг боломжийн босго. Яагаад гэвэл хэт жижиг байгаад 10 саяд орлогоо бариулах гээд ядаад яваа компаниудын нуруу жаахан тэнийгээд, орлогоо 50 сая дотор үнэн зөв мэдээлнэ.

-Хуулийн төсөлд хэрвээ хүсвэл сайн дураар НӨАТ төлөгч байж болно гэсэн байсан. Сайн дураараа НӨАТ төлөгч байна гэж байх уу?

-Байна, ирээдүйд орлого нь их болох магадлалтай компаниуд бушуухан НӨАТ төлөгчөөр бүртгүүлчихээд үйл ажиллагаагаа жигдрүүлмээр байгаа.

-Та татвар төлөгчдөд хандаж зөвлөгөө өгөхгүй юу?

-Манай иргэдийн хувьд бүх зүйлийг өөрөө хийх гээд байдаг. Ялангуяа зөвлөх үйлчилгээ авч сураагүй. Бид үсээ засуулахдаа өөрөө толинд хараад тайрдаггүй биз дээ. Гэртээ засвар үйлчилгээ хийх бол мужаан дууддаг. Машинаа засуулахаар засварын газарт очдог. Гэтэл санхүүгийн тайлан гаргах болохоор өөрөө хийх гээд дайрдаг. Энэ нь тухайн байгууллагын үйл ажиллагааг улам хүндрүүлдэг. Мэргэжлийн туслалцаа үзүүлдэг байдлыг жаахан энгийн болгоод мөрдүүлэх ёстой. Хувийн бизнес эрхэлж байгаа хүн өөрийн орлого, татварын үйл ажиллагаанд орооцолдохгүй байх юм бол бизнес нь сайн явна. Мэргэжлийн байгууллагын үйлчилгээ авах ёстой гэсэн үг. ■

ТАТВАР

Засгийн газраас УИХ-д өргөн барьсан, хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад багтсан Татварын нэмэлт, өөрчлөлт орох хуулийн төслүүдийг урьдчилсан байдлаар хүргэж байна.

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6.4.1 дэх заалтын “80 хувьд” гэснийг “20 хувьд” гэж, 4.1.10, 5.2, 6.11, 7.2, 13.7 дахь хэсгийн “10.0 сая” гэснийг “50.0 сая” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

1.1. Хуулийн төслийн зорилго:

Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган авч төсөвт төлөх үүрэг бүхий албан татвар төлөгч (албан татвар төлөгч)-өөр бүртгүүлэх босгын хэмжээ 10 сая байсныг 50 сая болгон өөрчлөх

1.2. Хамрагдах этгээд:

-Борлуулалтын орлогын хэмжээ **50 сая** ба түүнээс дээш төгрөгт хүрсэн иргэн, хуулийн этгээд;

-Борлуулалтын орлогын хэмжээ **50 сая** ба түүнээс дээш төгрөгт хүрсэн гадаадын хуулийн этгээдийн төлөөний газар

-Борлуулалтын орлогын хэмжээ **10 саяас 50 сая** төгрөг хүртлэх иргэн, хуулийн этгээд сайн дураар бүртгүүлэх боломжтой.

1.3.Босго тогтоох шаардлага :

Албан татвар төлөгч болсоноор дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

-Бусдаас албан татвар суутган авч, төсөвт төлөх;

-Төсөвт төлсөн албан татвараас хасалт хийлгэх, буцаан олголт авах;

-Тухайн татварын жилийн туршид заавал борлуулалт хийсэн байх;

Иймд бусдаас албан татварыг суутган авах онцгой эрхийг тодорхой босгын болзол хангасан этгээдэд олгох нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах ач холбогдолтой тул НӨАТ-ын босгыг

зайлшгүй тогтоох шаардлагатай.

1.4. Нэмэгдсэн өртгийн албан татварын босго тогтоох шалгуур үзүүлэлт

- Одоо байгаа босгын хэмжээг инфляцийн өсөлттэй уялдуулж тохируулга хийхэд 10 сая төгрөг нь 43 сая төгрөг байна.

- Оновчтой босгыг тогтоох олон улсын загварт үндэслэхэд 51.4 сая төгрөг байна.

Тус загвар нь:

Нийгмийн бүтээмжид ногдох ахиуц зардал

Татварын албаны зардал

Татвар төлөгчийн зардал

Татварын хувь, хэмжээ

Борлуулалтад шингэсэн нэмүү өртгийн хэмжээнд тус тус үндэслэсэн.

Иймд уг босгын хэмжээг үнийн өсөлт болон босго тогтоох загварын дагуу тооцон үзэж **50 сая** төгрөг байхаар тогтоож байна.

1.5. НӨАТ босгогүй бол:

-Хүн бүр хийсэн гүйлгээ тутмаасаа бусдаас татвар суутгах эрхтэй болж, суутгасан татвараа төлж, тайлагнах улмаар хуулийн хариуцлага хүлээх системд шилжинэ.

1.6.Хуулийн төсөл батлагдсанаар үүсч болох эрсдэл, төсөвт үзүүлэх нөлөөлөл:

-Нийт НӨАТ төлөгчийн 45.3 хувь буюу 9098 аж ахуйн нэгж нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан гаргах, бүртгэл хөтлөх, падаан цуглуулах үйл ажиллагаанаасаа чөлөөлөгдөнө.

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд дараах 16 дугаар зүйлийн 16.11 дэх хэсэг, 19¹ дүгээр зүйлийг тус тус нэмсүгэй:

1/ 16 дугаар зүйлийн 16.11 дэх хэсэг:

“16.11. Энэ хуулийн дагуу албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо үйл ажиллагааны чиглэл болон тусгай зөвшөөрөл тус бүрээр тусгаарлан тооцно.”

2/ 19¹ дүгээр зүйл. Буцаан олгох:

“19¹ дүгээр зүйл. Буцаан олгох

19¹.1. Энэ хуулийн 8.1.1-д заасан орлогын дүн нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй, Монгол Улсад байнга байрладаг албан татвар төлөгчийн төлсөн албан татварын 90 хувийг дор дурдсан шаардлагыг зэрэг хангасан тохиолдолд буцаан олгоно:

19¹.1.1. Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо энэ хуулийн 8.1.1-д заасан албан татвар ногдох орлогоос мөн хуулийн 12 дугаар зүйлд заасан зардлыг хасч тооцсон байх;

19¹.1.2. Энэ зүйлийн 19¹.1.1-д заасан албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо зөвхөн энэ хуулийн 8.1.1-д заасан үйл ажиллагаанд зориулсан баримтаар ногдох тухайн жилд гарсан зардлыг хассан байх.

19¹.1.3. Албан татвар төлөгч нь тухайн жилд ногдох албан татварыг хуулийн хугацаанд бүрэн төлсөн байх.

19¹.2. Энэ зүйлийн 19¹.1-д заасан албан татварын буцаан олголтыг тухайн жилийн албан татварын тайлант хугацаагаар тодорхойлон, төлсөн татварын дүнгээс тооцож, албан татвар төлөгчид дараагийн татварын жилийн эхний хагаст багтаан буцаан олгоно.

19¹.3. Энэ зүйлийн 19¹.1-д заасан буцаан олголт нь дор дурдсан салбарт үйл ажиллагаа явуулдаг албан татвар төлөгчид хамаарахгүй:

19¹.3.1. уул уурхайн хайгуул, ашиглалт, олборлолт, боловсруулалт, импорт, экспорт;

19¹.3.2. газрын тосны хайгуул, ашиглалт, олборлолт, боловсруулалт, импорт, экспорт;

19¹.3.3. үүрэн холбооны оператор;

19¹.3.4. согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа;

19¹.3.5. тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа;

19¹.3.6. банк, санхүүгийн байгууллага.

19¹.4. Харилцан хамаарал бүхий талуудын хувьд энэ зүйлийн 191.1-д заасан борлуулалтын орлогын хэмжээг тодорхойлохдоо тэдгээрийн борлуулалтын орлогын нийлбэрээр тооцно.

19¹.5. Энэ зүйлийн 19¹.1-19¹.4-т заасан албан татварын буцаан олголттой холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19¹.6. Энэ зүйл нь 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хүчинтэй байна.”

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/6 дугаар зүйл. Харилцан хамаарал бүхий тал:

“6 дугаар зүйл. Харилцан хамаарал бүхий тал

6.1. Харилцан хамаарал бүхий талууд гэж тухайн талуудын хооронд хийгдсэн аливаа хэлцлийн эдийн засгийн үр дүнд шууд нөлөө үзүүлэхүйц дараах этгээдүүдийг хэлнэ:

6.1.1. Гэр бүлийн тухай хуулийн 3.1.3, 3.1.5, 3.1.6-д заасан харилцаатай;

6.1.2. тухайн аж ахуйн нэгжийн хувьцаа буюу саналын эрхийн 20 ба түүнээс дээш хувийг шууд ба шууд бус хэлбэрээр эзэмших эрхтэй;

6.1.3. тус бүрийн хувьцаа буюу саналын эрхийн 20 ба түүнээс дээш хувь нь шууд ба шууд бус замаар гуравдагч этгээдийн эзэмшилд байдаг аж ахуйн нэгжүүд;

6.1.4. Аж ахуйн нэгжийн удирдлагын 20 ба түүнээс дээш хувийг томилох эрхтэй эсхүл үйл ажиллагааных нь бодлого, чиглэлийг тодорхойлох эрхтэй этгээд;

6.1.5. Компанийн тухай хуулийн 99.1-д заасан агуулгаар хамааралтай аж ахуйн нэгжүүд.” ■



ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛД


ЗАХЫН ТЭНЦВЭР: ИЛҮҮДЭЛ БА ХОМСДОЛ, ХЭРЭГЛЭГЧИЙН БОЛОН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ХОЖОО

Өмнөх хоёр хичээлээр бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн талаар авч үзсэн билээ. Энэ удаа эдгээр ухагдахууныг нэгтгэн захын тэнцвэр гэсэн ухагдахууныг авч үзэх болно.


Захын тэнцвэр: Бүтээгдэхүүний эрэлт нь хэрэглэгчийн талаас, харин нийлүүлэлт нь үйлдвэрлэгчийн талаас үүддэг. Энэ хоёр талын сонирхол уулзах цэг нь бүтээгдэхүүний зах болно. Аливаа зах дээр үнэ нь худалдагч (үйлдвэрлэгч) болон худалдан авагчдын (хэрэглэгч) төлөвлөгөөг тэнцвэржүүлэх гол зохицуулагч байдаг. Бүтээгдэхүүний эрэлтийн болон нийлүүлэлтийн тоо хэмжээ тэнцүү байх нөхцөлийг захын тэнцвэр гэдэг. Энэ нөхцөл дэх үнийг тэнцвэрт үнэ, тоо хэмжээг тэнцвэрт тоо хэмжээ хэмээдэг. Эрэлтийн муруй дээрх үнэ нь хэрэглэгчийн зүгээс тухайн бүтээгдэхүүний харгалзах нэгжийн төлөө төлөх хамгийн их үнийг харуулдаг бол нийлүүлэлтийн муруй дээрх үнэ үйлдвэрлэгчийн зүгээс санал болгох хамгийн бага үнэ болно. Иймээс бүтээгдэхүүнийг хэрэглэгч эрэлтийн муруйгаас доош үнээр худалдан авах, харин үйлдвэрлэгч нийлүүлэлтийн муруйгаас дээш үнээр борлуулах сонирхолтой байдаг. Зах дээр тогтох бодит үнэ энэ хоёр үнийн хооронд байна. Ийнхүү үнэ тогтох бодит нөхцөл нь маш олон

тооны хэрэглэгч, үйлдвэрлэгч байгаа тохиолдолд л хэрэгждэг. Цөөн тооны юм уу эсвэл цор ганц үйлдвэрлэгч, хэрэглэгчтэй захын хувьд дээрх нөхцөл биелэхгүй.

Үнэ тэнцвэрт үнээс дээгүүр тогтсон үед нийлүүлэлт нь эрэлтээс давж, бүтээгдэхүүний илүүдэл үүсдэг. Илүү үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ худалдагч нар үнийг нь бууруулж зарах тул үнэ буурсаар тэнцвэрт түвшинд хүрнэ. Харин үнэ тэнцвэрт үнээс доогуур байвал нийлүүлэлт нь эрэлтээ хангахгүй хомсдоно. Бүтээгдэхүүн хомсдолтой тохиолдолд хэрэглэгч үнэ хаяж, хоорондоо өрсөлдөн бүтээгдэхүүнийг худалдан авснаар үнэ өсч, тэнцвэрт үнэд хүрдэг. Үнэ өөрчлөгдөх энэхүү механизмаар дамжин, урт хугацаанд тэнцвэрт үнэ тогтдог.

**Захын тэнцвэрийн өөрчлөлтүүд:**


Эрэлтэд нөлөөлөгч “үнийн бус бусад хүчин зүйлс” өөрчлөгдөх нөхцөлд захын тэнцвэр өөрчлөгддөг. Хэрэглэгчийн орлого, орлох, хослох бүтээгдэхүүний үнэ, үнийн болон орлогын хүлээлтээс хамааран эрэлт өсөхөд эрэлтийн муруй баруун гар тийш шилжиж, үр дүнд нь үнэ өсч, нийлүүлэлтийн тоо хэмжээ нийлүүлэлтийн муруйн дагуу нэмэгддэг. Харин эрэлт буурахад эрэлтийн муруй зүүн гар тийш шилжиж, тэнцвэрт үнэ ба тоо хэмжээ нэгэн зэрэг буурдаг.




Үйлдвэрлэлийн түүхий эд, хүчин зүйлсийн үнэ, технологи зэрэг “Борлуулалтын төлөвлөлтөд нөлөөлөгч үнийн бус бусад хүчин”

► зүйлс” өөрчлөгдснөөр нийлүүлэлт ихэсэх эсвэл багасах замаар захын тэнцвэрийг өөрчилдөг. Нийлүүлэлт өсөхөд нийлүүлэлтийн муруй баруун гар тийш шилжиж, үр дүнд нь үнэ буурч, эрэлтийн тоо хэмжээ эрэлтийн муруйн дагуу өснө. Нийлүүлэлт буурахад, нийлүүлэлтийн муруй зүүн гар тийш шилжиж, тэнцвэрт үнэ өсч, тэнцвэрт тоо хэмжээ буурна.

Нийлүүлэлт өсөөгүй байхад эрэлт нэмэгдэх нь үнэ өсөх шалтаг болдог бол эрэлт тогтонги үед нийлүүлэлт ихсэх нь үнэ буурах шалтгаан болно. Эдийн засгийн нөхцөл байдал, зохицуулалт цаг хугацаанаас хамааран байнга хөдлөнгө шинжтэй байх тул захын тэнцвэр ч мөн түүнийг даган байнга өөрчлөгдөн шилжих шинжийг агуулдаг.



Эрэлт, нийлүүлэлт хоёулаа нэгэн зэрэг өсөхөд тэнцвэрт тоо хэмжээ өснө. Тэнцвэрт үнэ хэрхэн өөрчлөгдөх нь тодорхойгүй. Учир нь эрэлтийн өсөлт тэнцвэрт үнийг өсгөж, нийлүүлэлтийн өсөлт тэнцвэрт үнийг бууруулдаг. Эрэлт, нийлүүлэлт хоёулаа буурахад тэнцвэрт тоо хэмжээ буурдаг бол тэнцвэрт үнэ яахыг мэдэхгүй. Эрэлтийн бууралт тэнцвэрт үнийг бууруулж, нийлүүлэлтийн бууралт тэнцвэрт үнийг өсгөдөг. Энэ хоёр тохиолдолд үнийн өсөлт, бууралт хэрхэн явагдахыг тухайн бүтээгдэхүүний



эрэлт, нийлүүлэлтийн үнийн мэдрэмж гэсэн ойлголтыг ашиглан тайлбарлах боломжтой. Энэ талаар дараагийн булангаар авч үзнэ.


Хэрэглэгчийн болон

үйлдвэрлэгчийн хожоо. Тухайн бүтээгдэхүүнд хувь хүний хандаж байгаа үнэлэмж нь түүний нэгжид төлөхөд бэлэн байгаа хамгийн өндөр үнээр хэмждэг. Энэ нь эрэлтийг тодорхойлдог. Эрэлтийн муруй дээрх үнэ нь хэрэглэгчийн зүгээс санал болгох хамгийн өндөр үнэ байдаг. Хэрэглэгч бодит байдалд зах зээлийн тэнцвэрт үнээр бүтээгдэхүүнийг худалдан авах ба энэ нь түүний төлөхөд бэлэн байгаа үнээс доогуур эсвэл тэнцүү байна. Хэрэглэгчийн хувьд үүсч байгаа энэхүү зөрүүг хэрэглэгчийн хожоо гэсэн ойлголтоор тодорхойлдог ба түүнийг худалдан авсан бүтээгдэхүүний нэгж бүрийн хувьд төлөхөд бэлэн үнээс төлсөн үнийг хасаад, хооронд нь нэмж тооцдог. Хэрэглэгчийн хожоог эрэлтийн муруйгаас доош, тэнцвэрт буюу төлсөн үнээс дээш хашигдсан дүрсийн талбайгаар хэмжигдэнэ.

Бүтээгдэхүүнийг нэгжээр нэмж үйлдвэрлэх зардал нь түүний ахиу зардал юм. Ахиу зардал нь пүүсийн хүлээн зөвшөөрөхөд бэлэн байгаа хамгийн бага үнэ болно. Энэ үнийг нийлүүлэлтийн муруйгаар дүрсэлдэг. Үйлдвэрлэгч нийлүүлэлтийн муруй дээрх үнээс

дээш үнээр бүтээгдэхүүний тухайн нэгжийг борлуулахыг эрмэлздэг. Бодит байдалд үйлдвэрлэгч нэгж бүтээгдэхүүн тутмаас захын тэнцвэрт үнэтэй тэнцүү хэмжээний орлого олох ба энэ нь хамгийн бага үнээс их байна. Өөрөөр хэлбэл захын тэнцвэрт үнэ нь үйлдвэрлэгчид ямар нэг өгөөжийг өгдөг. Үүнийг үйлдвэрлэгчийн хожоо гэсэн ойлголтоор илэрхийлэх ба түүнийг худалдсан бүтээгдэхүүний нэгж бүрийн хувьд бүтээгдэхүүний захын тэнцвэрт үнээс нийлүүлэлтийн хамгийн бага үнийг хасч, хооронд нь нэмсэн нийлбэрээр тодорхойлдог. Геометрийн ойлголтоор илэрхийлбэл, захын тэнцвэрт үнээс доош, нийлүүлэлтийн муруйнаас дээш хэсгийн талбайгаар хэмжинэ.

Энэхүү хоёр хожооны нийлбэрийг нийгмийн хожоо гэнэ. Төрөөс тогтоож буй татвар нь хэрэглэгч, үйлдвэрлэгчийн хожооноос авагдах ба хэрэглэгчийн бүтээгдэхүүний нэгжийн төлөө төлсөн мөнгө, үйлдвэрлэгчийн нэгж бүтээгдэхүүнээс олсон цэвэр орлогын зөрүүгээр татварын хэмжээ тодорхойлогддог. Татвар тогтоосноор тухайн бүтээгдэхүүний нийгмийн хожоо буурдаг. ■



ДААТГАЛ

АМИН ДЭМ


Э.ЗОРИГТ

Бүхэл бүтэн 20 гаруй жил хүлээлээ. Мөлхсөн хэвээр л. Уг нь даатгалын салбар аливаа улс орны санхүүгийн хамгийн хүчирхэг зэвсэг байдаг. Гэтэл манайд нэг л унхиагүй. Хөгжлийн эхэн шатнаас олигтой урагшилдаггүй “тушаатай морь шиг” энэ салбарыг хэрхэн хөгжүүлэх вэ. Тоо баримтаас харахад 2009 оноос хойш манай даатгалын салбар жил бүр тогтмол өсөлттэй гарсан байдаг. Гэхдээ чанар яривал муу дүнтэй. Тухайлбал, нийт актив, хураамжийн орлого, нөхөн төлбөр, хөрөнгө оруулалтын ашиг болон дүн үзүүлэлтээр бусад орноос холоо хоцорчээ. Монгол Улстай нэг гараанаас гарсан Казахстан улсын даатгалын салбарын нийт актив 2.97 тэрбум ам.доллар, хураамжийн орлого 1.12 тэрбум ам.доллар байх жишээтэй. Гэтэл манай улсын даатгалын үйл ажиллагаа явуулж буй 17 компанийн нийт хөрөнгийн хэмжээ өнгөрсөн оны дөрөвдүгээр улирлын байдлаар 126.4 тэрбум төгрөг байна. Дэлхийн банкны зөвлөх Б.Заяа “Манай даатгалын салбар хөгжлийнхөө эхэн шатанд л явж байна. Хөрөнгийн хэмжээ ДНБ-д эзлэх хувь хэмжээ гээд аль ч үзүүлэлтээс энэ нь тодорхой харагддаг. Тиймээс төрийн тусгай бодлого хэрэгтэй байна” гэв. Тэгвэл төрийн ямар бодлого хэрэгтэй вэ.

Хариуцлага даатгах тогтолцоо

Монголын даатгалын зах зээлд гарсан томоохон өөрчлөлт бол Жолоочийн хариуцлагын албан журмын заавал даатгал юм. Тус хууль хэрэгжиж эхэлснээр даатгалын зах зээл 300 мянга гаруй шинэ хэрэглэгчтэй болж, хүмүүс даатгалын мэдлэг болон хэрэгцээгээ дээшлүүлж, даатгалын компаниуд илүү хурдацтай хөгжих

боломжийг бүрдүүлсэн гэдгийг Албан журмын даатгагчдын холбооны гүйцэтгэх захирал Д.Цэвээнжав хэлсэн. Одоогоор албан журмын даатгалын үйл ажиллагааг нийслэлд даатгалын 16 компани, орон нутагт дээрх даатгалын компаниудын 213 салбар, даатгалын 2357 төлөөлөгч эрхлэн явуулж байгаа аж. Мөн өнгөрсөн онд жолоочийн даатгалаар нийт 15.1 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрч 10.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Санхүүгийн зохицуулах хорооны гаргасан тайлангаас харахад нөхөн төлбөр олголтын хэмжээ жил бүр сайжирсан дүнтэй байна. Өнгөрсөн онд гэхэд нөхөн төлбөр 5.9 тэрбум төгрөгөөр өсчээ. Мөн хууль хэрэгжиж эхэлснээс хойш даатгалын компаниудын хураамжийн орлого ойролцоогоор 20 орчим хувиар өссөн байна. Эндээс харахад ганцхан төрлийн албан журмын хариуцлагын даатгал тус салбарт ямар том хувь нэмэр оруулсан нь харагдана. Тиймээс энэ төрлийн даатгалыг дахин бий болгоход төр бодлогоор дэмжих шаардлага бийг салбарынхан хэлж байна. Б.Заяа “Төрөөс дараа дараагийн албан журмын даатгалын төрлийг бий болгох хэрэгтэй. Аль ч орны туршлагаас харахад даатгалын салбар хариуцлагын даатгалыг зайлшгүй хийхийг шаарддаг. Тухайлбал, барилгын ажил өнөөдөр олон хүний амь насанд хүрч байна шүү дээ. Жишээ нь тус салбарын нийт ослын 54 хувьд нь хүний амь нас эрсэдсэн байна. Эндээс тус салбар хариуцлагын даатгалыг албан журмаар оруулж ирэх хэрэгтэй гэдэг нь харагдана” гэсэн юм. Манайх шиг даатгалын талаарх иргэдийн мэдлэг тааруу нөхцөлд албан журмын даатгалыг төрийн бодлогоор хэрэгжүүлж даатгалын ашиг тусыг олон нийтэд хүргэх нь нэг




талаар даатгалын салбарыг дэмжээд зогсохгүй төрийн тэр бүр хүрч чадахгүй байгаа газарт хөндлөнгийн хяналт болдог аж. Тиймээс эмч, хуульч зэрэг хүний амь нас эрүүл мэндтэй холбоотой зарим ажил мэргэжлийг даатгах зайлшгүй шаардлагатай байгааг салбарынхан хэлж байна. Хэрвээ тэгж чадвал энэ нь Монголын даатгалын салбарыг хөгжүүлэхэд төрийн үзүүлж буй хамгийн том хувь нэмэр юм. Д.Цэвээнжав дарга дээр дурдсан салбаруудад хариуцлагын албан журмын даатгалын тогтолцоог бий болгох тал дээр хуулийн төслийг холбогдох яам тамгын газраас боловсруулаад явж байгаа талаар дуулгасан.

Байгууллагаас хүн рүү

Мөлхөө салбарыг гүйдэг болгоход туслах өөр нэгэн амин дэм бол иргэдэд чиглэсэн даатгалын ▶

▶ бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх юм. Манай улсын даатгалын компаниудын гаргадаг бүтээгдэхүүний ихэнх нь албан байгууллагуудад зориулсан байдаг гэнэ. Тиймээс даатгалын салбарыг хөгжүүлж ард иргэдэд даатгалын сайн сайхныг ойлгуулахын тулд бичил буюу хүртээмжтэй даатгалыг зайлшгүй хөгжүүлэх хэрэгтэйг Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/-ны Ердийн даатгалын



бүтээгдэхүүн бөгөөд хураамж шимтгэлийн хувьд харьцангуй хямд, өндөр нөхөн олговортой, энгийн ойлгомжтой байдаг. Манай орны нөхцөлд бичил даатгалд тооцогдох наад захын олон жишээ дурьдаж болно. Бичил бизнес эрхлэгчид лангуугаа, бараа бүтээгдэхүүнээ, гэр хорооллын иргэд хашаа, байшин, гэрээ бүр цахилгаан хэрэгслээ хүртэл даатгуулж болдог санхүүгийн хамгаалалт ажээ. Б.Жавхлант “Хэрвээ манай улсад бичил даатгал хөгжсөн бол “Бөмбөгөр”, “Нарантуул” зэрэг зах шатахад тэр олон хүн хохирохгүй байсан. Тэнд худалдаа хийдэг иргэд тодорхой хугацаанд орлогогүй болж банкны зээлтэй зарим нь зээлийн дарамтад орсон. Худалдаа наймаагаа үргэлжлүүлэх гэтэл өмнөх өрөө төлөөгүй гээд зээл олдохгүй. Баталгаат орлого нь тасалдсан тул хоосон ходоодтой, хүйтэн гэрт өнжсөн нь цөөнгүй байгаа зэрэг хувь хүн дээр түмэн асуудал бууж ирнэ. Хэрвээ өөрийн лангуу бараа бүтээгдэхүүнээ даатгуулчихсан бол ядаж банкны өрөө даатгалын мөнгөөрөө төлчих боломжтой болох юм” гэв. Товчхондоо иргэд ирээдүйд учрах ямар л эрсдэл байна, тэр бүхнээс багахан хураамж төлөөд л бүрэн хамгаалагдах боломжтой гэсэн үг.

Даатгалын компаниуд зах зээлээ тэлж чадахгүй байгаа учир шалтгаанаа иргэдийн бага орлого буюу даатгал худалдан авах санхүүгийн чадвартай холбон тайлбарласаар ирсэн хэдий ч хөгжиж буй олон улс орнуудад энэхүү саадыг үл харгалзан бага орлоготой иргэдэд бичил даатгалын бүтээгдэхүүнийг амжилттай борлуулж байгаа туршлагауд байдаг аж. Тухайлбал, Энэтхэг, Камбож зэрэг орны туршлагаас харахад бичил даатгал нь зөвхөн ядуу, бага орлоготой иргэд болон Засгийн газарт нь ач тусаа өгөөд зогсохгүй урт хугацаанд хувийн секторын хөгжлийг хурдасгадгаараа ихээхэн ач холбогдолтойг баталсан байна. Үүнээс үүдэн бичил даатгал нь ядуу иргэдийг эрсдэлээс хамгаалж, амьжиргааг дэмжих замаар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд эерэгээр нөлөөлөх гээд олон талын ач холбогдолтой байдаг аж. Одоогоор СЗХ-ны Ердийн даатгалын

газраас гэр хорооллын айл өрхүүдийг жилийн 12-15 мянган төгрөг төлөөд болзошгүй аюулаас гэр, байшин, хашаа зэрэг эд хөрөнгөө даатгуулах тогтолцоог бий болгох тал дээр ажиллаж байна. Энэ нь тухайн иргэн сард дунджаар 1000 төгрөг төлөөд л иргэд гал, усны аюулаас санхүүгийн хувьд хамгаалагдах боломж бүрдэх юм.

Эндээс харахд Монголд “бичил даатгал”-ыг нутагшуулах нь зүйтэй гэдэг нь харагдана. Наана нь харин төр засгийн зүгээс холбогдох байгууллага, хөгжлийн агентлагуудтай хамтран бичил даатгалын тусгай журам, стандартуудыг боловсруулах. Хууль эрхзүйн орчныг сайжруулах, даатгагчдын болон даатгуулагчдын санхүүгийн боловсролыг сайжруулах, түгээлт борлуулалтын зохистой сувгуудыг тодорхойлох зэрэг багагүй ажлуудыг амжуулах шаардлагатай аж. Ингэж санхүүгийн үйлчилгээ ялангуяа даатгалын хүртээмжийг тэлж гэмээнэ манай Засгийн газраас явуулж буй халамжийн тогтолцоо буурч, төрийн нуруун дээрх “ачаа” нь харьцангуй хөнгөрөх төдийгүй даатгалын салбар хөгжих бас нэгэн шинэ боломж бүрдэнэ. Манайд одоогоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, СЗХ-оо хамтраад Люксембургийн Засгийн газрын хөрөнгө оруулалттай “Бичил даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх” төслийг амжилттай хэрэгжүүлээд дуусах шатандаа явж байгаа юм билээ. Уг төсөл хэрэгжсэнээр тогтвортой бөгөөд эрсдэлд тэсвэртэй амьжиргааг дэмжиж, ядуурлыг бууруулах зорилготой аж. Түүнчлэн энэ сарын 16-17-нд “Хүртээмжтэй даатгал” олон улсын хурал болно.

Манай улсын нийгэм, эдийн засгийн чадавх сайжирч байгаа өнөө үед хувийн хэвшлийнхэн овсгоотой байж дээрх даатгалын шинэ бүтээгдэхүүн гаргах замаар иргэдийн буруу ойлголтыг засах. Нөгөө талдаа төр, засгийн бодлого тодорхойлогчид даатгалын зах зээлийн нөөц боломжийг зөв үнэлж, бодлогоор дэмжих хэрэгтэй байна. Ингэж чадвал манай даатгалын салбар ойрын хэдэн жилийн дотор хөлд орох чадвартай юм билээ. ■

хэлтсийн дарга Б.Жавхлант сануулсан юм. Олон улсын туршлагаас харахад бичил даатгал нь хувь хүнд чиглэсэн төрөл бүрийн даатгалын төрлийг хэлдэг аж. Харин манай улсын хувьд бичил даатгалын ямар ч зохицуулалт байдаггүй аж.

Үүнийг Монголд даатгалын зах зээл хөгжөөд удаагүй, ялангуяа арилжааны даатгал дөнгөж эхлэл төдий, иргэдийн санхүүгийн боловсрол нэн дутмаг гэхчлэн олон хүчин зүйлээр тайлбарлаж болно. Гэхдээ хамгийн үнэнд дөхөх хувилбар нь манай даатгалын байгууллагууд ихэнхдээ байгууллагын төрлийн даатгалын үйлчилгээ эрхэлдэг учир хүн амын дийлэнх хэсэг болох бага орлого бүхий ядуу иргэдэд хүрч чадахгүй байгаатай холбоотой аж.

Бичил даатгал нь бага орлоготой, ядуу иргэд, бичил бизнес эрхлэгчдэд зориулан боловсруулсан даатгалын

УУЛ УУРХАЙ

СОНГОЛТГҮЙ СОНГОЛТ

Б.ТОГТОХ

Монгол Улсын хөгжил шинэ сонголттой нүүр тулаад байна. Гэвч үүнийг сонголтгүй сонголт хэмээн энэ жилийн Монголын эдийн засгийн чуулганы оролцогчид хүлээн зөвшөөрсөн юм. Улсын хөгжлийг ойрын жилүүдэд тодорхойлох нүүр царай, хөдөлгөх хүч нь уул уурхай хэвээр байна гэж тэд үзэв. Магадгүй энэ нь уул уурхайгүйгээр хөгжих ёстой гэсэн бодолтой зарим оролцогчдыг гонсойлгосон байж болох талтай. Гэхдээ яах аргагүй хатуу үнэн уул уурхайн салбар дунд болон урт хугацаанд манай улсын эдийн засгийг жолоодсон хэвээр байх нь. Хэдий эрсдэлтэй, үнийн мөчлөгт байнга автаж байдаг. Түүнчлэн гаднын хөрөнгө оруулалтаас шууд хамааралтай ч Монголын эдийн засаг уул уурхайгаас авах зүйлээ аваагүй байгаа учраас хүссэн хүсээгүй тус салбарын оролцоо чухал. Хэдий нүүрсний орлого тасарч, хөрөнгө оруулалт дайжсан ч гэлээ уул уурхайн нөлөөг салгаж ойлгох боломжгүй юм. Үүнийг Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан Монгол Улсын хөгжлийн зураглал баталж байна.


Хөгжлийн зураглалд буй гурван хувилбарын нэг нь уул уурхай. Түүний өсөн нэмэгдэх эрэлт хэрэгцээнд тулгуурлаж хөгжих боломжтойг онцолжээ. Мөн Монголын уул уурхайн салбар хөгжлийнхөө чухал үед ирээд байгааг тус тайланд дурдсан нь бий. Эндээс үзэхэд уул уурхайн салбараас орж ирж буй орлогыг хэрхэн зөв зарцуулахаас хөгжил хэр чанартай байх нь хамаарах аж.

Эдийн засгийн чуулганы салбар хуралдааны нэг нь “Уул уурхайн эрх зүйн орчин ба баялаг бүтээгчид” байсан. Магадгүй уул уурхайн салбарынхан баялаг олборлогчоос гадна баялаг бүтээгч байж болох

юм. Тэд ажлын байр шинээр бий болгож, хамгийн их татвар төлдөг, орон нутгийн хөгжилд зохих хүрээнд анхаардаг гээд авууштай чанар байгаа. Олборлосон бүтээгдэхүүнээ дахин боловсруулах, нэмүү өртөг шингээдэггүй нь тэдний сул тал. Гэвч тус салбар яг одоо хүндээр “өвдчихөөд” байна. Энэ тохиолдолд төсвийн орлого амар бүрдэхгүй л болов уу.

яамнаас танилцуулаад УИХ-д оруулахаар бэлтгэж байна. Дараа нь Газрын хэвлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах юм. Мөн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийг шинээр өргөн барих аж. Эцсийн хэлэлцүүлэгт орохоор хүлээж байгаа нь Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга. Уг шинэчилсэн найруулгыг УИХ хаврын чуулганаар хэлэлцэх ажээ.

Уул уурхайн салбарын нөлөө



Энэ оны төсөвт уул уурхайн салбар дангаар 1.4 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлнэ. Үүний 43 хувийг нүүрс, 27 хувийг зэсийн баяжмал, 13 хувийг алт бүрдүүлэхээр байгаа. Өөрөөр хэлбэл, нэгдсэн төсвийн 12 хувийг уул уурхайн салбар олно. Гэгээтэй мэдээ гэрт нь байхгүй ч салбарын эрх зүйн орчинд нар мандаж буй.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичиг албан ёсных болсон. Энэхүү бодлогод нийцүүлж, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар зэхэж буй. Хуульд орох нэмэлт өөрчлөлтийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд Уул уурхайн

Одоогоор Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Алтны илт тод байдлын тухай хууль батлагдаад байна. Хууль хэрэгжих болсноос хойш Монголбанкинд тушаасан алтны хэмжээг өмнөх онтой харьцуулж үзвэл 2.6 дахин /1.3 тонн/ нэмэгджээ. Нэг үеэ бодвол уул уурхайн салбар дахь эрхзүйн орчин тогтворжиж, тодорхой болж байгааг Монголын экспортлогчдын холбооны тэргүүн Д.Галсандорж онцлон тэмдэглэсэн.

Тогтворгүй хууль эрхзүйн орчин хөрөнгө оруулагчдад халтай болохыг өнөөгийн бодит байдал харуулж буй. Тиймээс Шинэчлэлийн Засгийн газар Уул уурхайн салбарт ▶▶

▶ шаардлагатай гэсэн хууль эрх зүйн орны зохицуулалтыг нааштай байдлаар хийж байгаа нь энэ. Уул уурхайн салбар өмнө нь төрийн зохицуулалтаар явж ирсэн бол энэ байдал халаагаа өгөх бололтой. Хувийн хэвшилд тулгуурласан хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхээр Төрөөс баримтлах бодлогын баримт бичигт тусгажээ. Салбарын цаашдын бодлогыг тодорхойлоход мэргэжлийн холбоог татан оролцуулах болсныг тэрбээр мөн хэлсэн юм.

Богино хугацаанд авч хэрэгжүүлж уул уурхайн салбар дахь бодлогын өөрчлөлт, хуулийн шинэчлэлд салбарынхан ам сайтай байна. Харин дутуу үлдээд байгаа зүйл нь төмөр зам. Цариг тойрсон асуудлыг шийдэхгүйгээр Монгол Улсын уул уурхайн эрдэс бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд хүргэхэд хүнд. Өрсөлдөх чадвараа дээшлүүлэхийн тулд төмөр замаас өөр сонголт байхгүйг Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн тэргүүн Д.Дамба учирласан. Тээврийн асуудлаа шийдсэн тохиолдолд Монгол нүүрс Австралийн нүүрсстэй өрсөлдөх боломжтой аж. Уул уурхайнхан ажилдаа гарах үе ирж байна.

Эрдэс баялгийн салбарт нүүрс голлож буй. Зарим үзүүлэлтээрээ зэсээс ч давж байгаа. Тиймээс нүүрсээ гурван чиглэлээр боловсруулахаар судалж байгааг Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Жигжигд дуулгасан юм. Энэхүү зорилтын хүрээнд шингэрүүлэх, хийжүүлэх, баяжуулах юм байна. Экспортын нүүрсэнд жишиг үнэ тогтоож, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /АМНАТ/ тооцож авдаг тогтолцоог өөрчлөхөөр болсон билээ. Ингэснээр экспортод гаргаж буй нүүрснээс АМНАТ тооцохоор болсныг Уул уурхайн сайд Д.Ганхуяг мэдэгдсэн. Журам нь энэ сараас хэрэгжиж байна. Нүүрсний үнэ хямд, экспорт тааруу байгаагаас үүдэн дээрх шийдвэр гарсан юм. Түүнчлэн нүүрсний экспортыг нэмэгдүүлэхээр хоёр улсын хилийн боомтын хүнд суртлыг багасгасан хэд хэдэн арга хэмжээг авчээ. Тухайлбал, Ганцмод-Гашуунсухайтын боомт цайны завсарлагаагүйгээр 24 цагаар ажиллаж байна. Мөн өдөрт 1500 автомашин нэвтэрч байхаар хилийн автозамыг зохицуулжээ.

Дэлхийн эдийн засгийн форумын гаргасан Дэлхийн орнуудын хөгжлийн цувралд “Монголын хувьд өнөөдөр гарааны цэг болоход тохиромжтой бэлэн өгөгдөл нь уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүнээ боловсруулах. Түүнийг арилжаалахад харьцангуй хялбар” хэмээсэн. Үгүйсгэж

боломгүй уул уурхайн оролцоо эдийн засагт гүн бат сууриа эзэлжээ. Тиймээс өнөөдөр Монгол Улс уул уурхайгаас нүүр бууруулах биш, олборлох, боловсруулах, экспортлох ажлаа түргэсгэх. Ингэснээр олсон мөнгөөрөө эрүүл мэнд, боловсрол, дотоодын үйлдвэрлэл зэрэг бусад салбараа хөгжүүлэх цаг болжээ. ■

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ

ХУВЬСГАЛЫН ТОХИРОО

Э.ТАМИР

Монгол Улс жил бүр ОХУ-аас Эрчим хүч импортолдог. Өнгөрсөн онд гэхэд л хойд хөршөөс 173 мВт эрчим хүч авсан. Энэ нь манай жагсаалтаас гарах дөхсөн хоёр, гуравдугаар станцын үйлдвэрлэдгээс ч илүү хэмжээний эрчим хүч юм. Улаанбаатар хотын дулааны цахилгаан станцуудын нийлбэр хүчин чадал нь эдүгээ 1585 Гкал/цаг. Гэтэл 2010 онд дулааны хэрэгцээ хүчин чадлаа давжээ. Мөн өнгөрсөн онд төвийн бүсийн эрчим хүчний систем цахилгааны оргил ачаалал 875 мВт болж хүчин чадлаасаа мөн л хэтэрсэн тул монголчууд хойд хөршөөсөө бадар барин өвлийг өнтэй давсан. Хэрвээ оросууд үнэд орвол монголчууд яах вэ. Үнэд орсон ороогүй ОХУ-аас манай руу татсан шугам жилд дээд тал нь 173 мВт цахилгаан дамжуулах хүчин чадалтай гэнэ. Тэгэхээр хойд хөршөөс үүнээс илүү эрчим хүч импортлох боломжгүй гэсэн үг. Гэтэл Монголын эрчим хүчний хэрэглээ жилд 10 хувиар өсөөд байдаг.

Манай орны хэтийн хөгжлийн чиг хандлагаар 2020 оны түвшинд оргил ачаалал 1128 мВт-д хүрэх төлөвтэй гэнэ. Энэ хугацаанд ТЭЦ V ашиглалтад орох хэдий ч хурдтай өсөн

нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээг бүрэн хангаж чадахгүй юм. Тэр үед дахиад л Оросоос эсвэл Хятадаас эрчим хүч гуйх уу. Уг нь монголчууд эрчим хүч импортолж биш экспортлох боломжтой. Хэдэн терраваттаар хэмжигдэх сэргээгдэх эрчим хүч, 160 тэрбум тонн нүүрсний нөөцтэй мөртлөө цахилгаан, дулааны хангамж нь хэрэглээний өсөлтийг гүйцэхгүй олон жил болов. “Новатерра” компанийн захирал Б.Бямбасайхан “Улс орны эдийн засаг хурдацтай, тогтвортой хөгжихийн тулд эрчим хүчний салбар түүчээ нь болж хөгжих ёстой” гэв. Гэтэл чирэх нь бүү хэл, хамгийн том чиргүүл нь болж явна. Үүний цаад шалтгаан нь эрчим хүч гэхээр л худлаа ярихаас хэтэрдэггүй, цаасан дээрх урагшгүй бодлого энэ салбарыг дампууруулсан гэх. Гэхдээ шинэчлэлийн гэх тодотголтой Засгийн газар эрчим хүчний салбарыг шинэчилж магадгүй аж. Энэ талаар Эрчим хүчний яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга П.Товуудорж “Эрчим хүчний яамтай болсноос хойш олон ажил хийж байна. Яамны хэрэгжүүлж байгаа бодлогын хүрээнд эдийн засгийн өсөлтийг хангахуйц эрчим хүчний эх үүсвэртэй болж улмаар эрчим хүч импортлогчоос экспортлогч орон руу ▶▶

► шилжих том зорилгыг өмнөө тавиад байна” гэв. Мөн хувийн хэвшлийнхэн энэ салбарт орж ирж байгаа нь сайшаалтай. Тухайлбал, Азийн эрчимийн супер сүлжээ гэх асар том төсөл өдгөө судалгаа шинжилгээний шатандаа явна. Одоогоор Монголын хэд хэдэн газар салхи болон нарны эрчим хүчийг тусгай багийнхан судалж байгаа аж. Харин яамны хийж байгаа зарим ажлаас нь дурдвал гурав, дөрөвдүгээр станцыг өргөтгөх төслийг энэ онд багтаан дуусгах юм байна. Дээрх станцуудыг өргөтгөснөөр 150 мВт цахилгаан эрчим хүч, 200 Гкал/цаг дулааныг төвийн сүлжээнд нийлүүлэх аж. Мөн 300 Гкал/цагийн хүчин чадалтай Амгалангийн дулааны станцыг энэ онд ашиглалтад оруулахаар төлөвлөжээ. Түүнчлэн 450 мВтын хүчин чадалтай ТЭЦV-ыг 2016 онд ашиглалтад оруулснаар монголчууд оросуудаас гуйлга гуйдаг зовлонгоос ангижрах боломжтой. Ер нь эрчим хүчний үйлдвэрлэлийн ирээдүйн төлөвийг харвал олон жил цахилгаанаар ангаж явсан Монгол цахилгаанаар бялуурах бололтой дог оо. Тухайлбал, ЭХЯ-ны төлөвлөгөөгөөр бол ТЭЦ V-ыг оролцуулаад нийтдээ 12 цахилгаан станц барих төсөл удахгүй хэрэгжиж эхлэх гэнэ. Эдгээрийн дунд мөнөөх урт настай удаан жаргалтай Эгийн голын их чадлын

усан цахилгаан станцын төсөл багтсан байх жишээтэй. Үүнийг бүтээн байгуулснаар усан цахилгаан станц гэлтгүй сэргээгдэх эрчим хүчний салбарт томоохон ахиц гарахаар байгаа аж.

Диваажингийн орон

“Новатерра” компанийн захирал Б.Бямбасайханы хэлсэнчлэн Монголыг сэргээгдэх эрчим хүчний диваажин гэж нэрлэж болохоор. Үүнийг батлахын тулд хэдхэн тоо дурдахад л хангалттай. Тухайлбал, 175 тэрбум тонн нүүрсний таамаг нөөц, 205 сая тонн газрын тосны нөөц, 68 мянган тонн ураны нөөцтэй манайх. Мөн нарийн судалгаа бага ч сэргээгдэх эрчим хүчний нөөц ч хангалттай байгаа аж. Тухайлбал, 56.2 тэрбум кВт.цагийн усны, 1200-1400 кВт/метр нарны, 836.8 кВт/цагийн салхины нөөцтэй гэсэн тооцоо байгаа юм. Нүүрс болон ураны баялаг нөөцийн хувьд хязгаарлагдмал бөгөөд хэт их ашиглах нь байгаль орчинд халтай. Харин шавхагдашгүй нөөцтэй сэргээгдэх эрчим хүчийг ашиглах нь ногоон нөөц, ногоон бизнес билээ. Нэг үеэ бодвол Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчийг ашиглах тал дээр нүдэнд харагдаж гарт баригдахуйц хийсэн нэг бус ажлыг дурдахгүй өнгөрч болохгүй. Тухайлбал, “100 000 нарны гэр” үндэсний хөтөлбөрийг

баталсан. Уг хөтөлбөрийг 2000-2012 онд дөрвөн үе шаттайгаар хэрэгжүүлсэнээр орон нутгийн 100146 айл өрхийг нарны цахилгаан үүсгүүрээр хангажээ. Мөн Төв аймгийн Салхит уулын салхин парк өдгөө төвийн бүсийн эрчим хүчний сүлжээнд цэвэр эрчим хүч нийлүүлж байна. Уг салхин парк Монголын сэргээгдэх эрчим хүчний салбарт том итгэл өгсөн. Тийм болоод ч Монголд дахин нэг салхин парkyг босгохоор зэхэж байна. Дорноговь аймгийн Сайншандад баригдах “Сайншанд салхин парк” нэртэй уг төслийн хувьцааны дийлэнхийг Германы “Ферростаал индустриал прожекст” компани эзэмшихээр болсон байна. Тус бүтээн байгуулалтад нийт 120 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд станцыг 2015 онд ашиглалтад оруулахаар төлөвлөжээ. Сайншандын “Салхит” гэх газар босох уг цахилгаан станц ашиглалтад орсноор жилдээ 190 сая кВт/ц цахилгааныг төвийн эрчим хүчний сүлжээнд нийлүүлэх аж. Мөн жилдээ 100 мянга гаруй айл өрхийн цахилгааны хэрэглээтэй тэнцэх цэвэр эрчим хүчийг нэгдсэн сүлжээнд нийлүүлж, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлээс бий болох 200 гаруй тоннтой тэнцэх нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг бууруулна. Түүчлэн хоёр сая шоо метр орчим цэвэр ►



▸ усны зарцуулалт, 50 мянга гаруй тонн нүүрс хэмнэх гэнэ. Цаашдаа ч эрчим хүчний яам сэргээгдэх эрчим хүчийг дэмжихэд бэлэн байгаа аж. Энэ талаар П.Товуудорж “Өнөөдөр манайд сэргээгдэх эрчим хүчний салбарт шийдэх олон асуудал байгаа ч олон улс хөгжлийнхөө гол зорилт болгон тавьж байгаа. Манайх ч тэдний эгнээнд багтсан. Монгол Улс 2007 онд батлагдсан хуулиар сэргээгдэх эрчим хүч татаастай байдаг. Салхины хувьд 8-9.5 цент, нар 15-30, ус 4.5-6 цент гээд хуульчилж зааж өгсөн. Эрчим хүчний зохицуулах хороо гэрээнийх нь загварыг баталж гаргаж өгөх ёстой. Ер нь сэргээгдэх эрчим хүчийг дэмжих хууль эрх зүйн орчин бүрдсэн” гэсэн юм.

Уснаас “гал гаргах” ажиллагаа

Засгийн газар 2000 оноос хойш л Орхон, Эгийн гол, Сэлэнгэ мөрний сав газарт их чадлын усан цахилгаан станц барих талаар ярьсаар ирсэн. Харин энэ бүхэн ажил хэрэг болсон зүйлгүй улстөржөөд дуусдаг уламжлал тогтсон. Эхэн үед нутгийн иргэдийн дунд усан цахилгаан станц барих юм бол өнө эртний түүх домогтой гол мөрөн сүйдэж, тахиж ирсэн лус савдаг нь догширох гэх мэт олон жил бугшсан өрөөсгөл ойлголт энэ талын хөгжилд саад болж байжээ. Харин Тайшир, Дөргөний усан цахилгаан станц ажиллаж, үр ашгаа өгч эхэлснээс хойш иргэдийн ойлголт өөрчлөгдсөн гэж хэлж болох. Сүүлийн үед Сэлэнгэ мөрний сав газарт цуваа усан цахилгаан станц барих талаар идэвхтэй ярьж байна. Энэ удаа том чадлын усан цахилгаан станц барих бидний мөрөөдөл биелж магадгүй гэсэн горьдлого эрчим хүчний салбарынханд бий болжээ.

Тэртээ 1991-1994 онд Техник эдийн засгийн үндэслэл боловсруулж гол ажлаа нугалаад байсан тус төсөл өнөөдрийг хүртэл таг зогссон. Усан цахилгаан станц улс орны эрчим хүчний амь тариа гэдгийг ойлгож мэдсээр байж улс төрийн түвшинд унагаснаас хойш энэ төсөл өндийж босох гэж хоёр ч удаа оролдсон байдаг юм. 2007 онд М.Энхболдын Засгийн газрын үед Хятадын 300 сая ам.долларын зээлээр босгохоор шав тавьж байсан “хөшөө” одоо

Хүснэгт



Эгийн голын хөндийд хэвтэж байна. Шинэчлэлийн засгийн газар урагшилдаггүй усан цахилгаан станцыг барихаар зориг шулуудсан нь олзуурхах зүйл. Манайд усан цахилгаан станц өндийн босох боломж одоо л бүрдсэн гэдгийг салбарынхан онцолж буйг дуулгая. Ингээд галт тэрэг хөдөллөө. Эгийн голын усан цахилгаан станцын төслийн мэргэжилтэн Д.Энхтөр “Эгийн голын станц баригдахгүй өдий хүрсэн нь улс төрийн болон бас бус шалтгаантай. Орон нутгийн ард иргэд энэ талаар дутуу дулимаг ойлголттой байсан. Харин одоо байдал өөр болжээ. Оросууд Байгаль далайгаас гарсан Ангар мөрний дагуу 12000 мВт –ын дөрвөн том станц барьсаны хамгийн бага нь л гэхэд Эгийн голын станцаас гурав дахин том. Хэрвээ байгаль экологид сөрөг нөлөөтэй байсан бол хойд хөрш ийм том хэмжээтэй цувраа усан цахилгаан станц барихгүй. Усан цахилгаан станц зөвхөн эрчим хүч үйлдвэрлэхээс гадна орон нутагт чийглэг уур амьсгал үүсгэдэг, үерийн усыг хяналтад оруулдаг гээд ашигтай зүйл олон. Тиймээс Монголын хоёр дахь Хөвсгөл бий болгоход хамтран зүтгэе” гэв. Олон улсын гэрээгээр тухайн орон өөрийн нутгаар урсган усны 20 хүртэл хувийг ашиглаж болох аж. Биднийг будилж байх хооронд олон улсын хэлцлээр усны бодлогыг өөрчлөөд, ашиглаж болох хувийг багасгавал яах вэ. Том орнууд далан шуудуугаа барьж хангалттай нөөцөлж аваад л хориг тавьчихвал бидний хохь болно. Тиймээс цаг алдаагүй байгаа дээрээ Эгийн голын усыг бизнесийн эргэлтэд оруулсан нь хэн хэндээ ашигтай байх. Одоогоор

төслийн ажил судалгаа, шинжилгээг баталгаажуулах болон бусад бэлтгэл ажлын түвшинд явж байгаа гэсэн. Ирэх жилээс бүтээн байгуулалтын ажил шуударна гэдгийг Д.Энхтөр хэлсэн юм.

Хүн төрөлхтөн 5000 жилийн тэртээ анхны усны далан барьсан бол сүүлийн 45 жилд 48000 ийм далан байгууламж бий болгон үр шимийг нь хүртэж сууна. Турк орон 27 тэрбум ам.долларын есөн том усан байгууламжийн төслөөр 12000 орчим усан сан барьж эргэн тойрон хөдөө аж ахуй, аялал жуулчлалын бүс болгон ажиллаж байна. Зарим улс бохир усаа хуримтлуулан цахилгаан гаргадаг. Гэтэл бид өдий олон жил хоорондоо хэрэлдсээр маш их цэвэр усаа алдаж буй нь үндэсний эмгэнэл юм. Бүр нийт хэрэглээний 85 хувийг газрын гүнээс татаж хэрэглэдэг тогтолцоотой улс дэлхийд ганц Монгол л бий. Эгийн голын усан цахилгаан станцын хүчин чадал 220 мВт. Энэ нь манайдаа том болохоос гаднын аварга станцуудтай харьцуулахад маш жижиг. Монгол орноос урсган гарч байгаа усны нөөцтэй жишиж үзсэн ч энэ бол өчүүхэн үзүүлэлт. Мөн цаана нь дулааны станцын ашигтай ажиллагааг дэмжиж ажилладаг олон сая тонн хүлэмжийн хий бууруулдаг гээд мөнгөөр хэмжигдэхгүй үнэ цэнэ олон бий гэдгийг мэргэжлийн хүмүүс хэлж байна. Товчхондоо ус бол нэг л өдөр нуран унахад бэлэн болсон өнөөгийн эрчим хүчний салбарын гажиг тогтолцоог халах гайхамшигтай бурхны бэлэг юм. Тиймээс энэ бэлгийг тосоод авах уу, тоглуулаад хаях уу монголчуудын л асуудал. ■